





УНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРОО



ГЭМТ ХЭРГИЙН СТАТИСТИК-2018



УЛААНБААТАР
2019 он

ТАНИЛЦУУЛГЫГ БИЧИЖ БОЛОВСРУУЛСАН:

Цэрэнхүүгийн Дулмаа

Статистикч-Эдийн засагч
Эдийн засгийн ухааны магистр
ҮСХ-ны Хүн ам, нийгмийн статистикийн газрын статистикч

ХЯНАН ТОХИОЛДУУЛСАН:

Аюушийн Ариунзаяа

ҮСХ-ны дарга

Чилхаасүрэнгийн Баянчимэг

ҮСХ-ны дэд дарга

Авирмэдийн Амарбал

ҮСХ-ны Хүн ам, нийгмийн статистикийн газрын дарга

Ням-Очирын Должинсүрэн

ҮСХ-ны Хүн ам, нийгмийн статистикийн ахлах статистикч

Санал, хүсэлтээ доорх хаягаар ирүүлнэ үү.

Үндэсний статистикийн хороо

Засгийн газрын III байр

Бага тойруу - 44, Сүхбаатар дүүрэг

Улаанбаатар -11, Монгол Улс

Утас : (976-51)-263966

Факс : (976-11)-324518

Web хуудас : www.nso.mn, www.1212.mn

E-Mail : international@nso.mn; nso_hansg@nso.mn

Үндэсний статистикийн хорооноос эрхлэн гаргав.

Улаанбаатар хот, 2019 он

АГУУЛГА

Товчилсон үгийн тайлбар.....	3
Хуулийн тайлбар.....	4

Бүлэг 1. УДИРТГАЛ ХЭСЭГ

1.1 Үзүүлэлтийн ойлголт, тодорхойлолт.....	10
1.2 Гэмт хэргийн статистикийн үүсэл, хөгжил.....	11
1.3 Гэмт хэргийн статистикийн мэдээлэл цуглуулалт, тархаал.....	12

Бүлэг 2. БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРГИЙН СТАТИСТИК

2.1 Бүртгэгдсэн гэмт хэрэг, гэмт хэргийн ангилал, төрлөөр.....	14
2.2 Бүртгэгдсэн гэмт хэрэг, гэмт хэргийн төрлөөр.....	18
2.3 Бүртгэгдсэн гэмт хэрэг, үйлдэгдсэн байдлаар.....	36
2.4 Бүртгэгдсэн гэмт хэрэг, үйлдэгдсэн гараг, цаг, газраар.....	40
2.5 Гэмт хэрэг үйлдэгч.....	44
2.6 Гэмт хэргийн улмаас хохирсон хүн, хуулийн этгээд.....	48
2.7 Гэмт хэргийн улмаас учирсан хохирол, нөхөн төлүүлэлт.....	60
2.8 Гэмт хэргийн улмаас гэмтсэн, нас барсан хүн.....	62

Бүлэг 3. ШҮҮХЭЭР ШИЙДВЭРЛЭСЭН ХЭРГИЙН СТАТИСТИК

3.1 Анхан шатны шүүхээр шийдвэрлэсэн хэрэг.....	67
3.2 Анхан шатны шүүхээр шийдвэрлэсэн эрүүгийн хэрэг, гэмт хэргийн төрлөөр.....	69
3.3 Шүүхээр ял шийтгүүлсэн хүн.....	71
3.4 Учирсан хохирол, нөхөн төлүүлэлт, хохирогч хүн, хуулийн этгээд.....	76
3.5 Анхан шатны шүүхээр шийдвэрлэсэн иргэний хэрэг.....	78
3.6 Анхан шатны шүүхээр шийдвэрлэсэн захиргааны хэрэг.....	83
3.7 Давж заалдах шатны шүүхээр шийдвэрлэсэн хэрэг.....	84
3.8 Хяналтын шатны шүүхээр шийдвэрлэсэн хэрэг.....	87

Бүлэг 4. УЛС ОРНУУДЫН ГЭМТ ХЭРГИЙН НӨХЦӨЛ, БАЙДЛААС

Дүгнэлт.....	91
Санал, зөвлөмж.....	95

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР:

ҮСХ- Үндэсний статистикийн хороо

ТХЗ – Тогтвортой хөгжлийн зорилт

ХАБТХАЖ- Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журам

ИХШХШ- Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх

ХЗДХЯ- Хууль зүй дотоод хэргийн яам

МУ- Монгол Улс

НҮБ- Нэгдсэн Үндэсний байгууллага

ЭХ- Эрүүгийн хууль

UNODC-United Nations Office on Drugs and crime

АШИГЛАСАН МАТЕРИАЛ**Хууль:**

1. Гэр бүлийн тухай хууль, 1999 он
2. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, 2016 он
3. Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль, 2015 он
4. Захиргааны ерөнхий хууль, 2015 он
5. Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, 2016 он
6. Иргэний хууль, 2002 он
7. Иргэний хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, 2002 он
8. Хөдөлмөрийн тухай хууль, 1999 он
9. Эрүүгийн хууль, 2017 он
10. Эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэх тухай хууль, 2017 он

Мэдээллийн эх үүсвэр:

1. Цагдаагийн ерөнхий газрын бүртгэгдсэн гэмт хэргийн захиргааны болон албан ёсны статистикийн мэдээлэл
2. Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүхээр шийдвэрлэсэн хэргийн захиргааны болон албан ёсны статистикийн мэдээлэл
3. Үндэсний статистикийн хорооны статистикийн мэдээллийн нэгдсэн сан -www.1212.mn цахим хуудас
4. НҮБ-ын Гэмт хэрэг, мансууруулах бодистой тэмцэх газрын <https://www.unodc.org/>, <https://dataunodc.un.org/crime/theft> сайтууд

ХУУЛИЙН ТАЙЛБАР:

Хууль зүйн шинэчлэлийн хүрээнд Монгол Улсын Их хурлаас Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийг 2017 онд шинэчлэн баталснаар өмнө мөрдөгдөж байсан Эрүүгийн хуулийн бүлэг, зүйлийн нэр, томъёо, агуулга болон гэмт хэргийн төрөл, ангиллын хувьд өөрчлөгдсөн. Иймд өмнө мөрдөгдөж байсан Эрүүгийн хуулийн гэмт хэргийн төрлүүдийг шинэ хуулийн гэмт хэргийн төрлүүдтэй дараах байдлаар дүйцүүлэн динамикийг үүсгэн мэдээллийг нийтэд тархааж байна. Өмнөх гэмт хэргийн төрлүүдийг шинэ хуулийн гэмт хэргийн төрлүүдтэй дүйцүүлэхэд ХЗДХЯ-ны Сургагч багш нарт зориулан 2017 онд гаргасан гарын авлагыг үндэс болгосон болно.

МУ-ын Эрүүгийн хууль, 2002 он	МУ-ын Эрүүгийн хууль, 2017 он
Бусдын бие махбодод гэмтэл учруулах гэмт хэрэг	Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг
Хүүхэд гэр бүл, нийгмийн ёс суртахууны эсрэг	Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг
Иргэдийн улс төрийн болон бусад эрх, эрх чөлөөний эсрэг гэмт хэрэг	Хүний хувийн, улс төрийн эрх, эрх чөлөөний эсрэг гэмт хэрэг
Аж ахуйн эсрэг гэмт хэрэг	Эдийн засгийн гэмт хэрэг
Нийгмийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг, Хүн амын эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг	Олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг
Шүүн таслах ажиллагааны эсрэг гэмт хэрэг	Хэрэг шалган шийдвэрлэх ажиллагааны эсрэг гэмт хэрэг
Захиргааны журмын эсрэг гэмт хэрэг	Нийтийн албаны ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг
Байгаль хамгаалах журмын эсрэг гэмт хэрэг	Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг
Компьютерын мэдээллийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг	Цахим мэдээллийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг
Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг	Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг
Албан тушаалын гэмт хэрэг	Авлигын гэмт хэрэг
Завших, үрэгдүүлэх гэмт хэрэг	Хөрөнгө завших гэмт хэрэг



36 220

Бүртгэгдсэн гэмт хэрэг-Бүгд
Recorded crimes-Total



12 551

Шүүхээр шийдвэрлэгдсэн эрүүгийн хэрэг
Resolved criminal case by Court



Гэмт хэргийн улмаас / Caused of crime



Хохирсон хүн
Victims

33 566



14 053



Нас барсан хүн
Died persons

934



524



Гэмтсэн хүн
Injured persons

9 283



8 217



Бүртгэгдсэн хэргийн улмаас учирсан хохирол, тэрбум төг

193.3

Damage caused by recorded crime, billion togrogs



Нөхөн төлүүлэлт, тэрбум төг

32.4

Restituted damage, billion togrogs



Шүүхээр шийдвэрлэсэн эрүүгийн хэргийн улмаас учирсан хохирол, тэрбум төг

40.0

Damage caused resolved criminal case by Court, billion togrogs



Нөхөн төлүүлэлт, тэрбум төг

22.3

Restituted damage, billion togrogs

Шүүхээр ял шийтгүүлсэн хүн / Persons convicted by court



Бүгд / Total

12 088



Эмэгтэй / Female

1 344



Өсвөр насны хүн
Teenager

295



НЭГДҮГЭЭР БҮЛЭГ УДИРТГАЛ ХЭСЭГ



БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ, 2018 оны байдлаар

- ☐ Бүртгэгдсэн 10 гэмт хэрэг тутмын
 - 7 нь нийслэлд, 3 нь аймаг, орон нутагт
 - 1 нь согтуугаар үйлдэгдсэн хэрэг
 - 1 нь эмэгтэйчүүд оролцсон хэрэг
 - 8 нь хөнгөн гэмт хэрэг
 - 2 нь хүнд гэмт хэрэг

- ☐ Бүртгэгдсэн 10 гэмт хэрэг тутмын
 - 6 нь өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг
 - 3 нь хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг байна.
- ☐ Өмчлөх эрхийн эсрэг 10 гэмт хэрэг тутмын
 - 5 нь хулгайлах
 - 2 нь залилах
- ☐ Хулгайлах 10 хэрэг тутмын
 - 8 нь нийслэлд
 - 2 нь орон нутагт


- ☐ Нийслэлд бүртгэгдсэн хулгайлах 10 хэрэг тутмын
 - 3 нь Баянзүрх дүүрэгт
 - 2 нь Сүхбаатар дүүрэгт
 - 2 нь Баянгол дүүрэгт
- ☐ Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг 10 хэрэг тутмын
 - 9 нь хүний эрүүл мэндэд хөнгөн хохирол учруулах
 - 6 нь нийслэлд
- ☐ Нийслэлд бүртгэгдсэн хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг 10 хэрэг тутмын
 - 3 нь Баянзүрх дүүрэгт
 - 2 нь Сонгинохайрхан дүүрэгт
 - 2 нь Баянгол дүүрэгт

- ☐ Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг 10 хэрэг тутмын
 - 8 нь хүчиндэх гэмт хэрэг
 - 5 нь нийслэлд
 - 5 нь орон нутагт
- ☐ Бүртгэгдсэн 10 гэмт хэрэг тутмын
 - 8 нь ажлын өдрөөр
 - 2 нь амралтын өдрөөр
 - 3 нь 21-05 цагийн хооронд үйлдэгдсэн байна.

- ☐ Бүртгэгдсэн 10 хэрэг тутмын
 - 3 нь гэр, орон сууцанд
 - 2 нь гудамж, талбайд
 - 1 нь олон нийтийн газарт үйлдэгджээ.
- ☐ Гэр орон сууцанд үйлдэгдсэн 10 хэрэг тутмын
 - 7 нь нийслэлд
 - 3 нь орон нутагт

- ☐ Яллагдсан 10 хүн тутмын

- 6 нь ажилгүй иргэд
- 3 нь 14-24 насны залуучууд
- 4 нь 25-34 насны залуучууд
- 5 нь бүрэн дунд боловсролтой
- 1 нь эмэгтэй
- 3 нь согтуугаар үйлдсэн
- Гэмт хэрэгт холбогдсон 100 яллагдагч тутмын 8 нь өмнө нь ял эдэлж байсан хүн байна.


 Гэмт хэргийн улмаас Монгол Улсын 10000 хүн тутмын

2017 онд


- 119 хүн хохирсны 58 нь эмэгтэй, 6 нь 18 хүртэлх насны хүүхэд

2018 онд


- 105 хүн хохирсны 48 нь эмэгтэй, 5 нь 18 хүртэлх насны хүүхэд

 Гэмт хэргийн улмаас хохирсон 10 хүн тутмын

- 2 нь 0-24 насны залуус
- 6 нь эрэгтэйчүүд
- 3 ажилгүй иргэд байна.

 Гэр бүлийн хүчирхийллийн улмаас хохирсон 10 хүн тутмын

- 7 нь бие махбодын хүчирхийлэлд өртсөн
- 2 нь хамгаалалтанд хамрагдсан
- 5 нь гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгчийн эхнэр байна.


 Гэмт хэргийн улмаас хохирсон 100 хүн тутмын

2017 онд


- 3 нь нас барсан
- 28 нь гэмтсэн хүн байна.

2018 онд


- 3 нь нас барсан
- 28 нь гэмтсэн хүн байна.

 Гэмт хэргийн улмаас нас барсан 10 хүн тутмын

- 3 нь Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэргийн улмаас
- 3 нь эмэгтэй хүн

 Гэмт хэргийн улмаас гэмтсэн 10 хүн тутмын

- 6 нь Хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэргийн улмаас
- 4 нь Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг

 Гэмтсэн 100 хүн тутмын

- 6 нь хүнд гэмтэл
- 14 нь хүндэвтэр гэмтэл
- 80 нь хөнгөн гэмтэл авсан байна.

ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮДИЙН ӨСӨЛТ, БУУРАЛТ, ОНООР

Үзүүлэлтүүд	нэгж	2017 он	2018 он	Өөрчлөлт
Бүртгэгдсэн гэмт хэрэг	тоо	32 259	36 220	↑
хөнгөн	тоо	20 120	28 095	↑
хүндэвтэр	тоо	5 146	-	↓
хүнд	тоо	6 747	8 125	↑
онц хүнд	тоо	246	-	↓
Үндэсний аюулгүй байдлын эсрэг	тоо	34	99	↑
Хүний амьд явах эрхийн эсрэг	тоо	721	714	↓
Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг	тоо	8 812	9 134	↑
Хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийн эсрэг	тоо	71	115	↑
Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг	тоо	573	621	↑
Хүний хувийн, улс төрийн эрх, эрх чөлөөний эсрэг	тоо	29	6	↓
Өмчлөх эрхийн эсрэг	тоо	18 176	22 468	↑
Эдийн засгийн гэмт хэрэг	тоо	287	242	↓
Олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг	тоо	1 069	314	↓
Хүрээлэн байгаа орчны эсрэг	тоо	330	366	↑
Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг	тоо	1 525	1 231	↓
Хэрэг шалган шийдвэрлэх ажиллагааны эсрэг	тоо	125	196	↑
Авлигын гэмт хэрэг	тоо	150	362	↑
Нийтийн албаны ашиг сонирхлын эсрэг	тоо	262	237	↓
Цэргийн албаны эсрэг	тоо	5	15	↑
Эрүүл мэндийн эсрэг	тоо	31	33	↑
Хүүхдийн эсрэг	тоо	15	21	↑
Соёлын өвийн эсрэг	тоо	-	3	↑
Хохирогч хүн	тоо	37 173	33 566	↓
Нас барсан хүн	тоо	1 129	934	↓
Гэмтсэн хүн	тоо	10 513	9 283	↓
Хохирсон хуулийн этгээд	тоо	86	57	↓
Учирсан хохирол	тэрбум.төг	198.1	193.3	↓
Нөхөн төлүүлэлт	тэрбум.төг	74.5	32.4	↓
Шүүхээр шийдвэрлэсэн эрүүгийн хэрэг-бүгд	тоо	11 152	12 363	↑
Шүүхээр ял шийтгүүлсэн хүн	тоо	9 019	12 088	↑
Шүүхээр шийдвэрлүүлсэн хөдөлмөрийн маргаан	тоо	2 214	1 785	↓
Ажлаас буруу шилжүүлсэн	тоо	53	31	↓
Ажлаас үндэслэлгүй халагдсан	тоо	1 432	943	↓
Цалин хөлсний маргаан	тоо	565	637	↑
Шүүхийн шийдвэрийн дагуу нөхөн төлүүлсэн хохирол				
Эрүүгийн хэрэг	сая.төг	48 772.6	21 155.0	↓
Иргэний хэрэг	сая.төг	240 841.6	263 038.1	↑
Захиргааны хэрэг	сая.төг	942.4	883.7	↓
Бусад хэргийн шийдвэртэй	сая.төг	4 383.5	218 459.5	↑
Авлигын хэргийн шийдвэрлэлт				
Эрүү үүсгэсэн хэрэг	тоо	159	224	↑
Эрүүгийн хэргийн сэжигтэн	тоо	185	352	↑
Учирсан хохирол	сая.төг	69 546.0	663 214.0	↑
Нөхөн төлүүлэлт	сая.төг	3 412.0	17 470.8	↑

1.1 ҮЗҮҮЛЭЛТИЙН ОЙЛГОЛТ, ТОДОРХОЙЛОЛТ

Хүн: Монголын Улсын иргэн, гадаадын иргэн, харьяалалгүй хүнийг ойлгоно.

Хуулийн этгээд: Өмчлөлдөө буюу эзэмшиж, ашиглах, захиран зарцуулах эрхдээ тусгайлсан хөрөнгөтэй, өөрийн нэрээр эрх олж, үүрэг хүлээдэг, үйл ажиллагаанаасаа бий болох үр дагаврыг эд хөрөнгөөрөө хариуцдаг, нэхэмжлэгч, хариуцагч байж чадах, тодорхой зорилго бүхий, тогтвортой үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллагуудыг ойлгоно.

Эрүүгийн хариуцлага хүлээлгэх нас: Монгол Улсын Эрүүгийн хуулийн 6.2.1-т хуульчилснаар гэмт хэрэг үйлдэх үедээ 16 насанд хүрсэн хүнд эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ. Харин МУ-ын ЭХ-ийн 6.2.2-т зааснаар 14-16 насны хүн энэ хуулийн тусгай ангийн 10.1(Хүнийг алах), 11.1(Хүний эрүүл мэндэд хүнд хохирол санаатайгаар учруулах), 12.1(Хүчиндэх), 17.1(Хулгайлах), 17.2(Дээрэмдэх), 17.8(Эд хөрөнгө устгах, гэмтээх), 20.7(Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар ашиглах), 20.16(Олон нийтийн амгалан тайван байдал алдагдуулах), 26.1(Цахим мэдээлэлд хууль бусаар халдах), 26.2(Цахим мэдээллийн сүлжээнд хууль бусаар халдах, программ, техник хэрэгсэл бэлтгэх, борлуулах), 26.3(Хор хөнөөлт программ хангамж бүтээх, ашиглах, тараах), 29.8(Террор үйлдэх) гэмт хэрэг үйлдсэн тохиолдолд эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ.

Эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаа: Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулах, түүнд прокурор хяналт тавих, яллагдагчийг шүүхэд шилжүүлэх, эрүүгийн хэргийг анхан шатны, давж заалдах, хяналтын журмаар хянан шийдвэрлэх ажиллагааг ойлгоно.

Гэмт хэрэг: Монгол Улсын Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан нийгэмд аюултай гэм буруутай үйлдэл, эс үйлдэхүйг ойлгоно.

16, түүнээс дээш насны 10000 хүнд ногдох гэмт хэргийн түвшин: 16, түүнээс дээш насны 10000 хүнд ногдох бүртгэгдсэн (шүүхээр шийдвэрлэсэн) гэмт хэргийн тоог гаргахдаа нийт бүртгэгдсэн (шүүхээр шийдвэрлэсэн) гэмт хэргийн тоог 16, түүнээс дээш насны хүн амын жилийн дундаж тоонд харьцуулж, 10000-аар үржүүлж тооцно.

Гэмт хэргийн хохирогч: Монгол Улсын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасны дагуу гэмт хэргийн улмаас амь нас, эрүүл мэнд, бусад эрх, эрх чөлөө, эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус хохирол хүлээсэн хүн, хуулийн этгээдийг ойлгоно.

Гэмт хэргийн улмаас учирсан хохирол: Монгол Улсын Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан гэмт хэргийн улмаас хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгө, бусад эрх, эрх чөлөө, нийтийн болон үндэсний ашиг сонирхол, аюулгүй байдалд шууд учирсан үр дагаврыг гэмт хэргийн хохирол гэж ойлгоно.

Хохирлын нөхөн төлбөр: Хохирлын нөхөн төлүүлэлт нь өргөн утгаараа хүний эрх, эрх чөлөөний хэр хэмжээ, учруулсан хор уршигт дүйцэхүйц байх ёстой бөгөөд хохирогчийн эрх, эрх чөлөө, хувийн байдал, гэр бүл, эд хөрөнгө, хөдөлмөр эрхлэлт, сургууль, боловсролын түвшинг аль болох өмнө байсан хэмжээнд нь сэргээхийг ойлгоно.

Яллагдагч: Монгол Улсын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасны дагуу эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах тогтоолтой танилцсан гэмт хэрэгт холбогдогчийг ойлгоно.

Гэмт хэргийн илрүүлэлт: Хэрэг бүртгэлд бүртгэгдсэн нийт хэргээс мөрдөн байцаалтын явцад гэмт этгээдийг нь тогтоосон хэргийн түвшнээр тодорхойлогдоно.

Ял: МУ-ын Эрүүгийн хуулийн 5.2-т хуульчилсан торгох, нийтэд тустай ажил хийлгэх, зорчих эрхийг хязгаарлах, хорих, эрх хасах ялыг ойлгоно.

Зам тээврийн осол: Зам дээр тээврийн хэрэгслийн хөдөлгөөнөөс үүдэн хүний амь, нас, эрүүл мэнд хохирох, тээврийн хэрэгсэл болон зам, замын байгууламж эвдэрч, гэмтэх, ачаа болон бусад эд хөрөнгийн хохирол учрахыг ойлгоно.

Хөдөлмөрийн маргаан: Хөдөлмөрлөх эрх түүнтэй холбогдсон хууль ёсны ашиг сонирхлын хүрээнд ажиллагч болон ажил олгогчдын хооронд үүссэн саналын зөрүүг ойлгоно.

Хүчирхийлэл: Хэн нэг этгээд зорилгодоо хүрэхийн тулд эрх мэдлээ тогтоох зорилгоор бусдад албадлага, хүч хэрэглэх, дарамтлах үйлдлийг ойлгоно.

Эс үйлдэхүй. Иргэн, хуулийн этгээдээс эрх, хууль ёсны ашиг сонирхлоо хэрэгжүүлэх, хамгаалуулахаар гаргасан гомдлыг хянан шийдвэрлэх үүргээ захиргааны байгууллага, албан тушаалтнаас хуульд заасан хугацаанд биелүүлээгүй буюу шийдвэрлээгүй орхигдуулсныг ойлгоно.

1.2 ГЭМТ ХЭРГИЙН СТАТИСТИКИЙН ҮҮСЭЛ, ХӨГЖЛӨӨС

НҮБ-ын Гэмт хэрэг, мансууруулах бодистой тэмцэх газар 1950 онд байгуулагдсанаар гэмт хэргийн статистикийн мэдээллийг олон улсын түвшинд цуглуулж эхэлсэн байна.

1933 онд батлагдсан “Цагдаагийн байгууллагын тухай” хуулийн 4 дүгээр зүйлд Цагдаагийн төв байгууллагын харьяанд гэмт хэрэгтэй тэмцэх, нийгмийн хэв журам хамгаалах асуудлаар шинжилгээ, судалгаа явуулах үүрэг бүхий байгууллага байж болно, мөн хуулийн 28 дугаар зүйлд “Цагдаагийн байгууллага гэмт хэрэгтэй тэмцэх, нийгмийн хэв журам хамгаалах үйл ажиллагаанд туслах тоо бүртгэл хөтөлж, мэдээллийн сүлжээ, сан байгуулж, ашиглана” гэж заасан нь өнөөгийн Мэдээлэл дүн шинжилгээ, шуурхай удирдлагын албаны эрх зүйн үндсийг бүрдүүлж өгсөн түүхтэй.

Манай улсад гэмт хэргийн статистикийн мэдээлэл 1980-аад оноос улам өргөжин мэдээллийн технологийн дэвшилтэт арга технологийг ашиглах болж, улмаар гэмт хэргийн салбарын мэдээллийн санг бүрдүүлж эхэлсэн.

1993 онд батлагдсан “Шүүхийн тухай” хуулийн 55 дугаар зүйлд “Улсын Дээд шүүхийн дэргэд шүүхээс хууль хэрэглэх, тайлбарлахад хууль зүйн онолын асуудлаар зөвлөмж өгөх, шүүхийн статистикийн тоо мэдээлэл, практикийг нэгтгэн дүгнэж, санал гаргах үүрэг бүхий шүүхийн судалгааны төв ажиллана” гэж заасны дагуу Шүүхийн судалгаа, мэдээллийн төв байгуулагдан ажилласнаар, Монгол Улсад шүүхийн статистикийн үндэс суурь тавигдсан түүхтэй.


Олон улсын түвшинд гэмт хэргийн статистикийг хоёр эх үүсвэрээс бүрддэг гэж үздэг. Үүнд:

1. Гэмт хэрэг, шүүн таслах ажиллагааны албан болон захиргааны статистикийн мэдээлэл
2. Гэмт хэргийн хохирогчийн судалгаа

Манай орны хувьд гэмт хэргийн статистикийн мэдээллийн эх үүсвэр нь одоогоор Цагдаагийн ерөнхий газрын бүртгэгдсэн гэмт хэргийн сар бүрийн мэдээ, Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүхийн статистикийн жилийн мэдээ, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын жилийн мэдээ, Авлигатай тэмцэх газрын жилийн мэдээ, Хуульчдын холбооны жилийн мэдээ байна. Эдгээр мэдээллийн эх үүсвэрт үндэслэж гэмт хэрэг, гэмт хэрэгт холбогдсон яллагдагч, хохирогч, учирсан хохирол, нөхөн төлүүлэлт, шүүхээр ял шийтгүүлсэн хүний тоо, шүүхээр шийдвэрлэгдсэн хөдөлмөрийн маргаан, шүүхийн шийдвэрийн дагуу нөхөн төлүүлсэн хохирлын хэмжээ, авлигын

хэргийн шийдвэрлэлт, хуульчдын тоо зэрэг үзүүлэлтийг сар, улирал, жилийн бюллетень, танилцуулга, эмхэтгэлд тусган нийтэд тархааж байна. Мөн хууль сахиулах, шүүх эрх мэдлийн байгууллагуудын гэмт хэрэг, хууль зүйн статистикийн гол үзүүлэлтүүдэд үндэслэн салбарын танилцуулга бичин дэлгэрэнгүй мэдээллийг жил бүр нийтэд тархааж, ҮСХ-ны статистикийн мэдээллийн нэгдсэн сан www.1212.mn сайтаар тархааж байна.

1.3 ГЭМТ ХЭРГИЙН СТАТИСТИКИЙН МЭДЭЭЛЭЛ ЦУГЛУУЛАЛТ, ТАРХААЛТ





ХОЁРДУГААР БҮЛЭГ


БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРГИЙН СТАТИСТИК




2.1 БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ, ангилал, гэмт хэргийн төрлөөр

Улсын хэмжээгээр 2018 онд 36.2 мянган гэмт хэрэг бүртгэгдсэн нь 1995 оноос 15724 (76.7%), 2000 оноос 12757 (54.4%), 2005 оноос 18809 (2.1 дахин), 2010 оноос 16395 (82.7%), 2017 оноос 3961 (12.3%)-ээр өссөн байна (Зураг 2.1.1). Өмнөх оноос нийт гэмт хэрэг өсөхөд залилах гэмт хэрэг 2376 (79.3%), хулгайлах гэмт хэрэг 1202 (9.8%), хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг 322 (3.7%), дээрэмдэх гэмт хэрэг 264 (21.4%), хөрөнгө завших гэмт хэрэг 193 (52.3%), хүчиндэх гэмт хэрэг 143 (38.0%)-аар өссөн нь голлон нөлөөлөв.

Зураг 2.1.1 Бүртгэгдсэн гэмт хэрэг, 1995-2018 он



Зураг 2.1.2 Бүртгэгдсэн гэмт хэрэг, сүүлийн 23 жилд




Сүүлийн 23 жилийн хугацаанд 2005 онд гэмт хэрэг хамгийн бага бүртгэгдсэн бол 2018 онд хамгийн олон хэрэг бүртгэгдсэн байна (Зураг 2.1.2). Бүртгэгдсэн нийт гэмт хэргийн 77.6 хувийг хөнгөн, 22.4 хувийг хүнд хэрэг эзэлж, өмнөх оноос хөнгөн хэрэг 15.2 пункт, хүнд хэрэг 1.5 пунктээр нэмэгджээ (Хүснэгт 2.1.1). Өмнөх оноос хөнгөн, хүнд хэргийн эзлэх хувь өссөн нь Монгол Улсын Эрүүгийн хууль шинэчлэгдэн батлагдаж, хуучин Эрүүгийн хуульд гэмт хэргийг хүнд, хөнгөн, хүндэвтэр, онц хүнд гэж ангилдаг байсныг өөрчилж хөнгөн, хүнд гэж ангилдаг болсонтой холбоотой өөрчлөлт юм.

Хүснэгт 2.1.1 Бүртгэгдсэн гэмт хэрэг, ангиллаар, 2009-2018 он

Үзүүлэлт	2009	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2018
Бүртгэгдсэн гэмт хэрэг	20 373	19 825	19 197	22 089	25 362	27 318	27 757	27 167	32 259	36 220
гэмт хэргийн ангиллаар										
Хөнгөн	7 857	8 151	7 977	9 637	11 648	13 057	13 487	13 519	20 120	28 095
Хүндэвтэр	10 006	9 219	8 889	10 041	11 514	11 951	12 127	11 767	5 146	-
Хүнд	2 126	2 014	1 823	1 914	1 766	1 781	1 628	1 393	6 747	8 125
Онц хүнд	384	441	508	497	434	529	515	488	246	-

Зураг 2.1.3 Бүртгэгдсэн гэмт хэрэг, бүсээр, нийслэлээр, хувиар, 2017-2018 он



Улсын хэмжээгээр 2018 онд бүртгэгдсэн нийт гэмт хэргийн 10.4 хувь нь Төвийн бүсэд, 10.2 хувь нь Хангайн бүсэд, 4.0 хувь нь Баруун бүсэд, 4.4 хувь нь Зүүн бүсэд, 70.8 хувь нь нийслэлд, 0.2 хувь нь хилийн чанадад бүртгэгджээ (Зураг 2.1.3).


Хүснэгт 2.1.2 Бүртгэгдсэн гэмт хэрэг, хэргийн төрлөөр, 2009-2018 он

д/д	Гэмт хэргийн төрөл	Бүртгэгдсэн гэмт хэрэг									
		2009	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2018
1	Хүний амьд явах эрхийн эсрэг	1 038	992	624	609	592	565	404	443	721	714
2	Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг	5 770	5 821	5 838	6 546	7 564	8 132	8 064	8 248	8 812	9 134
3	Хүний халдашгүй чөлөөтэй байх эрхийн эсрэг	27	35	26	46	55	49	57	44	71	115
4	Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг	375	410	434	405	425	397	383	384	573	621
5	Хүний хувийн, улс төрийн эрх, эрх чөлөөний эсрэг	59	63	72	126	124	144	141	116	29	6
6	Өмчлөх эрхийн эсрэг	8 853	7 944	7 232	9 023	11 118	12 551	13 445	13 336	18 176	22 468
7	Үндэсний аюулгүй байдлын эсрэг	161	118	96	138	54	45	10	36	34	99
8	Эдийн засгийн гэмт хэрэг	194	158	115	185	234	426	520	227	287	242
9	Олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг	1 745	2 012	2 134	2 044	2 212	2 053	1 971	1 895	1 069	314
10	Хүрээлэн байгаа орчны эсрэг	318	231	270	410	337	287	228	165	330	366
11	Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг	1 390	1 639	1 870	1 999	2 148	2 143	2 010	1 783	1 525	1 231
12	Нийтийн албаны ашиг сонирхлын эсрэг	223	228	280	332	278	249	269	268	262	237
13	Хэрэг шалган шийдвэрлэх ажиллагааны эсрэг	102	57	96	100	104	118	106	91	125	196
14	Авлигын гэмт хэрэг	99	101	101	110	106	135	128	111	150	362
15	Цэргийн албаны эсрэг	18	13	9	16	10	11	12	10	5	15
16	Цахим мэдээллийн аюулгүй байдлын эсрэг	1	3	-	-	1	13	9	10	44	42
17	Эрүүл мэндийн эсрэг	-	-	-	-	-	-	-	-	31	33
18	Хүүхдийн эсрэг	-	-	-	-	-	-	-	-	15	21
19	Хүн төрөлхтний аюулгүй байдал, энх тайвны эсрэг	-	-	-	-	-	-	-	-	-	1
Улсын дүн		20 373	19 825	19 197	22 089	25 362	27 318	27 757	27 167	32 259	36 220

Бүртгэгдсэн 36.2 мянган гэмт хэргийн 22.5 (62.0%) мянга нь Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг, 9.1 (25.2%) мянга нь Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг, 1.2 (3.4%) мянга нь Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг байна (Хүснэгт 2.1.2).


Бүртгэгдсэн гэмт хэргийг тухайн сараар авч үзэхэд 2018 оны 10 дугаар сард 4563 хэрэг бүртгэгдсэн нь хамгийн их, 2017 оны 6 дугаар сард 1919 хэрэг бүртгэгдсэн нь хамгийн бага байна. Харин жил бүрийн 2 дугаар сард гэмт хэрэг буурч, 3 дугаар сард хэрэг өссөн хандлагатай байна (Зураг 2.1.4).

Зураг 2.1.4 Бүртгэгдсэн гэмт хэрэг, сараар, 2014-2018 он



Улсын дунджаар 16, түүнээс дээш насны 10000 хүн тутамд 2018 онд 169 бүртгэгдсэн гэмт хэрэг ногдож байгаа бол шүүхээр шийдвэрлэсэн эрүүгийн хэрэг 59 ногдож байна. Улаанбаатар хотод 16, түүнээс дээш насны 10000 хүнд ногдох гэмт хэрэг улсын дунжаас 94 (55.6%)-өөр их байна. Улаанбаатар хотод 2018 онд 25.7 мянган гэмт хэрэг бүртгэгдсэний 6.7 (25.9%) мянган хэрэгт нь эрүүгийн хэрэг үүсгэж, шүүхээр шийдвэрлэсэн байна.


Зураг 2.1.5 16, түүнээс дээш насны 10000 хүнд ногдох гэмт хэрэг, 2018 он



2.2 БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ, гэмт хэргийн төрлөөр

Бүртгэгдсэн гэмт хэргийг төрлөөр нь авч үзвэл 2018 онд нийт гэмт хэрэгт өмчлөх эрхийн эсрэг гэмт хэргийн эзлэх хувь 62.0 болж өмнөх оноос 5.7 пунктээр, авлигын гэмт хэргийн эзлэх хувь 1.0 болж, 0.5 пунктээр өсөж, харин хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн эзлэх хувь 25.2 болж, 2.1 пунктээр, хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэргийн эзлэх хувь 3.4 болж, 1.3 пунктээр, хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэргийн эзлэх хувь 2.0 болж, 0.2 пунктээр, Олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг гэмт хэргийн эзлэх хувь 0.9 болж, 2.4 пунктээр тус тус буурсан байна (Зураг 2.2.1).

Зураг 2.2.1 Бүртгэгдсэн гэмт хэрэг, төрлөөр, дүнд эзлэх хувиар, 2017-2018 он



Хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг


Хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг 2018 онд 714 бүртгэгдсэн нь өмнөх оноос 7 (1.0%)-гоор буурчээ. Хүнийг санаатайгаар алах хэрэг өмнөх оноос 0.7 пункт, хүний амь насыг болгоомжгүйгээр хохироох хэрэг 1.2 пунктээр, амиа хорлосон хэрэг 2.1 пунктээр өсөж, харин хүнийг амиа хорлох

нөхцөл байдалд хүргэх хэрэг 0.9 пункт, золгүй явдлаар нас барсан хэрэг 2.1 пунктээр буурсан байна (Хүснэгт 2.2.1).

Хүснэгт 2.2.1 Хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг, 2009-2018 он

Үзүүлэлт	2009	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2018
Хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг	1 038	992	624	609	592	565	404	443	721	714
Хүнийг санаатай алах	223	230	262	231	204	211	204	174	189	192
Хүний амь насыг болгоомжгүйгээр хохироох	16	15	21	14	21	27	32	24	45	53
Хүнийг амиа хорлох нөхцөл байдалд хүргэх	764	727	314	324	323	288	144	206	470	459
Амиа хорлосон	-	119	51	46	48	43	24	26	36	45
Золгүй явдлаар нас барсан	-	608	263	278	275	245	120	180	434	414
Бусад	35	20	27	40	44	39	24	39	17	10
Дүнд харьцуулсан хувь										
Хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0
Хүнийг санаатай алах	21.5	23.2	42.0	37.9	34.5	37.3	50.5	39.3	26.2	26.9
Хүний амь насыг болгоомжгүйгээр хохироох	1.5	1.5	3.4	2.3	3.5	4.8	7.9	5.4	6.2	7.4
Хүнийг амиа хорлох нөхцөл байдалд хүргэх	73.6	73.3	50.3	53.2	54.6	51.0	35.6	46.5	65.2	64.3
Амиа хорлосон	-	16.4	16.2	14.2	14.9	14.9	16.7	12.6	7.7	9.8
Золгүй явдлаар нас барсан	-	83.6	83.8	85.8	85.1	85.1	83.3	87.4	92.3	90.2
Бусад	3.4	2.0	4.3	6.6	7.4	6.9	5.9	8.8	2.4	1.4

Зураг 2.2.2 Хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг ба хүнийг санаатай алах гэмт хэрэг, 2009-2018 он




Амиа хорлосон хэрэг 2018 онд 45 болж өмнөх оноос 9 (25.0%)-өөр нэмэгдэж, харин золгүй явдлаар нас барах хэрэг 414 болж, 20 (4.6%)-оор буурсан байна (Зураг 2.2.3).

Зураг 2.2.3 Амиа хорлосон болон золгүй явдлаар нас барсан хэрэг, 2010-2018 он




Хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэргийн 60.6 хувь нь Улаанбаатар хотод бүртгэгдсэн бөгөөд Төв (52), Хөвсгөл (30), Дорнод (29), Сэлэнгэ (27), Дархан-Уул (17), Өвөрхангай (17), Булган (14) аймгуудад энэ төрлийн гэмт хэргийн гаралт бусад аймгийнхаас их байна. 2018 онд бүртгэгдсэн нийт хүнийг санаатай алах гэмт хэргийн 110 (57.3%) нь Улаанбаатар хотод гарсан бөгөөд 30 (27.3%) нь Сонгинохайрхан дүүрэгт, 22 (20.2%) Баянзүрх дүүрэгт, 19 (17.3%) нь Чингэлтэй дүүрэгт, 14 (12.7%) нь Баянгол дүүрэгт, 14 (12.7%) Сүхбаатар дүүргийнх байна (Зурагт 2.2.4).

Зураг 2.2.4 Хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг, дүүргээр, 2018 он



Зураг 2.2.5 Хүнийг санаатай алах гэмт хэрэг, 1995-2018 он




Улаанбаатар хотод 2018 онд бүртгэгдсэн хүний амьд явах эрхийн эсрэг 433 гэмт хэргийн 104 нь Баянзүрх, 103 нь Сонгинохайрхан, 64 нь Баянгол, 57 нь Сүхбаатар дүүргүүдэд бүртгэгджээ. Эндээс харахад аймгуудад бүртгэгдсэн хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэгтэй харьцуулахад дүүрэгт энэ төрлийн хэргийн гаралт харьцангуй өндөр байна (Зураг 2.2.4).

Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг


Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг 2018 онд 9134 бүртгэгдсэн нь өмнөх оноос 322 (3.7%)-оор өсжээ Зураг 2.2.6).

Зураг 2.2.6 Бүртгэгдсэн гэмт хэрэг ба Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг, 2009-2018 он



2018 онд улсын хэмжээгээр гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх 210 гэмт хэрэг бүртгэгдсэний 188 (89.5%)-д нь хэрэг бүртгэлийн хэрэг нээж, 140 (67.7%)-д нь эрүүгийн хэрэг үүсгэжээ. Энэ төрлийн гэмт хэргийн илрүүлэлт 2018 онд 74.5 % болж өмнөх оноос 25.5 пунктээр өссөн байна. Улсын хэмжээнд бүртгэгдсэн 210 гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргийн 105 (50%) нь Улаанбаатар хотод бүртгэгдсэн нь өмнөх оноос 47 (30.9%)-гоор буурсан байна (Зураг 2.2.7). Улсын хэмжээгээр 2018 онд 210 гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оноос 13 (5.8%)-аар буурсан байна.

Зураг 2.2.7 Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэг, 2017-2018 он



Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг

Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэргийн тоо 2018 онд 22468 бүртгэгдэж, өмнөх оноос 4292 (23.6%)-оор өсөхөд энэ төрлийн гэмт хэргийн 59.7 хувийг эзэлж буй хулгайлах хэрэг 1202 (9.8%)-оор, залилах гэмт хэрэг 2376 (79.3%)-аар, дээрэмдэх гэмт хэрэг 264 (21.4%)-өөр, хөрөнгө завших гэмт хэрэг 193 (52.3%)-аар, мал хулгайлах гэмт хэрэг 195 (21.6%)-аар өссөн нь голлон нөлөөлжээ.

Хүснэгт 2.2.2 Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг, 2009-2018 он

Гэмт хэргийн төрлөөр	2009	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2018
Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг	8 853	7 944	7 232	9 023	11 118	12 551	13 445	13 336	18 176	22 468
Хулгайлах	6 376	5 777	5 276	6 266	7 884	8 424	9 169	9 065	12 222	13 424
Дээрэмдэх	754	520	536	552	620	686	537	474	1 233	1 497
Залилах	801	764	688	1 098	1 231	1 843	2 067	2 165	2 996	5 372
Хөрөнгө завших	348	337	202	269	326	297	333	322	369	562
Мал хулгайлах	1294	1070	1169	1376	1435	1434	1180	805	901	1096

Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэргийн бүрэлдэхүүнд ордог хулгайлах гэмт хэрэг 2018 онд өмнөх оноос 7.5 пункт, дээрэмдэх хэрэг 0.1 пунктээр, мал хулгайлах гэмт хэрэг 0.1 пунктээр буурч, харин залилах гэмт хэрэг 7.4 пунктээр, хөрөнгө завших хэрэг 0.5 пунктээр өссөн байна (Хүснэгт 2.2.2.).

Зураг 2.2.8 Бүртгэгдсэн гэмт хэрэг ба Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг, 2009-2018 он



Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг 2009 онд нийт бүртгэгдсэн гэмт хэргийн 43.5%-ийг, 2013 онд 43.8%-ийг, 2015 онд 48.4%-ийг эзэлж байсан бол 2017 онд 56.3%-ийг, 2018 онд 62.0%-ийг эзэлж сүүлийн 2 жилд эрс өссөн байна (Зураг 2.2.8).


Зураг 2.2.9 Хулгайлах гэмт хэрэг, 2009-2018 он



Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэргийн бүрэлдэхүүнд зонхилдог хулгайлах гэмт хэрэг 2009 онд өмчлөх эрхийн эсрэг гэмт хэргийн 72.0 %-ийг, 2013 онд 70.9%-ийг, 2015 онд 68.2%-ийг, 2017 онд 64.8%-ийг эзэлж байсан бол 2018 онд 59.7%-ийг эзэлж, дүнд эзлэх хувь нь тасралтгүй буурсан байна (Зураг 2.2.9).

2018 онд хулгайлах гэмт хэрэг Хөвсгөл (301), Орхон (297), Өвөрхангай (224), Дархан-Уул (213) Баянхонгор (206) аймгуудад хамгийн их гарсан бол Говьсүмбэр (34), Говь-Алтай (49) аймгуудад хамгийн бага бүртгэгдсэн байна (Зураг 2.2.10).


Зураг 2.2.10 Хулгайлах гэмт хэрэг ба илрүүлэлтийн хувь, аймгаар, 2018 он



Тайлбар: Хулгайлах гэмт хэргийн дүнд мал хулгайлах гэмт хэргийн тоо ороогүй болно.

2018 онд улсын хэмжээгээр бүртгэгдсэн нийт хулгайлах гэмт хэргийн 9539 (77.4%) нь Улаанбаатар хотод бүртгэгдсэн бөгөөд энэ хэргийн илрүүлэлт 15.3 хувьтай байна. Хулгайлах гэмт хэргийн илрүүлэлтийн хувь өмнөх оноос 4.1 пунктээр буурсан байна.

Зураг 2.2.11 Хулгайлах гэмт хэрэг хамгийн олон бүртгэгдсэн аймгууд, 2018 он




Мал хулгайлах гэмт хэрэг 1096 бүртгэгдсэн нь өмнөх оноос 195 (21.6%)-аар өсөхөд Хэнтий (51), Дорнод (42), Сүхбаатар (41), Хөвсгөл (35)-аар өссөн нь голлон нөлөөлжээ(Зураг 2.2.12).

Зураг 2.2.12 Мал хулгайлах гэмт хэрэг, 2009-2018 он




2018 онд мал хулгайлах гэмт хэрэг Хэнтий (120), Төв (114), Хөвсгөл (106), Дорнод (101) аймгуудад хамгийн их гарсан бол Орхон (7), Говьсүмбэр (7), Өмнөговь (8) аймгуудад хамгийн бага бүртгэгдсэн байна (Зураг 2.2.13).

Зураг 2.2.13 Мал хулгайлах гэмт хэргийн гаралт ихтэй аймгууд, 2018 он



Авто тээврийн хэрэгсэл хулгайлах гэмт хэрэг 431 бүртгэгдсэн нь нийт бүртгэгдсэн хэргийн 1.2 хувийг эзэлж, өмнөх оноос 62 (16.8 %)-оор өссөн байна. Энэ төрлийн гэмт хэргийн илрүүлэлт улсын хэмжээнд 37.8 хувь болж, өмнөх оноос 1.2 пунктээр буурсан байна (Зураг 2.2.14).

Зураг 2.2.14 Авто тээврийн хэрэгсэл хулгайлах гэмт хэрэг, 2009-2018 он




Авто тээврийн хэрэгслийн хулгай 2018 онд 2009 оноос 4.5 дахин, 2014 оноос 73.1%, 2017 оноос 16.8 %-иар нэмэгдсэн байна. Халаасны хулгай 2018 онд улсын хэмжээгээр 1276 бүртгэгдсэн нь өмнөх оноос 421 (49.2%)-ээр өссөн байна. Улсын хэмжээнд бүртгэгдсэн 1276 халаасны хулгайн 1269 (99.5%) нь Улаанбаатар хотод бүртгэгдсэн байна. Халаасны хулгайн гэмт хэрэг өмнөх оноос нийслэлд өсөхөд Баянзүрх (2.1 дахин), Баянгол (1.8 дахин), Сүхбаатар (1.2 дахин) өссөн нь голлон нөлөөлжээ. Залилах гэмт хэрэг 2018 онд 5372 бүртгэгдэж, өмнөх оноос 2376 (79.3%)-гаар, хөрөнгө завших хэрэг 562 бүртгэгдсэн нь өмнөх оноос 193 (52.3%)-аар нэмэгджээ (Зураг 2.2.15).

Зураг 2.2.15 Залилах, хөрөнгө завших гэмт хэргийн тоо, 2009-2018 он



Дээрэмдэх гэмт хэрэг 2018 онд 1497 бүртгэгдсэн нь өмнөх оноос 264 (21.4%)–өөр өссөн байна. Сүүлийн 24 жилийн хугацаанд дээрэмдэх хэрэг 2018 онд хамгийн их гарсан байна.


Зураг 2.2.16 Бусдын эд хөрөнгийг дээрэмдэх хэрэг, 1995-2018 он



Олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг

Олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг 2018 онд 314 бүртгэгдсэн нь нийт бүртгэгдсэн гэмт хэргийн 0.9 хувийг эзэлж байгаа бөгөөд өмнөх оноос 755 хэрэг буюу 70.6 хувиар буурчээ.

Зураг 2.2.17 Олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын гэмт хэрэг, 2009-2018 он



Олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг гэмт хэргийн бүрэлдэхүүнд зонхилох байр суурийг эзэлдэг мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар ашиглах гэмт хэрэг 2018 онд улсын хэмжээгээр 195-д хүрч, өмнөх оноос 66 (51.2%)–гаар өссөн байна. Улсын хэмжээгээр 2018 онд бүртгэгдсэн мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар ашиглах гэмт хэргийн 150 (76.9 %) нь Улаанбаатар хотод бүртгэгдсэн байна.


Зураг 2.2.18 Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар ашиглах хэрэг, дүүргээр, 2017-2018 он



Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг

Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг 2018 онд 1231 болж, өмнөх оноос 294 (19.3%)-өөр буурсан байна. Энэ төрлийн гэмт хэргийн илрүүлэлт улсын хэмжээнд 70.1 хувь болж өмнөх оноос 4.2 пунктээр өссөн байна.


Зураг 2.2.19 Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг, 2000-2018 он



Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг 2018 онд нийт бүртгэгдсэн гэмт хэргийн 3.4 хувийг эзэлж байгаа нь өмнөх оноос 1.3 пунктээр буурсан байна.


Энэ төрлийн гэмт хэргийн 42.0 хувь нь Улаанбаатар хотод бүртгэгдсэн нь өмнөх оноос 0.8 пунктээр буурсан байна.

Зураг 2.2.20 Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг, 2009-2018 он



Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэргийн 1215 (98.7%)-ыг авто тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих гэмт хэрэг (ХАБТХАЖ), 11 (0.9%)-ийг авто тээврийн гэмт хэрэг үйлдсэн жолооч зугтаах хэрэг эзэлж байна. Авто тээврийн гэмт хэрэг үйлдсэн жолооч зугтаах гэмт хэрэг өмнөх оноос 187 (94.4%)-гоор буурсан байна. Авто тээврийн гэмт хэрэг үйлдсэн жолооч зугтаах гэмт хэрэг 2009-2013 онд тасралтгүй өссөн боловч сүүлийн жилд эрс буурсан байна (Зураг 2.2.20).

Зураг 2.2.21 Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг, аймаг, нийслэлээр, 2018 он



Хүснэгт 2.2.3 Зам тээврийн ослын улмаас нас барсан хүн, 2009-2018 он

Үзүүлэлт	2009	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2018
Гэмт хэргийн улмаас нас барсан хүний тоо	1 358	1 191	922	901	949	1 078	847	880	1 129	934
Зам тээврийн ослын улмаас нас барсан хүний тоо	317	325	363	369	424	503	429	399	392	325
Зам тээврийн ослын улмаас нас барсан хүүхдийн тоо	36	28	40	41	37	48	54	50	55	45
Гэмт хэргийн улмаас гэмтсэн хүний тоо	8 593	7 486	8 100	8 436	9 797	11 281	11 287	11 257	10 513	9 283
Зам тээврийн ослын улмаас гэмтсэн хүний тоо	920	933	1 094	1 078	1 282	1 460	1 382	1 247	1 135	998
Зам тээврийн ослын улмаас гэмтсэн хүүхдийн тоо	538	656	935	183	1 231	1 164	1 089	1 065	1 058	1 004

Гэмт хэргийн улмаас 2018 онд 934 хүн нас барсны 325 (34.8%) нь зам тээврийн ослын улмаас нас барсан нь өмнөх оноос 0.1 пунктээр өссөн байна. Гэмт хэргийн улмаас 2018 онд 9283 хүн гэмтсэний 998 (10.8%) нь зам тээврийн ослын улмаас гэмтжээ.


Зам тээврийн ослын улмаас нас барсан 325 хүний 91 (28.0%) нь Улаанбаатар хотынх байна. Сонгинохайрхан(29), Хан-Уул(15) Баянзүрх(15) Налайх(10) дүүргүүдэд зам тээврийн ослын улмаас хамгийн олон хүн амь насаа алджээ. Харин аймгуудаас Төв(35), Дорноговь(19), Сэлэнгэ(19), Дорнод (17), Өвөрхангай (17) аймгуудад хамгийн олон хүн зам тээврийн ослын улмаас амь насаа алджээ.

Зураг 2.2.22 Гэмт хэргийн улмаас нас барсан хүүхэд ба зам тээврийн ослын улмаас нас барсан хүүхэд, 2009-2018 он



Улсын хэмжээгээр 2018 онд гэмт хэргийн улмаас 934 хүн нас барсны 88 (9.4%) нь хүүхэд байна. Гэмт хэргийн улмаас нас барсан 88 хүүхдийн 45 (51.1%) нь зам тээврийн ослын улмаас амь насаа алджээ. Харин өмнөх оноос гэмт хэргийн улмаас нас барсан хүүхдийн тоо 39 (30.7%)-өөр, зам тээврийн ослын улмаас нас барсан хүүхдийн тоо 10 (18.2%)-аар буурсан байна (Зураг2.2.22).

Зураг 2.2.23 Зам тээврийн ослын улмаас нас барсан түвшин, 10000 хүнд ногдохоор аймаг, нийслэлээр, 2018 он




Цагдаагийн байгууллагад 2018 онд 29454 зам тээврийн осол бүртгэгдсэний 25666 (87.1%) нь Улаанбаатар хотод бүртгэгдсэн зам тээврийн осол байна. 2018 онд 10000 хүнд ногдох зам тээврийн ослын тоо Улаанбаатар хотод 174 байгаа нь улсын дунджаас 82-оор их байна. Улсын хэмжээгээр 2018 онд 10000 хүнд ногдох зам тээврийн ослын улмаас нас барсан түвшин 92 байна (ТХЗ-ын 3.6.1).

Эдийн засгийн гэмт хэрэг

Эдийн засгийн гэмт хэрэг 2018 онд 242 бүртгэгдсэн нь өмнөх оноос 45 (15.7%)-аар буурчээ. Эдийн засгийн гэмт хэрэг улсын хэмжээгээр буурахад Улаанбаатар хотод бүртгэгдсэн эдийн засгийн гэмт хэрэг 17 (8.9%), Дорноговь аймагт 22 (45.8%)—оор буурсан нь голлон нөлөөлжээ.

Зураг 2.2.24 Эдийн засгийн гэмт хэрэг, 2009-2018 он




Улаанбаатар хотод эдийн засгийн гэмт хэрэг өмнөх оноос буурахад Сүхбаатар дүүрэгт 58.5%, Сонгинохайрхан дүүрэгт 39.5 %, Хан-Уул дүүрэгт 17.2%-аар буурсан нь голлон нөлөөлсөн байна.

Авлигын гэмт хэрэг


Авлигын гэмт хэрэг 2018 онд 362 бүртгэгдсэн нь өмнөх оноос 212 (2.4 дахин)-оор өссөн байна. Сүүлийн 23 жилийн хугацаанд авлигын гэмт хэрэг 2006 онд хамгийн цөөн (92), 2018 онд хамгийн олон (362) бүртгэгджээ.

Зураг 2.2.25 Авлигын гэмт хэрэг, 1995-2018 он



Улсын хэмжээгээр 2018 онд эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашиглах гэмт хэрэг 269 бүртгэгдсэн нь нийт бүртгэгдсэн авлигын гэмт хэргийн 74.3%-ийг эзэлж байна. Улаанбаатар хотод бүртгэгдсэн 170 авлигын хэргийн 126 (74.1%) нь эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашиглах гэмт хэрэг байна (Зураг 2.2.26).

Зураг 2.2.26 Эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашиглах гэмт хэрэг, 2018 он



Хээл хахууль авах гэмт хэрэг 58 бүртгэгдсэн нь 2018 онд бүртгэгдсэн нийт авлигын гэмт хэргийн 16.0 %-ийг, харин хээл хахууль өгөх хэрэг 9 бүртгэгдсэн нь нийт бүртгэгдсэн авлигын хэргийн 2.5%-ийг эзэлж байна. Хээл хахууль авах гэмт хэрэг өмнөх оноос 31(2.1 дахин), харин хээл хахууль өгөх хэрэг 4 (80.0%)-өөр тус тус өссөн байна (Зураг 2.2.27).


Зураг 2.2.27 Хээл хахуулын гэмт хэрэг, 2009-2018 он



Хүний халдашгүй чөлөөтэй байх эрхийн эсрэг гэмт хэрэг

2018 онд нийт бүртгэгдсэн гэмт хэргийн 115 буюу 0.3 хувийг Хүний халдашгүй чөлөөтэй байх эрхийн эсрэг гэмт хэрэг эзэлж байгаа бөгөөд өмнөх оноос 44 (62.0%)-өөр өссөн байна.

Зураг 2.2.28 Хүний халдашгүй чөлөөтэй байх эрхийн эсрэг гэмт хэрэг, 2009-2018 он



Хүснэгт 2.2.4 Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч, насны бүлгээр, 2009-2018 он

Он	Улсын дүн	8--13	14-17	18-24	25-29	30-34	35-39
2009	14	-	-	-	13	-	1
2010	3	-	-	2	1	-	-
2011	4	-	-	4	-	-	-
2012	2	-	-	2	-	-	-
2013	13	2	3	2	6	-	-
2014	15	-	2	9	4	-	-
2015	10	-	5	-	4	1	-
2016	5	-	1	4	-	-	-
2017	9	-	1	4	2	2	-
2018	10	-	4	6	-	-	-

Улсын хэмжээгээр 2018 онд хүн худалдаалах гэмт хэрэг 10 бүртгэгдсэн нь хүний халдашгүй чөлөөтэй байх эрхийн эсрэг гэмт хэргийн 8.7%-ийг эзэлж байна. Хүн худалдаалах 10 гэмт хэргийн 7 (70.0%) нь Улаанбаатар хотод бүртгэгдсэн байна. Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийг насны ангиллаар авч үзвэл ихэвчлэн 14-29 насныхан байна (Хүснэгт 2.2.4).


Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг

Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг 2018 онд 621 болж, өмнөх оноос 48 (8.4%)-аар өссөн байна. Энэ төрлийн хэргийн 83.6 хувийг эзэлж байгаа хүчиндэх хэрэг 2018 онд 519 бүртгэгдэж, өмнөх оноос 143 (38.0%)-аар өссөн байна (Хүснэгт 2.2.29).

Зураг 2.2.29 Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг, төрлөөр, 2009-2018 он




Зураг 2.2.30 Хүчиндэх гэмт хэрэг, 1995-2018 он



Хүчиндэх гэмт хэрэг 1995 онд улсын хэмжээгээр бүртгэгдсэн нийт гэмт хэргийн 1.8%, 2000 онд 1.5%, 2005 онд 1.8 %, 2010 онд 1.7%, 2015 онд 1.0% -ийг эзэлж байсан бол 2018 онд 1.4%-ийг эзэлж өмнөх оноос 0.2 пунктээр өссөн байна.

Зураг 2.2.31 Хүчиндэх гэмт хэрэг хамгийн олон гарсан аймгууд, 2018 он




Хүснэгт 2.2.5 Хүчиндэх гэмт хэргийн хохирогч хүүхэд, насны ангиллаар

	2009	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2018
Улсын дүн	147	152	164	135	156	125	139	143	187	238
7 хүртэлх	-	13	11	12	14	10	7	18	20	20
8-13	-	46	46	39	52	42	47	45	59	91
14-17	147	93	107	84	90	73	85	80	108	127

2018 онд хүчиндэх гэмт хэргийн хохирогч болсон 238 хүүхдийн 127 (53.4%) нь 14-17 насны охид, 91(38.2%) 8-13 насны охид, 20(8.4%) нь 7 хүртэлх бага насны охид байна (Хүснэгт 2.2.5).

Зураг 2.2.32 Хүчиндэх гэмт хэргийн хохирогч хүүхэд, дүнд эзлэх хувиар, 2017-2018 он



2018 онд нийт хүчиндэх гэмт хэргийн хохирогч хүүхдийн 53.4%-ийг 14-17 насны хохирогч эзэлж, өмнөх оноос 4.4 пунктээр, 8.4%-ийг 7 хүртэлх насны хохирогч эзэлж, 2.3 пунктээр буурч, харин 8-13 насны хохирогч 38.2%-ийг эзэлж, өмнөх оноос 6.6 пунктээр нэмэгдсэн байна (Зураг 2.2.28).

2.3 БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ, ҮЙЛДЭГДСЭН БАЙДЛААР

Хүснэгт 2.3.1 Бүртгэгдсэн гэмт хэрэг, үйлдэгдсэн байдлаар, 2009-2018 он

Үзүүлэлт	2009	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2018
Согтуугаар үйлдэгдсэн	4 255	4 610	4 312	5 063	6 406	6 686	5 907	5 520	4 012	3 289
Галт зэвсгээр үйлдэгдсэн	49	27	39	41	42	39	38	33	44	39
Гэр бүлийн хүчирхийллийн улмаас	316	284	420	534	418	1 076	1 356	1 449	1 286	1 069
Бүлэглэн гүйцэтгэсэн	2 292	1 960	2 066	2 427	2 447	2 683	2 274	1 635	1 829	1 714
Мансуурсан үедээ үйлдэгдсэн	-	-	-	-	-	-	-	65	92	176
Зохион байгуулалттай бүлгээр үйлдсэн	79	55	40	108	73	52	47	23	15	85


2018 онд үйлдэгдсэн гэмт хэргийн 3289 (9.1%) нь согтуугаар үйлдэгдсэн хэрэг, 176 (0.5%) нь мансуурсан үедээ үйлдсэн хэрэг, 39 (0.1%) нь галт зэвсгээр үйлдэгдсэн хэрэг, 1069 (3.0%) нь гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн хэрэг, 85 (0.2%) нь зохион байгуулалттай гэмт хэрэг, 741(2.0%) нь хүүхэд оролцсон гэмт хэрэг, 2939 (8.1%) нь эмэгтэйчүүд оролцсон хэрэг байна (Хүснэгт 2.3.1). Согтуугаар үйлдэгдсэн гэмт хэрэг 2018 онд 3289 бүртгэгдсэн нь өмнөх оноос 723 (18.0%)-аар буурсан байна (Зураг 2.3.1).

Зураг 2.3.1 Бүртгэгдсэн гэмт хэрэг, үйлдэгдсэн байдлаар, 2009-2018 он




Согтуугаар үйлдэгдсэн гэмт хэрэг өмнөх оноос буурахад Улаанбаатар хот (525), Дорноговь (87), Хөвсгөл(38), Сэлэнгэ (37), Баянхонгор(36) аймгуудад буурсан нь голлон нөлөөлжээ (Зураг 2.3.1).

Зураг 2.3.2 Согтуугаар үйлдэгдсэн хэрэг, 2018 он




Гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн гэмт хэрэг 2018 онд 1069 болж, өмнөх оноос 217-гоор буурахад Улаанбаатар хот (168), Баян-Өлгий (20), Орхон(21), Хэнтий (19), Сүхбаатар (21) аймгуудад буурсан нь голлон нөлөөлөв. Гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн гэмт хэргийн 1069 хэргийн 589 (55.1%) нь Улаанбаатар хотод бүртгэгдсэн байна. Гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн хэрэг дүүргүүдээс Баянзүрх (160), Сонгинохайрхан (118), Баянгол (85)–д хамгийн их бүртгэгджээ.

Зураг 2.3.3 Гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн гэмт хэрэг, 2018 он




2018 онд хүүхэд оролцсон гэмт хэрэг 741 бүртгэгдсэн нь өмнөх оноос 191 (20.5%)-ээр буурсан байна. Хүүхэд оролцсон гэмт хэрэг 1999 онд нийт бүртгэгдсэн гэмт хэргийн 4.9%, 2005 онд 5.1%, 2010 онд 2.3%, 2015 онд 4.1%, 2017 онд 2.9%-ийг эзэлж байсан бол 2018 онд 2.0%-ийг эзэлж байна (Зураг 2.3.4).

Зураг 2.3.4 Хүүхэд оролцсон гэмт хэрэг, 1999-2018 он




Мансуурсан үедээ үйлдэгдсэн хэрэг улсын хэмжээгээр 2018 онд 176 бүртгэгдсэн нь өмнөх оноос 84 (91.3%)-өөр өссөн байна. Мансуурсан үедээ үйлдсэн хэрэг 2018 онд 176 бүртгэгдсэний 151 нь Улаанбаатар хотод бүртгэгдсэн нь 2016 оноос 21 (40.4%), 2017 оноос 78 (2.1 дахин)-аар өссөн байна.

Зураг 2.3.5 Мансуурсан үедээ үйлдсэн хэрэг, дүүргээр, 2016-2018 он




2018 онд улсын хэмжээгээр эмэгтэй хүн оролцсон 2939 хэрэг бүртгэгдсэн нь нийт бүртгэгдсэн гэмт хэргийн 8.1%-ийг эзэлж, өмнөх оноос 137 (4.9%)-гоор өссөн байна. Эмэгтэйчүүд оролцсон 2939 хэргийн 2058 (70.0%) нь Улаанбаатар хотод бүртгэгдсэн байна.

Зураг 2.3.6 Эмэгтэйчүүд оролцсон хэрэг, дүүргээр, 2016-2018 он



2018 онд улсын хэмжээгээр бүртгэгдсэн 36220 хэргийн 1714 (4.7%) нь бүлэглэн гүйцэтгэсэн хэрэг байна. Бүлэглэн гүйцэтгэсэн хэрэг өмнөх оноос 115 (6.3%)-аар буурсан байна. Бүлэглэн гүйцэтгэсэн гэмт хэрэг Улаанбаатар хотод 933 бүртгэгдсэн нь улсын хэмжээнд бүртгэгдсэн бүлэглэн гүйцэтгэсэн хэргийн 54.4%-ийг эзэлж өмнөх оноос 6.3 пунктээр буурсан байна.


Зураг 2.3.7 Бүлэглэн гүйцэтгэсэн хэрэг, аймаг, нийслэлээр, 2018 он




2.4 ГЭМТ ХЭРЭГ ҮЙЛДЭГДСЭН гараг, цаг, газраар

2018 онд бүртгэгдсэн гэмт хэргийн 74.8 хувь нь ажлын өдрүүдэд, 25.2 хувь нь амралтын өдрүүдэд үйлдэгджээ. Нийт гэмт хэргийн 15.8 хувь нь даваа гарагт үйлдэгдсэн бөгөөд үүний 70.5 хувь нь нийслэлд, 29.5 хувь нь аймгуудад бүртгэгдсэн байна. Хэрэг үйлдэгдсэн гарагаар авч үзвэл 8 жилийн туршид Даваа гаригт бусад гарагаас илүү их хэрэг бүртгэгдсэн байна (Зураг 2.4.1).

Зураг 2.4.1 Үйлдэгдсэн гэмт хэрэг гарагаар, дүнд эзлэх хувиар, 2011-2017 он




Зураг 2.4.2 Бүртгэгдсэн гэмт хэрэг, үйлдэгдсэн гарагаар, дүнд эзлэх хувиар, 2018 он




2018 онд улсын хэмжээгээр бүртгэгдсэн гэмт хэргийн 30.5% нь 21-05 цагийн хооронд, 29.8% нь 14-18 цагийн хооронд, 25.2% нь 06-13 цагийн хооронд, 14.5% нь 14-18 цагийн хооронд үйлдэгдсэн байна.

Зураг 2.4.3 Бүртгэгдсэн гэмт хэрэг, үйлдэгдсэн цагаар, 2018 он



Улаанбаатар хотод 2017 онд бүртгэгдсэн нийт гэмт хэргийн 28.4 % нь шөнийн 21 цагаас өглөөний 05 цагийн хооронд, 30.9 % нь 14-18 цагийн хооронд, 26.7 % нь 06-13 цагийн хооронд, 13.9 % нь 18-21 цагийн хооронд үйлдэгдсэн байна. Бүртгэгдсэн гэмт хэргийн 32.2 % нь гэр, орон сууцанд, 21.4 % нь гудамж, талбайд, 13.6% нь олон нийтийн газарт үйлдэгджээ (Зураг 2.4.4).


Зураг 2.4.4 Бүртгэгдсэн гэмт хэрэг, үйлдэгдсэн газраар, хувиар, 2017-2018 он




Гэр, орон сууцанд үйлдэгдсэн хэрэг өмнөх оноос 0.4 пункт, гудамж, талбайд үйлдэгдсэн хэрэг 1.6 пункт, олон нийтийн газар үйлдэгдсэн хэрэг 0.5 пункт, төрийн байгууллагад гарсан хэрэг 0.8 пункт, бусад газар үйлдэгдсэн хэргүүд 0.8 пунктээр өсөж, харин нийтийн тээвэрт үйлдэгдсэн хэрэг 0.1 пункт, төрийн бус байгууллага 0.2 пункт, аж ахуйн нэгж байгууллага 0.1 пункт, авто зам 3.7 пунктээр буурсан байна.

Авто зам дээр гарсан гэмт хэрэг 2018 онд өмнөх оноос 3.7 пунктээр буурахад Улаанбаатар хот (111), Сэлэнгэ (30), Төв (27), Хөвсгөл (23) аймгуудад өмнөх оноос буурсан нь голлон нөлөөлжээ. Авто зам дээр гарсан нийт хэргийн 560 (46.1%) нь Улаанбаатар хотод гарсан нь өмнөх оноос 0.9 пунктээр өссөн байна.

Зураг 2.4.5 Авто зам дээр үйлдэгдсэн хэрэг, дүүргээр, хувиар, 2017-2018 он




Зураг 2.4.6 Авто зам дээр үйлдэгдсэн хэрэг, замын ангиллаар, хувиар, 2017-2018 он



2018 онд авто зам дээр гарсан гэмт хэргийн 45.6 % нь хотын замд, 44.8 % нь орон нутгийн замд, 5.6% нь улсын замд, 1.2% нь олон улсын замд, 2.5% нь аж ахуй нэгж, байгууллагын дотоод зам дээр үйлдэгдсэн байна (Зураг 2.4.6).

Зураг 2.4.7 Авто зам дээр гарсан хэрэг, замын хучилтаар, 2017-2018 он



Авто зам дээр гарсан хэргийг замын хучилтаар авч үзвэл, 922 (75.8 %) нь асфальтан зам дээр, 112 (9.2 %) нь хөрсөн зам дээр, 74 (6.1%) нь сайжруулсан зам дээр гарсан хэрэг байна (Зураг 2.4.7).

2.5 ГЭМТ ХЭРЭГ ҮЙЛДЭГЧ

Яллагдагчдын тоо 2018 онд 16.4 мянгад хүрч, өмнөх оноос 1742 (9.6%)-оор буурсан хэдий ч гэмт хэрэгт холбогдсон 16.4 мянган яллагдагчдын 12.0 мянга (73.8%) нь шүүхээр ял шийтгүүлсэн нь өмнөх оноос 24 пунктээр өссөн байна (Зураг 2.5.1). Өөрөөр хэлбэл 2017 онд нийт яллагдагчдын 49.7 % нь ял шийтгүүлж байсан бол 2018 онд нийт яллагдагчдын 73.8% нь ял шийтгүүлжээ.

Зураг 2.5.1 Яллагдагч ба Шүүхээр ял шийтгүүлсэн хүн, 2009-2018 он




2018 онд гэмт хэрэгт холбогдон яллагдагчаар татагдсан 16.4 мянган яллагдагчийн 2218 (13.5%) нь эмэгтэйчүүд, 956 (5.8%) нь 18 хүртэлх насны хүүхдүүд байна.

Гэмт хэрэгт холбогдсон яллагдагчдын 1267 (7.7%) нь өмнө нь ял шийтгэгдсэн хүмүүс байгаа бөгөөд тэдгээрийн эзлэх хувь 2018 онд өмнөх оноос 5.2 пунктээр өсжээ.

Зураг 2.5.2 Гэмт хэрэгт холбогдсон сэжигтэн холбогдогчид, сүүлийн 10 жилийн байдлаар




Зураг 2.5.3 Гэмт хэрэгт холбогдсон яллагдагчид, насны бүлгээр, хувиар, 2017-2018 он



2018 оны байдлаар гэмт хэрэгт холбогдсон яллагдагчдыг насны бүлгээр авч үзвэл 30-34 насныхан 1.4 пунктээр, 45-49 насныхан 0.7 пунктээр, 40-44 насныхан 0,4 пунктээр өсөж, бусад насны бүлгээр буурсан байна.


Гэмт хэрэгт холбогдсон яллагдагчдад эрхэлсэн тодорхой ажилгүй хүний эзлэх хувь 55.7 болж өмнөх оноос 1.9 пункт, малчдынх 10.2 % болж 0.6 пунктээр, төрийн бус байгууллагынх 1.8 % болж 0.1 пунктээр, хувийн байгууллагад ажиллагчдынх 6.8 % болж 0.2 пунктээр өсөж, харин хувиараа хөдөлмөр эрхлэгчдийнх 15.7 болж 1.8 пунктээр, төрийн албан хаагчийнх 3.2 % болж, 0.6 пунктээр, оюутан, сурагчдынх 5.5 % болж 0.3 пунктээр буурсан байна (Зураг 2.5.4).

Зураг 2.5.4 Гэмт хэрэгт холбогдсон яллагдагч, хөдөлмөр эрхлэлтийн байдлаар, хувиар, 2017-2018 он



Гэмт хэрэгт холбогдсон яллагдагчдыг боловсролын түвшнээр нь авч үзвэл 45.7 %-ийг бүрэн дунд боловсролтой, 19.6%-ийг суурь боловсролтой, 17.5%-ийг дээд боловсролтой, 9.3 хувийг бага боловсролтой, 3.9%-ийг боловсролгүй, 4.0 %-ийг техникийн болон тусгай мэргэжлийн хүмүүс эзэлж байгаа бөгөөд өмнөх оноос бүрэн дунд боловсролтой яллагдагчдын эзлэх хувь 0.9 пункт, боловсролгүй 0.1 пунктээр өсөж, харин дээд боловсролтойнх 0.2 пункт, суурь боловсролтойнх 0.8 пунктээр буурсан байна (Зураг 2.5.5).

Зураг 2.5.5 Гэмт хэрэгт холбогдсон яллагдагч, боловсролын түвшнээр, хувиар, 2017-2018 он



Гэмт хэрэгт холбогдсон яллагдагчдын 28.4 хувь нь согтуугаар, 15.2 хувь нь бүлэглэж, 1.3 хувь нь мансуурсан үедээ, 0.1 % нь галт зэвсгээр, 0.4% нь зохион байгуулалттай гэмт хэрэг үйлдсэн бол 54.6 хувь нь тодорхой бус шалтгааны улмаас гэмт хэрэг үйлджээ.

Гэмт хэрэгт холбогдсон яллагдагчдын 6885(42.0%) нь Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг үйлдэж, өмнөх оноос 3.8 пунктээр, 6936 (42.3%) нь Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг үйлдэж, 2.3 пунктээр өсөж, харин 903 (5.5%) нь ХАБТХАЖ-ын эсрэг гэмт хэрэг үйлдсэн нь өмнөх оноос 1.5 пунктээр буурчээ (Хүснэгт 2.5.1).

Хүснэгт 2.5.1 Гэмт хэрэгт холбогдсон яллагдагч, хэргийн төрлөөр, 2010-2018 он

д/д	Гэмт хэргийн төрөл	Гэмт хэргийн яллагдагч									
		2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2018	
1	Хүний амьд явах эрхийн эсрэг	301	360	335	343	327	316	296	270	266	
2	Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг	6 020	5 970	6 671	7 724	8 365	8 468	8 503	7 267	6 936	
3	Хүний халдашгүй чөлөөтэй байх эрхийн эсрэг	32	23	37	52	57	58	45	30	34	
4	Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг	475	484	451	471	417	446	426	496	392	
5	Хүний хувийн, улс төрийн эрх, эрх чөлөөний эсрэг	59	67	111	120	141	159	127	30	-	
6	Өмчлөх эрхийн эсрэг	7 586	6 115	6 977	8 207	9 233	10 326	9 915	6 926	6 885	
7	Үндэсний аюулгүй байдлын эсрэг	139	98	147	35	11	1	2	17	66	
8	Эдийн засгийн гэмт хэрэг	202	129	185	188	182	186	144	102	58	
9	Олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг	2 265	2 243	2 049	2 298	2 146	2 219	1 997	1 106	329	
10	Хүрээлэн байгаа орчны эсрэг	284	340	418	422	396	304	210	293	307	
11	Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг	1 566	1 738	1 887	2 015	2 048	1 956	1 728	1 273	903	
12	Нийтийн албаны ашиг сонирхлын эсрэг	234	248	284	264	254	278	280	215	119	
13	Хэрэг шалган шийдвэрлэх ажиллагааны эсрэг	67	93	104	95	106	99	90	63	54	
14	Авлигын гэмт хэрэг	132	67	62	42	40	29	19	17	2	
15	Цэргийн албаны эсрэг	13	7	16	10	12	10	13	5	12	
16	Цахим мэдээллийн аюулгүй байдлын эсрэг	3	-	-	-	2	2	10	14	7	
17	Эрүүл мэндийн эсрэг	-	-	-	-	-	-	-	4	10	
18	Хүүхдийн эсрэг	-	-	-	-	-	-	-	3	8	
19	Хүн төрөлхтний аюулгүй байдал, энх тайвны эсрэг	-	-	-	-	-	-	-	-	1	
Улсын дүн		19 378	17 982	19 734	22 286	23 737	24 857	23 805	18 131	16 389	


Эх үүсвэр: Цагдаагийн ерөнхий газрын яллагдагчийн мэдээлэл

2.6 ГЭМТ ХЭРГИЙН УЛМААС ХОХИРСОН ХҮН, ХУУЛИЙН ЭТГЭЭД

Нийгмийн хөгжлийн шалгуур үзүүлэлтүүдийн нэг нь тухайн нийгмийн гишүүд аливаа хууль бус үйл ажиллагаанаас хохирох эрсдэлээс баттай хамгаалагдсан байх явдал юм. Нэг ч хүн хохирохгүй байх нөхцөлийг бүрдүүлсэн улс орны туршлага хаа ч байхгүй бөгөөд байх ч боломжгүй. Гэхдээ л иргэдийг гэмт халдлагаас урьдчилан сэргийлэх бүх талын арга хэмжээг тасралтгүй үр ашигтай явуулах, нэгэнт хохирсон тохиолдолд түүний хөндөгдсөн эрхийг нөхөн сэргээх эрх зүйн тогтолцоо, үйл ажиллагааны зохистой нөхцөлийг цогцоор нь бүрдүүлэх явдал аль ч улс орны хувьд нэн чухал байдаг байна.

Сүүлийн 10 жилд жил тутам дунджаар 25.7 мянган хэрэг Цагдаагийн байгууллагад бүртгэгдэж, 25.8 мянган хүн гэмт хэргийн улмаас хохирчээ. Гэмт хэргийн улмаас 2018 онд 33.6 мянган хүн, 141 байгууллага хохирсон нь өмнөх оноос хохирсон хүний тоо 3607-оор, хохирсон хуулийн этгээдийн тоо 29-өөр буурчээ (Зураг 2.6.1).


Зураг 2.6.1 Бүртгэгдсэн гэмт хэрэг ба хохирогч хүн, мянгаар, 2009-2018 он



Гэмт хэргийн улмаас хохирсон эмэгтэйчүүдийн тоо 2018 онд 14.7 мянга болж, өмнөх оноос 3.5 мянгаар буурсан байна. Хохирсон иргэдийн 56.3 хувь нь эрэгтэйчүүд байгаа нь өмнөх оноос 5.1 пунктээр өссөн байна.

2018 онд гэмт хэргийн улмаас хохирсон хүний 20859 (62.1%) нь Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэргээс, 9148 (27.3%) нь Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэргээс, 1375 (4.1%) нь Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэргийн улмаас хохирсон байна. Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг өмнөх оноос 0.7 пунктээр, Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг 0.5 пунктээр буурч, харин Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг 3.1 пунктээр өсжээ (Хүснэгт 2.6.1).


Зураг 2.6.2 Хохирсон хүний тоо, 2009-2018 он




Хүснэгт 2.6.1 Хохирсон хүн, гэмт хэргийн төрлөөр, 2009-2018 он

д/д	Гэмт хэргийн төрөл	Хохирсон хүн									
		2009	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2018
1	Хүний амьд явах эрхийн эсрэг	1 016	978	589	560	557	546	402	462	769	647
2	Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг	5 932	5 850	5 911	6 607	7 728	8 405	8 423	8 664	8 980	9 148
3	Хүний халдашгүй чөлөөтэй байх эрхийн эсрэг	27	38	23	36	52	62	63	48	56	85
4	Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг	378	395	413	383	408	385	369	377	564	579
5	Хүний хувийн, улс төрийн эрх, эрх чөлөөний эсрэг	62	62	70	116	126	147	137	120	34	6
6	Өмчлөх эрхийн эсрэг	8 490	7 928	7 070	8 838	11 012	12 625	13 509	13 507	23 352	20 859
7	Үндэсний аюулгүй байдлын эсрэг	12	2	1	4	1	8	-	2	1	1
8	Эдийн засгийн гэмт хэрэг	31	51	31	67	95	220	217	143	105	118
9	Олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг	1 797	2 066	2 138	1 969	2 200	2 044	1 993	1 877	984	93
10	Хүрээлэн байгаа орчны эсрэг	58	102	159	284	262	256	237	161	243	305
11	Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг	1 480	1 690	1 950	2 122	2 293	2 439	2 232	1 995	1 728	1 375
12	Нийтийн албаны ашиг сонирхлын эсрэг	173	154	163	234	203	219	248	234	205	173
13	Хэрэг шалган шийдвэрлэх ажиллагааны эсрэг	50	42	57	52	59	81	76	70	77	82
14	Авлигын гэмт хэрэг	25	11	12	8	10	19	27	12	15	8
15	Цэргийн албаны эсрэг	14	9	5	14	9	8	7	9	13	13
16	Цахим мэдээллийн аюулгүй байдлын эсрэг	-	3	-	-	-	11	8	8	11	24
17	Эрүүл мэндийн эсрэг	-	-	-	-	-	-	-	-	-	-
18	Хүүхдийн эсрэг	-	-	-	-	-	-	-	-	-	-
19	Хүн төрөлхтний аюулгүй байдал, энх тайвны эсрэг	-	-	-	-	-	-	-	-	-	-
Улсын дүн		19 545	19 381	18 592	21 294	25 015	27 475	27 948	27 689	37 173	33 566

Зураг 2.6.3 Хохирсон хүн, хүйсээр, 2009-2018 он



Зураг 2.6.4 Гэмт хэргийн улмаас хохирсон хүн, насны бүлгээр, хувиар, 2017-2018 он



2018 онд 18 хүртэлх насны хохирсон хүн өмнөх оноос 0.3 пунктээр, 18-24 насных 1.0 пунктээр, 30-34 насных 0.2 пунктээр өсөж, харин 25-29 насны хохирсон хүн өмнөх оноос 0.1 пункт, 35-39 насны хохирсон хүн 0.1 пункт, 45-49 насны хохирсон хүн 0.2 пункт, 50-54 насны хохирсон хүн 0.7 пункт, 55-59 насны хохирсон хүн 0.2 пункт, 60-64 насны хохирсон хүн 0.1 пункт, 65-69 насны хохирсон хүн 0.2 пунктээр нэмэгдсэн байна.

18 хүртэлх насны гэмт хэргийн нийт хохирогчийн дүнд 7 хүртэлх насны хохирогчдын эзлэх хувь 10.2 болж, өмнөх оноос 2.0 пунктээр, 14-17 насны хохирогчдын эзлэх хувь 59.8 болж, 2.6 пунктээр буурч, харин 8-13 насны хохирогчдын эзлэх хувь, 3.4 пунктээр өссөн байна.

2018 онд гэмт хэргийн улмаас хохирсон нийт хүний 31.4 хувийг ажилгүй хүн эзэлж байгаа нь 2017 оноос 2.3 пунктээр буурчээ. Хохирогч хүний 7.1 хувь нь оюутан, сурагчид, 7.7 хувь нь төрийн албан

хаагчид байгаа нь оюутан, сурагчид өмнөх оноос 0.2 пунктээр өсөж, харин төрийн албан хаагчид 1.3 пунктээр буурсан байна.

Хүснэгт 2.6.2 Гэмт хэргийн улмаас хохирсон хүүхэд, гэмт хэргийн төрлөөр, 2009-2018 он

д/д	Гэмт хэргийн төрөл	Гэмт хэргийн улмаас хохирсон хүүхэд									
		2009	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2018
1	Хүний амьд явах эрхийн эсрэг	78	60	42	36	42	50	46	52	79	47
2	Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг	272	283	333	355	356	403	373	323	430	445
3	Хүний халдашгүй чөлөөтэй байх эрхийн эсрэг	1	-	1	2	6	2	5	3	4	11
4	Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг	170	184	202	196	202	182	189	194	262	312
5	Хүний хувийн, улс төрийн эрх, эрх чөлөөний эсрэг	1	2	5	11	5	4	3	6	3	-
6	Өмчлөх эрхийн эсрэг	204	187	210	269	373	471	414	345	647	660
7	Үндэсний аюулгүй байдлын эсрэг	-	-	-	-	-	-	-	-	-	-
8	Эдийн засгийн гэмт хэрэг	-	4	-	-	7	2	1	-	-	1
9	Олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг	160	162	175	156	187	163	163	145	85	5
10	Хүрээлэн байгаа орчны эсрэг	-	1	-	-	1	-	-	2	2	1
11	Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг	158	181	208	244	246	297	282	268	244	192
12	Нийтийн албаны ашиг сонирхлын эсрэг	-	-	-	-	1	-	-	1	-	1
13	Хэрэг шалган шийдвэрлэх ажиллагааны эсрэг	1	2	2	-	-	2	1	1	1	-
14	Авлигын гэмт хэрэг	-	-	-	-	-	-	-	-	-	-
15	Цэргийн албаны эсрэг	-	-	-	1	-	-	-	-	-	-
16	Цахим мэдээллийн аюулгүй байдлын эсрэг	-	-	-	-	-	-	-	-	-	-
17	Эрүүл мэндийн эсрэг	-	-	-	-	-	-	-	-	1	4
18	Хүүхдийн эсрэг	-	-	-	-	-	-	-	-	-	9
19	Хүн төрөлхтний аюулгүй байдал, энх тайвны эсрэг	-	-	-	-	-	-	-	-	-	-
Улсын дүн		1 045	1 066	1 178	1 270	1 426	1 576	1 477	1 340	1 758	1 688

Эх үүсвэр: Цагдаагийн ерөнхий газрын Бүртгэгдсэн гэмт хэргийн мэдээ

Сүүлийн 10 жилийн байдлаар жилд дунджаар 1382 хүүхэд гэмт хэргийн улмаас хохирсон байна. Хүүхдүүд ихэвчлэн Хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг, Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг, Өмчлөх эрхийн эсрэг, Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг, ХАБТХАЖ-ын эсрэг гэмт хэргийн улмаас хохирдог байна. Хохирогч өөрийн буруугаас болж хохирсон тохиолдол 145 гарсан нь өмнөх оноос 53 (26.8%)-аар буурчээ. Архидан согтуурсны улмаас 253 хүн хохирсон нь өмнөх оноос 39 (18.2%) –өөр өсжээ.

Хүснэгт 2.6.3 Хохирсон хүн, насны бүлгээр, хувиар, 2014-2018 он

Он	Улсын дүн	7		8-13	14-17	18-24	25-29	30-34	35-39	40-44	45-49	50-54	55-59	60-64	65-69	70, түүнээс дээш
		Эмэгтэй	хүртэлх													
2014	27 475	10 902	205	389	982	4297	5008	4115	3533	2896	2236	1726	998	500	285	305
2015	27 948	7 828	201	396	880	3854	5225	4449	3668	3000	2246	1760	1156	532	268	313
2016	27 689	7 996	208	375	757	3693	5061	4552	3660	3048	2366	1748	1108	546	268	299
2017	37 173	14 718	211	462	1084	4159	6173	6153	5002	4235	3296	2683	1850	937	494	434
2018	33 566	14 673	173	506	1009	4104	5545	5650	4482	3815	2929	2178	1597	798	382	398

Эх үүсвэр: Цагдаагийн ерөнхий газрын Бүртгэгдсэн гэмт хэргийн мэдээ

2018 онд гэмт улмаас хохирсон 33.6 мянган хүний 14.7 мянга (43.7%) нь эмэгтэйчүүд, 1688 (5.0%) нь хүүхэд, 5545 (16.5%) нь 25-29 насны хохирогч, 5650(16.8%) нь 30-34 насны хохирогч, 4482 (13.4%) нь 35-39 насны хохирогч, 3815 (11.4%) нь 40-44 насны хохирогч байна. Өмнөх оноос нийт хохирогчийн дүнд эмэгтэйчүүдийн эзлэх хувь 4.1 пунктээр, 30-34 насны хохирогч 0.2 пунктээр өсөж, 25-29 насны хохирогч 0.1 пунктээр, 35-39 насны хохирогч 0.1 пунктээр буурчээ.

Хүснэгт 2.6.4 Хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэргийн хохирогч, хүйс, насны ангиллаар, 2014-2018 он

Он	Улсын дүн	7		8-13	14-17	18-24	25-29	30-34	35-39	40-44	45-49	50-54	55-59	60-64	65-69	70, түүнээс
		Эмэгтэй	хүртэлх													
2014	546	152	37	4	9	46	49	72	80	59	64	54	33	22	7	10
2015	402	112	33	7	6	28	44	39	66	41	43	43	28	11	4	9
2016	462	132	38	6	8	42	39	58	54	55	58	40	30	15	6	13
2017	769	191	45	11	17	52	61	90	82	107	81	87	68	27	20	21
2018	647	167	33	9	5	27	53	67	88	80	90	78	56	26	19	16

2018 онд гэмт хэргийн улмаас хохирсон 33.6 мянган хүний 647 (1.9%) нь хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэргийн хохирогч байна. Хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэргийн 647 хохирогчийн 88 (13.6%) нь 35-39 насных, 80 (12.4%) нь 40-44 насных, 90 (13.9%) нь 45-49 насных, 78 (12.1%) нь 50-54 насных, 56 (8.7%) нь 55-59 насных, 26 (4.0%) нь 60-64 насныхан, 19 (2.9%) нь 65-69 насныхан, 16 (2.5%) нь 70, түүнээс дээш насныхан байна. Хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэргийн хохирогч болсон 47 хүүхдийн 33 (70.2%) нь 7 хүртэлх насны хүүхэд, 5 (10.6%) нь 14-17 насны хүүхэд, 9 (19.1%) нь 8-13 насны хүүхдүүд байна (Хүснэгт2.6.4).

Хүснэгт 2.6.5 Хүнийг санаатай алах гэмт хэргийн хохирогч, хүйс, насны ангиллаар, 2014-2018 он

Он	Улсын дүн	7		8-13	14-17	18-24	25-29	30-34	35-39	40-44	45-49	50-54	55-59	60-64	65-69	70, түүнээс
		Эмэгтэй	хүртэлх													
2014	218	54	6	-	3	20	25	31	31	33	30	19	9	7	2	2
2015	214	51	5	2	2	17	26	25	40	22	24	23	17	3	3	5
2016	184	39	1	-	1	20	14	26	27	25	27	18	13	6	2	4
2017	191	45	6	1	1	14	23	22	29	32	21	21	13	3	1	4
2018	196	45	3	-	-	8	20	26	35	26	25	22	17	5	5	4

2018 онд гэмт хэргийн улмаас хохирсон 33.6 мянган хүний 196 нь санаатай алах гэмт хэргийн хохирогч байгаа нь өмнөх оноос 5-аар буурсан байна. 2018 онд санаатай аллагын гэмт хэргийн хохирогчийн 1.5 хувь нь хүүхэд байгаа нь өмнөх оноос 2.7 пунктээр буурсан байна (Хүснэгт2.6.5).

Хүснэгт 2.6.6 Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн хохирогч, хүйс, насны ангиллаар, 2014-2018 он

Он	Улсын дүн		7 хүртэлх	8-13	14-17	18-24	25-29	30-34	35-39	40-44	45-49	50-54	55-59	60-64	65-69	70, түүнээс
	Эмэгтэй	Эмэгтэй														
2014	385	368	17	52	113	89	42	29	9	10	12	7	-	2	1	2
2015	369	360	17	55	117	81	35	17	15	9	6	7	6	2	1	1
2016	377	367	28	60	106	70	32	28	14	11	12	6	4	1	2	3
2017	564	538	31	76	155	106	56	39	40	23	14	15	3	2	2	2
2018	579	560	21	98	193	123	32	37	25	12	13	12	8	2	-	3

2018 онд гэмт хэргийн улмаас хохирсон 33.6 мянган хүний 579 (1.7%) нь хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн хохирогч байна. Энэ нь өмнөх оноос 0.2 пунктээр буурсан байна.

Хүснэгт 2.6.7 Хүчиндэх хэргийн хохирогч, хүйс, насны ангиллаар, 2014-2018 он

Он	Улсын дүн		7 хүртэлх	8-13	14-17	18-24	25-29	30-34	35-39	40-44	45-49	50-54	55-59	60-64	65-69	70, түүнээс
	Эмэгтэй	Эмэгтэй														
2014	301	297	10	42	73	84	34	22	9	9	9	5	-	2	-	2
2015	287	285	7	47	85	67	28	14	13	7	6	3	6	2	1	1
2016	295	295	18	45	80	58	23	24	11	8	12	6	4	1	2	3
2017	368	356	20	59	108	84	35	17	16	10	7	10	1	1	-	-
2018	487	469	20	91	127	107	32	37	23	12	13	12	8	2	-	3

2018 онд хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн 579 хохирогчийн 487 (84.1%) нь хүчиндэх гэмт хэргийн хохирогч байна. Хүчиндэх гэмт хэргийн 487 хохирогчийн 469 (96.3%) нь эмэгтэйчүүд, 238 (48.9%) нь 18 хүртэлх насны хүүхдүүд байна. 18 хүртэлх насны хүүхдүүдийн 20 (8.4%) нь 7 хүртэлх насны хүүхдүүд, 91 (18.7%) нь 8-13 насны хүүхдүүд, 127 (53.4%) нь 14-17 насны хүүхдүүд байна (Хүснэгт 2.6.7).

Хүснэгт 2.6.8 Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэргийн хохирогч, хүйс, насны ангиллаар, 2014-2018 он

Он	Улсын дүн		7 хүртэлх	8-13	14-17	18-24	25-29	30-34	35-39	40-44	45-49	50-54	55-59	60-64	65-69	70, түүнээс
	Эмэгтэй	Эмэгтэй														
2014	12 625	5 296	1	127	343	1 640	2 159	1 873	1 655	1 501	1 141	920	605	296	182	182
2015	13 509	5 703	1	125	288	1 538	2 361	2 095	1 910	1 617	1 239	980	675	336	159	186
2016	13 507	5 917	1	85	259	1 470	2 300	2 130	1 864	1 660	1 332	1 027	665	346	183	185
2017	23 352	12 770	2	183	462	2 166	3 729	3 820	3 259	2 798	2 270	1 897	1 371	705	373	317
2018	20 859	9 648	4	216	440	2 314	3 324	3 464	2 894	2 484	1 985	1 461	1 118	594	276	285

2018 онд өмчлөх эрхийн эсрэг 22.5 мянган хэрэг бүртгэгдэж, 20.9 мянган хүн хохирсон байна. Энэ төрлийн гэмт хэргийн нийт хохирогчийн 9.6 мянга(46.3%) нь эмэгтэйчүүд, 660 (3.2%) нь хүүхдүүд байна. 2018 онд өмчлөх эрхийн эсрэг 20.9 мянган хохирогчийн 2314 (11.1%) нь 18-24 насныхан, 3324 (15.9%) нь 25-29 насныхан, 3464 (16.6%) 30-34 насныхан, 2894 (13.9%) нь 35-39 насныхан, 2484 (11.9%) нь 40-44 насныхан, 1985(9.5%) нь 45-49 насныхан, 1461 (7.0%) нь 50-54 насныхан, 1118 (5.4%) нь 55-59 насныхан, 594 (2.8%) нь 60-64 насныхан, 276(1.3%) нь 65-69 насныхан, 285 (1.4%) нь 70, түүнээс дээш насныхан байна (Хүснэгт 2.6.8).

Хүснэгт 2.6.9 Хулгайлах гэмт хэргийн хохирогч, хүйс, насны ангиллаар, 2014-2018 он

Он	Улсын дун	Эмэгтэй	7 хүртэлх	8-13	14-17	18-24	25-29	30-34	35-39	40-44	45-49	50-54	55-59	60-64	65-69	70, түүнээс
2015	9 204	3 806	-	29	141	983	1 658	1 398	1 332	1 105	865	684	498	254	122	135
2016	9 174	3 962	-	22	113	966	1 609	1 431	1 254	1 133	872	732	506	273	134	129
2017	11 378	5 245	1	27	163	1 136	1 814	1 854	1 598	1 307	1 154	922	687	347	190	178
2018	11 562	5 712	1	62	229	1 308	1 899	1 952	1 505	1 302	1 087	838	673	377	169	160

2018 онд өмчлөх эрхийн эсрэг гэмт хэргийн 20.9 мянган хохирогчийн 11.6 мянга (55.4%) нь хулгайлах хэргийн хохирогч байна. Хулгайлах гэмт хэргийн хохирогчийн 292 (2.5%) нь хүүхэд, 5.7 мянга (49.4%) нь эмэгтэйчүүд байна.

Хүснэгт 2.6.10 Мал хулгайлах гэмт хэргийн хохирогч, хүйс, насны ангиллаар, 2014-2018 он

Он	Улсын дун	Эмэгтэй	7 хүртэлх	8-13	14-17	18-24	25-29	30-34	35-39	40-44	45-49	50-54	55-59	60-64	65-69	70, түүнээс
2015	1 261	184	-	-	-	16	88	164	200	203	174	135	132	61	40	48
2016	849	109	-	-	-	17	66	111	146	-	104	82	68	49	29	33
2017	935	117	-	-	2	14	67	109	166	151	123	102	80	58	38	25
2018	1 107	167	-	-	-	28	74	122	186	209	147	101	105	60	28	47


Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэргийн 20.9 мянган хохирогчийн 1107 (5.3%) нь мал хулгайлах гэмт хэргийн хохирогч байгаа нь өмнөх оныхоос 172 (18.4%)-оор өссөн байна.

Хүснэгт 2.6.11 Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэргийн хохирогч, хүйс, насны ангиллаар, 2014-2018 он

Он	Улсын дун	Эмэгтэй	7 хүртэлх	8-13	14-17	18-24	25-29	30-34	35-39	40-44	45-49	50-54	55-59	60-64	65-69	70, түүнээс дээш
2015	2 232	847	97	103	82	263	325	298	240	201	166	151	132	63	49	62
2016	1 995	819	94	105	69	243	254	273	203	192	170	142	107	65	28	50
2017	1 728	673	88	84	72	189	208	203	177	164	155	141	105	57	37	48
2018	1 375	592	81	58	53	165	136	147	138	137	126	112	97	49	35	41


2018 онд гэмт хэргийн улмаас хохирсон 33.6 мянган хохирогчийн 1375 (4.1%) нь хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэргийн хохирогч байна. Энэ төрлийн гэмт хэргийн хохирогчийн 192 (14.0%) нь 18 хүртэлх насны хүүхдүүд, 592 (43.1%) нь эмэгтэйчүүд байна. ХАБТХАЖ-ын эсрэг гэмт хэргийн хохирогч өмнөх оноос 353 (20.4%)-аар буурсан байна.

Зураг 2.6.5 Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн аюулгүй байдлын журмын эсрэг гэмт хэргийн хохирогч, насны ангиллаар, 2017-2018 он



2018 онд гэмт хэргийн улмаас хохирсон 33.6 мянган хохирогчийн 43.0% нь бүрэн дунд, 34.9% нь дээд, 11.7% нь суурь, 4.7% нь бага, 4.0% нь техникийн болон тусгай мэргэжлийн, 1.6% нь боловсролгүй хүн байгаа нь өмнөх оноос бүрэн дунд боловсролтой 5.6 пунктээр, суурь боловсролтой 0.2 пунктээр, бага боловсролтой 0.3 пунктээр өсөж, харин дээд боловсролтой 2.0 пунктээр, техникийн болон тусгай мэргэжлийн 0.7 пунктээр, боловсролгүй 3.5 пунктээр буурсан байна (Зураг 2.6.6).

Зураг 2.6.6 Гэмт хэргийн хохирогч, боловсролын түвшнээр, 2017-2018 он



Гэмт хэргийн улмаас хохирсон 33.6 мянган хүний 11730 (34.9%) нь дээд боловсролтой, 1346 (4.0%) нь техникийн болон тусгай мэргэжлийн, 14447 (43.0%) нь бүрэн дунд, 3920 (11.7%) нь суурь боловсролтой, 1575 (4.7%) нь бага боловсролтой, 548 (1.6%) нь боловсролгүй хохирогч байна. Гэмт хэргийн төрөл, боловсролын байдлаар нь авч үзвэл дээд боловсролтой гэмт хэргийн хохирогч болсон 11730 хүний 8417 (71.8%) нь Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэргийн хохирогч, бүрэн дунд боловсролтой 14447 хохирогчийн 8656 (60.0%) нь Өмчлөх эрхийн эрхийн эсрэг гэмт хэргийн хохирогч, суурь боловсролтой 3920 хохирогчийн 2022 (51.6%) нь Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэргийн хохирогч байна (Хүснэгт 2.6.12).


Хүснэгт 2.6.12 Гэмт хэргийн хохирогч, боловсролын түвшинээр, 2018 он

д/д	Гэмт хэргийн төрөл	Улсын дүн	Дээд	Техникийн болон тусгай мэргэжлийн	Бүрэн дунд	Суурь	Бага	Боловсролгүй
1	Хүний амьд явах эрхийн эсрэг	647	61	27	316	147	47	49
2	Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг	9 148	2 296	334	4 501	1 338	518	161
3	Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг	579	58	13	135	152	169	52
4	Хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийн эсрэг	85	41	3	29	6	5	1
5	Хүний хувийн, улс төрийн эрх, эрх чөлөөний эсрэг	6	6	-	-	-	-	-
6	Өмчлөх эрхийн эсрэг	20 859	8 417	885	8 656	2 022	721	158
7	Үндэсний аюулгүй байдлын эсрэг	1	1	-	-	-	-	-
8	Эдийн засгийн гэмт хэрэг	118	85	4	23	3	-	3
9	Олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг	93	36	3	36	12	3	3
10	Хүрээлэн байгаа орчны эсрэг	305	262	13	23	4	-	3
11	Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг	1 375	226	54	657	227	103	108
12	Нийтийн албаны ашиг сонирхлын эсрэг	173	129	8	29	4	1	2
13	Хэрэг шалган шийдвэрлэх ажиллагааны эсрэг	82	62	-	16	2	1	1
14	Авлигын гэмт хэрэг	8	6	-	1	-	1	-
15	Цэргийн албаны эсрэг	13	11	-	2	-	-	-
16	Цахим мэдээллийн аюулгүй байдлын эсрэг	24	19	-	5	-	-	-
17	Эрүүл мэндийн эсрэг	28	8	2	12	1	2	3
18	Хүүхдийн эсрэг	18	4	-	4	2	4	4
19	Соёлын өвийн эсрэг	3	1	-	2	-	-	-
19	Хүн төрөлхтний аюулгүй байдал, энх тайвны эсрэг	1	1	-	-	-	-	-
Улсын дүн		33 566	11 730	1 346	14 447	3 920	1 575	548

Эх үүсвэр: Цагдаагийн ерөнхий газрын хохирогчийн мэдээлэл


Гэмт хэргийн улмаас 2018 онд нийт 57 хуулийн этгээд хохирсон нь өмнөх оноос 29 (33.7%)-өөр буурчээ (Зураг 2.6.7).

Зураг 2.6.7 Хохирсон хуулийн этгээд, 2009-2018 он



Байгууллагын төрлөөр нь авч үзвэл 2018 онд хохирсон байгууллагын 66.7 хувь нь төрийн, 5.3 хувь нь төрийн бус, 28.1 хувь нь хувийн байгууллага байгаа бөгөөд өмнөх оноос төрийн байгууллага 1.6 пунктээр өсөж, харин төрийн бус байгууллага 0.5 пунктээр, хувийн байгууллага 1.0 пунктээр буурсан байна (Зураг 2.6.8).

Зураг 2.6.8 Хохирсон байгууллага, төрлөөр, хувиар, 2009-2018 он



Хүснэгт 2.6.13 Хуулийн этгээд, гэмт хэргийн төрлөөр, 2018 он

Гэмт хэргийн төрлөөр	Хуулийн этгээд				Учирсан хохирол(сая.төг)				Хохирол нөхөн төлүүлэлт(сая.төг)			
	Бүгд	Төрийн	Төрийн бус	Хувийн	Бүгд	Төрийн	Орон нутгийн	Хувийн	Бүгд	Төрийн	Орон нутгийн	Хувийн
Улсын дүн	57	38	3	16	164642.5	20253.9	1698.9	142689.7	18358.8	1061.7	556.8	16740.3
Өмчлөх эрхийн эсрэг	26	9	2	15	130912.4	490.8	593.4	129828.2	16479.7	246.3	10.0	16223.4
Хулгайлах гэмт хэрэг	8	1	1	6	19368.3	57.4	356.7	18954.2	4074.1	0.6	-	4073.5
Залилах гэмт хэрэг	4	-	4	-	103901.0	-	56.4	103844.7	11227.2	-	-	11227.2
Эд хөрөнгө устгах, гэмтээх	2	1	-	1	6929.5	422.3	159.5	6347.7	938.6	125.5	-	813.2
Хөрөнгө завших	12	7	1	4	713.6	11.1	20.9	681.7	239.7	120.2	10.0	109.5
Эдийн засгийн гэмт хэрэг	13	11	1	1	20330.4	19480.4	210.1	639.9	822.5	699.0	42.2	81.3
Татвар төлөхөөс зайлхийх	2	2	-	-	19712.0	19362.0	-	350.0	590.5	590.5	-	-
Улсын хилээр барааг хууль бусаар нэвтрүүлэх	8	8	-	-	235.8	118.4	42.4	75.1	225.7	108.5	42.2	75.1
Мөнгөн тэмдэгт, үнэт цаас, төлбөр тооцооны хэрэгсэл, хуурамчаар бэлтгэх, ашиглах	3	1	1	1	382.5	-	167.7	214.8	6.3	-	-	6.3
Олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг	4	4	-	-	30.3	15.6	-	14.7	30.3	15.6	-	14.7
Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг завших	1	1	-	-	0.5	-	-	0.5	0.5	-	-	0.5
Хууль бусаар эм, бэлдмэл, эмнэлэгийн хэрэгсэл үйлдвэрлэх, импортлох, худалдах, түгээх	3	3	-	-	29.8	15.6	-	14.2	29.8	15.6	-	14.2
Авлигын гэмт хэрэг	3	3	-	-	142.6	22.9	105.0	14.7	-	-	-	-
Эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашиглах	3	3	-	-	142.6104	22.9104	105	14.7	-	-	-	-
Нийтийн албаны ашиг сонирхлын эсрэг	3	3	-	-	11723.4	70.3	-	11653.1	80.1	70.0	-	10.1
Хуурамч баримт бичиг үйлдэх, ашиглах	3	3	-	-	11723.4	70.3	-	11653.1	80.1	70.0	-	10.1
Хүрээлэн байгаа орчны эсрэг	8	8	-	-	1503.4	173.9	790.4	539.1	946.1	30.8	504.7	410.7
Хууль бусаар ашигт малтмал хайх, ашиглах, олборлох	5	5	-	-	676.3	92.4	313.1	270.9	410.3	15.7	188.4	206.2
Хууль бусаар ан агнах	2	2	-	-	177.4	48.1	33.8	95.5	124.9	13.0	28.0	83.9
Хууль бусаар мод бэлтгэх	1	1	-	-	649.6	33.4	443.5	172.7	410.9	2.1	288.3	120.5

2018 онд гэмт хэргийн улмаас учирсан 193.3 тэрбум төгрөгийн нийт хохирлын 164.6 (85.2%) тэрбум төгрөгийн хохирол нь хохирсон 57 хуулийн этгээдэд учирчээ. Гэмт хэргийн улмаас 2018 онд 57 хуулийн этгээдэд учирсан 164.6 тэрбум төгрөгийн хохирлын 26 (45.6%) хуулийн этгээдэд холбогдох нь 130.9 тэрбум төгрөг нь Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэргийн хохирол, 13 (22.8%) хуулийн этгээдэд холбогдох 20.3 тэрбум төгрөг нь Эдийн засгийн гэмт хэргийн хохирол, 4 (7.0%) хуулийн этгээдэд холбогдох 30.3 сая төгрөг нь Олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг гэмт хэргийн хохирол, 3 (5.3%) хуулийн этгээдэд холбогдох 142.6 сая төгрөг нь Авлигын гэмт хэргийн хохирол, 3 (5.3%) хуулийн этгээдэд холбогдох 11.7 тэрбум төгрөг нь Нийтийн албаны ашиг сонирхлын эсрэг гэмт хэргийн хохирол, 8 (14.0%) хуулийн этгээдэд холбогдох 1.5 тэрбум төгрөг нь Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэргийн хохирол байна. Хуулийн этгээдүүдэд гэмт хэргийн улмаас учирсан 164.6 тэрбум төгрөгийн хохирлын 18.4 тэрбум төгрөгийг нөхөн төлүүлсэн бөгөөд 1.0 тэрбум нь төрийн өмчийн, 556.8 сая төгрөг нь орон нутгийн өмчийн, 16.7 тэрбум төгрөг нь хувийн өмчийн хуулийн этгээдэд төлсөн нөхөн төлбөр байна (Хүснэгт 2.6.13).


2.7 ГЭМТ ХЭРГИЙН УЛМААС УЧИРСАН ХОХИРОЛ, НӨХӨН ТӨЛҮҮЛЭЛТ

Гэмт хэргийн улмаас учирсан хохирол 2018 онд 193.3 тэрбум төгрөг, нөхөн төлүүлсэн хохирлын хэмжээ 32.4 тэрбум төгрөг болж, өмнөх оноос учирсан хохирол 4.8 (2.4 %) тэрбум төгрөгөөр, нөхөн төлүүлсэн хохирол 42.1 (56.5 %) тэрбум төгрөгөөр буурсан байна (Зураг 2.7.1).

Зураг 2.7.1 Гэмт хэргийн улмаас учирсан хохирол, нөхөн төлүүлэлт, тэрбум төг, 2009-2018 он



Зураг 2.7.2 Учирсан хохирол, бүсээр, хувиар, 2017-2018 он



Тайлбар: Бусдыг Улаанбаатар хотод оруулсан болно.

2018 онд гэмт хэргийн улмаас учирсан хохирлын 1.9% баруун бүсэд, 4.5% хангайн бүсэд, 6.7% төвийн бүсэд, 2.9% зүүн бүсэд, 84.0 % Улаанбаатар хотод бүртгэгдсэн хэргийн хохирол байгаа бөгөөд өмнөх оноос баруун бүс 0.4 пунктээр, хангайн бүсэд 0.1 пунктээр, зүүн бүсэд 0.1 пунктээр өсөж, харин төвийн бүсэд 0.4 пункт, Улаанбаатар хотод 0.2 пунктээр буурсан байна (Зураг 2.7.2).


Хүснэгт 2.7.1 Учирсан хохирол ба нөхөн төлүүлэлт, нийслэлийн дүүргээр, сая төгрөг, 2014-2018 он

Дүүргийн нэр	Учирсан хохирол. сая төг					Нөхөн төлүүлэлт. сая төг				
	2014	2015	2016	2017	2018	2014	2015	2016	2017	2018
Баянгол	47 162.5	14 863.1	18 572.0	76 576.1	31 893.7	3 284.8	5 390.1	4 912.9	26 069.1	3374.9
Баянзүрх	23 847.4	11 909.2	14 445.5	36 096.8	38 700.6	5 142.9	3 614.7	4 491.6	22 097.2	3 496.6
Сүхбаатар	17 572.7	19 152.6	14 436.1	14 081.0	53 162.0	2 689.1	4 726.9	5 792.3	1 555.7	3 931.0
Сонгино хайрхан	8 358.6	8 067.5	5 544.8	7 848.9	7 506.8	6 386.7	3 384.6	2 649.3	3 304.5	2 271.1
Хан-Уул	7 758.7	6 879.4	4 556.9	15 172.4	9 390.6	3 742.7	5 163.2	2 283.3	3 116.5	2 758.6
Чингэлтэй	11 606.9	24 357.2	58 493.3	15 688.2	20 067.2	3 022.6	2 526.7	3 775.8	1 900.3	2 658.2
Бага нуур	139.5	450.3	279.3	276.1	319.7	96.5	120.4	123.5	160.0	70.1
Бага хангай	97.6	396.9	51.6	44.0	39.7	93.6	384.7	47.0	25.9	33.3
Налайх	1 202.3	1 232.4	795.1	965.3	824.5	871.1	639.7	455.1	440.4	457.2
Нийслэлийн дүн	117 746.2	87 308.5	117 174.6	166 748.6	161 904.9	25 330.0	25 951.0	24 530.7	58 669.6	19 051.1

Улсын хэмжээгээр 2014-2018 онд бүртгэгдсэн гэмт хэргийн улмаас учирсан хохирлын 66.4-86.2 хувь нь Улаанбаатар хотод бүртгэгдсэн хэргийн хохирол байна. 2018 онд улсын хэмжээгээр нийт учирсан хохирлын 161.9 (83.8%) тэрбум төгрөг нь нийслэлд учирсан хохирол эзэлж байгаа нь өмнөх оноос 4.8 (2.9%) тэрбум төгрөгөөр буурсан байна. Нийслэлд гэмт хэргийн улмаас учирсан хохирол өмнөх оноос буурахад Баянгол дүүрэг 44.7 тэрбум төгрөгөөр, Хан-Уул дүүрэгт 5.8 тэрбум төгрөгөөр буурсан нь голлон нөлөөлжээ. Улаанбаатар хотод гэмт хэргийн улмаас учирсан хохирол 2018 онд 161.7 тэрбум төгрөг, нөхөн төлүүлсэн хохирлын хэмжээ 19.1 тэрбум төгрөг болж, өмнөх


оноос учирсан хохирол 4.8 (2.9 %) тэрбум төгрөг, нөхөн төлүүлсэн хохирол 39.6 (67.5%) тэрбум төгрөгөөр буурчээ (Хүснэгт 2.7.1).

Зураг 2.7.3 Хохирлын нөхөн төлүүлэлтийн хувь, нийслэлийн дүүргүүдээр



2.8 ГЭМТ ХЭРГИЙН УЛМААС ГЭМТСЭН, НАС БАРСАН ХҮН

Зураг 2.8.1 Гэмт хэргийн улмаас нас барсан, гэмтсэн хүн, 2009-2018 он




Гэмт хэргийн улмаас 2018 онд 33566 хүн хохирсны 934 (2.8%) нь нас барж, 9283 (27.7%) нь гэмтсэн байна. Хохирсон хүний тоо өмнөх оноос 9.7%, нас барсан хүний тоо 17.3 %, гэмтсэн хүний тоо 11.7%-иар буурчээ.

Хүснэгт 2.8.1 Нас барсан болон гэмтсэн хүн, насны бүлгээр, 2014-2018 он

Насны бүлэг	Нас барсан хүн					Гэмтсэн хүн				
	2014	2015	2016	2017	2018	2014	2015	2016	2017	2018
7 хүртэлх	62	68	76	79	56	127	118	110	103	82
8-13	15	18	16	21	18	196	211	225	197	159
14-17	24	14	20	27	14	494	455	380	445	319
18-24	120	88	87	91	55	2 119	1 889	1 848	1 639	1 392
25-29	129	91	97	93	77	2 226	2 341	2 275	1 963	1 748
30-34	112	97	106	142	96	1 734	1 876	1 945	1 822	1 650
35-39	140	105	95	125	117	1 426	1 352	1 427	1 339	1 213
40-44	116	86	89	138	108	1 072	1 055	1 083	1 055	973
45-49	117	82	105	111	117	762	764	813	753	665
50-54	98	76	67	119	115	554	575	534	543	481
55-59	63	59	54	86	77	267	332	323	330	309
60-64	34	29	31	40	36	138	144	143	162	140
65-69	25	12	12	26	23	72	80	66	88	75
70, түүнээс дээш	23	22	25	31	25	94	95	85	74	77
Улсын дүн	1 078	847	880	1 129	934	11 281	11 287	11 257	10 513	9 283

2018 онд нас барсан хүний 12.5 хувийг 35-39 болон 45-49 насныхан, 11.6 хувийг 40-44 насныхан, 12.3 хувийг 50-54 насныхан эзэлж байна. Нас барсан хүний тоо өмнөх оноос буурахад 18-24 насных 2.2 пункт, 30-34 насныхан 2.3 пункт, 7 хүртэлх насных 1.0 пункт, 40-44 насных 0.7 пунктээр буурсан нь голлон нөлөөлжээ. Нас барсан хүний 268 (28.7%) нь эмэгтэйчүүд, 88 (9.4%) 18 хүртэлх насны хүүхдүүд байна. Нас барсан 934 хүний 91.9 хувь нь 24 цагийн дотор, 7.4 хувь нь 30 хоногийн дотор, 0.7 хувь нь 30-аас дээш хоногт амь насаа алдсан бөгөөд 24 цагийн дотор амь насаа алдсан хүн өмнөх оноос 0.3 пункт, 30-аас дээш хоногт амь насаа алдсан хүн 0.4 пунктээр буурч, харин 30 хоногийн дотор амь насаа алдсан хүн 0.7 пунктээр өссөн байна (Хүснэгт 2.8.1).

Зураг 2.8.2 Гэмт хэргийн улмаас нас барсан хүн, хэргийн төрлөөр, хувиар, 2017-2018 он




Гэмт хэргийн улмаас 2018 онд 934 хүн нас барсны 168 (18.0%) нь хүнийг санаатай алах гэмт хэргийн улмаас, 325 (34.8%) нь хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг, 335(35.9%) нь хүнийг амиа хорлох нөхцөл байдалд хүргэх, 49 (5.2%) нь хүний амь насыг болгоомжгүйгээр хохироох гэмт хэргийн улмаас амь насаа алджээ.

2018 онд гэмт хэргийн улмаас 88 хүүхэд нас барж, өмнөх оноос 39 (30.7%) –өөр, 560 хүүхэд гэмтэж, өмнөх оноос 185 (24.8%-аар буурсан байна.

Гэмтсэн хүний 6103 (65.7%) нь эрэгтэйчүүд, 3180 (34.3%) нь эмэгтэйчүүд, 7.1 хувь нь хүүхдүүд байна. 2018 онд нийт гэмтсэн хүний 15.0%-ийг 18-24 насныхан, 18.8%-ийг 25-29 насныхан, 17.8%-ийг 30-34 насныхан, 13.1%-ийг 35-39 насныхан, 10.5% -ийг 40-44 насныхан зонхилон эзэлж өмнөх оноос 0.6 пунктээр буурч, харин 25-29 насныхан 0.2 пункт, 30-34 насныхан 0.4 пункт, 35-39 насныхан 0.3 пункт, 40-44 насныхан 0.5 пунктээр өссөн байна. Гэмтсэн хүний тоо өмнөх оноос буурахад 14-17 насныхан 0.8 пункт, 18-24 насныхан 0.6 пункт, 8-13 насныхан 0.2 пункт, 7 хүртэлх насныхан 0.1 пунктээр буурсан нь голлон нөлөөлжээ (Хүснэгт 2.8.1).

Зураг 2.9.3 Гэмтсэн хүн, гэмтлийн зэргээр, хувиар, 2017-2018 он



2018 онд гэмт хэргийн улмаас гэмтсэн хүний 80.2 % нь хөнгөн, 13.6 % нь хүндэвтэр, 6.2 % нь хүнд гэмтэл авсан бөгөөд хөнгөн хэлбэрийн гэмтэл авсан хүний тоо 0.8 пунктээр, хүндэвтэр хэлбэрийн гэмтэл авсан хүн 0.2 пунктээр өсөж, харин хүнд хэлбэрийн гэмтэл авсан хүн 1.1 пунктээр буурсан байна (Зураг 2.9.3).

Хүснэгт 2.9.3 Гэмтсэн хүн, хэргийн төрлөөр, 2009-2018 он

Гэмт хэргийн төрлөөр	Гэмтсэн хүн									
	2009	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2018
Улсын дүн	8 593	7 486	8 100	8 436	9 797	11 281	11 287	11 257	10 513	9 283
Хүний амьд явах эрхийн эсрэг	13	24	18	30	32	30	29	16	37	34
Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг	5 466	4 576	4 850	5 341	6 256	7 531	7 683	7 931	8 024	7 957
Хүний халдашгүй чөлөөтэй байх эрхийн эсрэг	6	1	1	1	-	-	2	2	1	2
Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг	192	154	150	121	112	122	105	98	192	97
Хүний хувийн, улс төрийн эрх, эрх чөлөөний эсрэг	35	31	46	58	81	103	103	87	21	-
Өмчлөх эрхийн эсрэг	365	233	265	258	276	295	240	253	230	94
Үндэсний аюулгүй байдлын эсрэг	5	-	-	-	-	-	-	-	-	-
Эдийн засгийн гэмт хэрэг	1	3	2	-	-	-	-	1	-	-
Олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг	1 527	1 480	1 611	1 479	1 685	1 649	1 656	1 551	801	44
Хүрээлэн байгаа орчны эсрэг	1	1	-	1	2	6	-	1	2	-
Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг	920	933	1 094	1 078	1 282	1 460	1 382	1 247	1 135	998
Нийтийн албаны ашиг сонирхлын эсрэг	40	42	55	57	64	71	75	56	55	41
Хэрэг шалган шийдвэрлэх ажиллагааны эсрэг	6	2	4	5	1	8	8	6	6	-
Авлигын гэмт хэрэг	7	-	-	-	-	-	1	1	-	-
Цэргийн албаны эсрэг	9	6	4	7	6	6	3	7	9	4
Цахим мэдээллийн аюулгүй байдлын эсрэг	-	-	-	-	-	-	-	-	-	-
Эрүүл мэндийн эсрэг	-	-	-	-	-	-	-	-	-	10
Хүүхдийн эсрэг	-	-	-	-	-	-	-	-	-	2
Хүн төрөлхтний аюулгүй байдал, энх тайвны эсрэг	-	-	-	-	-	-	-	-	-	-

Эх үүсвэр: Цагдаагийн ерөнхий газрын хохирогчийн мэдээлэл

2018 онд гэмт хэргийн улмаас гэмтсэн 9283 хүний 7957 (85.7%) нь хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэргээс, 998 (10.8%) нь хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэргийн улмаас гэмтсэн байна.

Сүүлийн 10 жилд гэмт хэргийн улмаас 96.0 мянган хүн гэмт хэргийн улмаас гэмтсэний 65.6 (68.3%) мянга нь Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг, 11.5 (12.0%) нь Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэргийн улмаас, 13.5 (14.0%) нь Олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг гэмт хэргээс гэмтэж бэртсэн байна. 2018 онд гэмтсэн хүний тоо буурахад Олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг 757(94.5%)-гоор, ХАБТХАЖ-ын эсрэг гэмт хэрэг 137 (12.1%)–гоор буурсан нь голлон нөлөөлжээ.



ГУРАВДУГААР БҮЛЭГ

ШҮҮХЭЭР ШИЙДВЭРЛЭСЭН ХЭРГИЙН СТАТИСТИК



3.1 АНХАН ШАТНЫ ШҮҮХЭЭР ШИЙДВЭРЛЭСЭН ХЭРЭГ

Монгол Улсын Шүүхийн тухай хуульд заасанчлан Шүүх гэдэг нь Монгол Улсын Үндсэн хуульд заасны дагуу байгуулагдан хэрэг, маргааныг хянан шийдвэрлэж, заавал биелүүлэх шийдвэрийг төрийн нэрийн өмнөөс гаргадаг **шүүгч, шүүх бүрэлдэхүүнийг** ойлгоно.

“Дагнасан шүүх” гэж Эрүү, Иргэн, Захиргааны хэргийг шүүн таслах ажиллагааны төрлөөр дагнан байгуулагдсан шүүхийг ойлгоно. Шүүхийн үндсэн тогтолцоо нь Улсын дээд шүүх /хяналтын шатны шүүх/, аймаг, нийслэлийн шүүх /давж заалдах шатны шүүх/, сум буюу сум дундын, дүүргийн шүүх /анхан шатны шүүх/-ээс бүрдэнэ.


Анхан шатны шүүхээр 2018 онд 12551 эрүүгийн хэрэг, 48155 иргэний хэрэг, 1638 захиргааны хэрэг хянан шийдвэрлэж, 12904 зөрчилд хариуцлага оногдуулсан бөгөөд анхан шатны шүүхээр шийдвэрлэсэн эрүүгийн хэрэг өмнөх оноос 3.7 (42.0%) мянга, иргэний хэрэг 2.9 (6.5%) мянга, захиргааны хэрэг 578 (45.4%), хариуцлага ногдуулсан зөрчил 4.5 (52.7%) мянгаар тус тус өссөн байна Анхан шатны шүүхээр 2018 онд 62.3 мянган хэрэг, 12.9 мянган зөрчил шийдвэрлэсэн нь өмнөх оноос шийдвэрлэсэн хэргийн тоо 1.2 (2.05) мянгаар буурч, харин хариуцлага оногдуулсан зөрчлийн тоо 4.5 (52.7%) мянгаар өссөн байна Хүснэгт(3.1.1).

Хүснэгт 3.1.1 Анхан шатны шүүхээр шийдвэрлэсэн хэрэг, 2011-2018 он

Үзүүлэлт	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2018
Эрүүгийн хэрэг	5877	6161	6169	6375	6756	5 762	8 839	12 551
Иргэний хэрэг	30368	27792	35314	33996	40674	46 173	45 233	48 155
Захиргааны хэрэг	891	961	1106	1187	1439	1 780	1 060	1 638


Улсын хэмжээгээр 2018 онд шүүхээр шийдвэрлэсэн нийт эрүүгийн гэмт хэргийн 7.1 % нь Баруун бүсэд, 14.7 % нь Хангайн бүсэд, 17.8 % нь Төвийн бүсэд, 7.1 % нь Зүүн бүсэд, 53.2 % нь нийслэлийнх байна .

Зураг 3.1.1 16, түүнээс дээш насны 10000 хүнд ногдох шүүхээр шийдвэрлэсэн эрүүгийн хэрэг, аймагаар, 2018 он



16, түүнээс дээш насны 10000 хүнд ногдох эрүүгийн хэрэг 2018 онд Улаанбаатар хотод 68-д хүрсэн нь улсын дунджаас 9 (13.2%) –өөр их байна. Аймгуудаас 16, түүнээс дээш насны 10000 хүнд ногдох эрүүгийн хэрэг Говьсүмбэр(99), Өмнөговь(75), Дорнод(67) байгаа нь хамгийн өндөр бол Говь-Алтай, Баян-Өлгий, Завхан (29) аймагт хамгийн бага байна.

Зураг 3.1.2 Анхан шатны шүүхээр шийдвэрлэсэн хэрэг, оноор, хувиар



Хүснэгт 3.1.2 Анхан шатны шүүхийн эрүүгийн хэрэг, 2009-2018 он

Үзүүлэлт	2009	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2018
Шийдвэрлэвэл зохих хэрэг-бүгд	6 304	6 372	6 776	7 065	7 248	7 603	7 998	7 025	10 412	13 954
Прокурорт буцаасан	482	515	448	472	505	712	736	730	806	771
Харьяаллын дагуу шилжүүлсэн	3	11	13	12	12	23	23	22	47	128
Хянан шийдвэрлэсэн	5 407	5 460	5 877	6 161	6 169	6 375	6 756	5 762	8 839	12 551
Тайлант хугацааны үлдэгдэл	412	386	438	420	562	493	483	511	741	785

Анхан шатны шүүхээр шийдвэрлүүлэхээр 2018 онд 14671 хүнд холбогдох, 13954 эрүүгийн хэрэг хүлээн авсны 12551 хэргийг хянан шийдвэрлэж, 14925 хүнийг гэм буруутайд тооцож, 1191 хүнд холбогдох, 771 хэргийг прокурорт буцааж, 53 хүнд холбогдох 35 хэргийг түдгэлзүүлж, 310 хүнд холбогдох, 133 хэргийг харьяаллын дагуу шилжүүлж, 319 хүнд холбогдох 150 хэргийг хэрэгсэхгүй болгосон байна. Гэмт буруутай нь тогтоогдсон 14925 хүний 2040 (13.7%) хүнийг хорих ял оногдуулахгүйгээр тэнсэж, 52 (0.3%) хүнийг эрүүгийн хариуцлагаас чөлөөлж, 12366 (82.9%) хүний гэмт буруутайг тогтоож ял оногдуулсан байна.

Анхан шатны шүүхээр шийдвэрлүүлэхээр ирсэн эрүүгийн хэрэг 13954 болж, өмнөх оноос 3.5 мянга (34.0%) , харьяаллын дагуу шилжүүлсэн хэрэг 128 болж, 81 (2.7 дахин), хянан шийдвэрлэсэн хэрэг 12551 болж, 3.7 (42.0%) мянгаар өсөж, харин прокурорт буцаасан хэрэг 771 болж, 35(4.3%)-аар

буурсан байна. 2016 онд анхан шатны шүүхээр шийдвэрлэвэл зохих хэргийн 82.0 хувь нь хянан шийдвэрлэгдсэн бол 2017 онд шийдвэрлэвэл зохих 10412 хэргийн 84.9 хувь нь хянан шийдвэрлэгдэж, өмнөх оноос 2.9 пунктээр өссөн байна (Хүснэгт 3.1.2).

2018 онд анхан шатны шүүхээр шийдвэрлэсэн эрүүгийн хэргийн 6673 (53.2%) нь Улаанбаатар хотынх байгаа нь өмнөх оноос 11.1 пунктээр өссөн байна.

Зураг 3.1.3 Анхан шатны шүүхээр шийдвэрлэсэн эрүүгийн хэрэг, 2009-2018 он



Жил тутам анхан шатны шүүхээр шийдвэрлүүлэхээр ирсэн хэргийн 80-90%-ийг шүүхээр шийдвэрлэж, харин үлдсэн хэргүүд шийдвэрлэгдэлгүй үлддэг байна. 2018 онд Анхан шатны шүүхээр шийдвэрлүүлэхээр ирсэн 14.0 мянган хэргийн 12.6 мянга (90.0%) нь хянан шийдвэрлэгдсэн байна. 2018 онд шийдвэрлэвэл зохих хэргийн 90.0%-ийг хянан шийдвэрлэсэн нь өмнөх оноос 5.1 пунктээр өссөн байна (Зураг 3.1.3).

3.2 АНХАН ШАТНЫ ШҮҮХЭЭР ШИЙДВЭРЛЭСЭН ЭРҮҮГИЙН ХЭРЭГ, гэмт хэргийн төрлөөр

Хүснэгт 3.2.1 Бүртгэгдсэн гэмт хэрэг ба Шүүхээр шийдвэрлэсэн эрүүгийн хэрэг, 2011-2018 он

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2018
Бүртгэгдсэн гэмт хэрэг	тоо	19 197	22 089	25 362	27 318	27 757	27 167	32 259	36 220
Шүүхээр шийдвэрлэсэн эрүүгийн хэрэг	тоо	5 877	6 161	6 169	6 375	6 756	5 762	8 839	12 551
	хувь	30.6	27.9	24.3	23.3	24.3	21.2	27.4	34.7

Жил тутам Цагдаагийн байгууллагад бүртгэгдсэн гэмт хэргийн 21.2-34.7 % -д нь шүүхээс гэмт буруутайг нь тогтоож ял шийтгэл ноогдуулдаг байна. Улсын хэмжээгээр 2018 онд 36.2 мянган хэрэг бүртгэгдсэний 12.6 мянган (34.7%) хэрэгт МУ-ын ЭХ-ийн холбогдох зүйл заалтын дагуу Шүүхээс гэм буруутайг нь тогтоож ял шийтгэл оногдуулсан байна. Энэ нь өмнөх онтой харьцуулахад

бүртгэгдсэн хэрэг 3961 (12.3%)-ээр өсөхөд шүүхээр шийдвэрлэсэн эрүүгийн хэрэг 3712 (42.0%)-оор өссөн байна (Хүснэгт 3.2.1).


Анхан шатны шүүхээр 2018 онд шийдвэрлэсэн 12.6 мянган эрүүгийн хэргийн 6.9 мянга (55.2%) нь Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг, 3.1 мянга (24.4%) нь Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг, 1025 (8.2%) нь Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг байгаа нь 2018 онд бүртгэгдсэн Эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн 75.8%, Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэргийн 13.9%, Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэргийн 83.3 % байна. Өөрөөр хэлбэл бүртгэгдсэн Эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн 75.8% нь эрүүгийн хэрэг үүсгэгдэн хянан шийдвэрлэгдсэн байна (Хүснэгт 3.2.2).

Хүснэгт 3.2.2 Анхан шатны шүүхээр шийдвэрлэсэн эрүүгийн хэрэг ба Цагдаагийн байгууллагад бүртгэгдсэн гэмт хэрэг, төрлөөр, 2018 он

Гэмт хэргийн төрөл	2018 он	
	Бүртгэгдсэн гэмт хэрэг	Шүүхээр шийдвэрлэсэн хэрэг
Улсын дүн	36 220	12 551
Хүний амьд явах эрхийн эсрэг	714	222
Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг	9 134	6 923
Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг	621	314
Хүний халдашгүй чөлөөтэй байх эрхийн эсрэг	115	16
Хүний хувийн, улс төрийн эрх, эрх чөлөөний эсрэг	6	0
Эрүүл мэндийн эсрэг	33	12
Хүүхдийн эсрэг	21	7
Өмчлөх эрхийн эсрэг	22 468	3 113
Үндэсний аюулгүй байдлын эсрэг	99	53
Эдийн засгийн гэмт хэрэг	242	189
Олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг	314	189
Хүрээлэн байгаа орчны эсрэг	366	255
Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг	1 231	1 025
Нийтийн албаны ашиг сонирхлын эсрэг	237	89
Хэрэг шалган шийдвэрлэх ажиллагааны эсрэг	196	41
Авлигын гэмт хэрэг	362	28
Цэргийн албаны эсрэг	15	10
Цахим мэдээллийн аюулгүй байдлын эсрэг	42	3
Хүн төрөлхтний аюулгүй байдал, энх тайвны эсрэг	1	-
2002 оны ЭХ-аар шийдвэрлэсэн хэрэг	-	62

Эх үүсвэр: Цагдаагийн ерөнхий газар, Шүүхийн ерөнхий зөвлөл

Зураг 3.1.1 Анхан шатны шүүхээр шийдвэрлэсэн эрүүгийн хэрэг, төрлөөр, хувиар, 2018 он



Тайлбар: Бусдад бага хувийг эзэлж буй бусад хэргүүдийг хамруулсан.

Шүүхээр 2018 онд шийдвэрлэсэн 12.6 мянган эрүүгийн хэргийн 55.2% нь Эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг, 24.8% нь Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг, 8.2% нь ХАБТХАЖ-ын эсрэг гэмт хэрэг, 1.8% Хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг, 1.8% нь бусад төрлийн гэмт хэрэг, 2.0% нь Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг, 1.5% нь Олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг, 1.5% нь эдийн засгийн гэмт хэрэг, 0.7% нь Нийтийн албаны ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг байна (Зураг 3.1.1).


3.3 ШҮҮХЭЭР ЯЛ ШИЙТГҮҮЛСЭН ХҮН

Хүснэгт 3.3.1 Анхан шатны шүүхээр ял шийтгүүлсэн хүн, 2009-2018 он

Үзүүлэлт	2009	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2018
Ял шийтгүүлсэн хүн	7 513	7 292	8 210	8 324	8 065	8 178	7 696	6 566	9 019	12 088
Урьд нь ял шийтгүүлсэн	1 637	1 645	1 460	1 544	1 698	1 919	1 900	1 773	1 977	2 542
Гэмт хэрэг давтан үйлдсэн	591	562	471	539	504	455	600	451	282	311
Бүлэглэн үйлдсэн	1 314	1 407	1 465	1 498	1 414	1 604	1 616	1 382	1 497	893
Согтуугаар үйлдсэн	1 610	1 512	1 704	1 717	1 710	1 582	1 700	1 729	2 250	2 928


Шүүхээр ял шийтгүүлсэн хүний тоо 2018 онд 9019 болж, өмнөх оноос 3069 (34%) - өөр өссөн байна. Ял шийтгүүлэгчдийн 2542 (21.0%) нь урьд нь ял шийтгүүлж байсан, 311 (2.6%) нь давтан хэрэг үйлдсэн, 893 (7.4%) нь бүлэглэн үйлдсэн, 2928 (24.2%) нь согтуугаар гэмт хэрэг үйлдсэн байна. Ял шийтгүүлэгчдийн 1344 (11.1%) нь эмэгтэйчүүд, 295 (2.4%) нь өсвөр насны хүн байна (Хүснэгт 3.3.1).

Зураг 3.3.1 Шүүхээр ял шийтгүүлсэн хүн, 2000-2018 он



2000 онд 16, түүнээс дээш насны 10000 хүн тутмаас 95 хүн шүүхээр ял шийтгүүлж байсан бол 2005 онд 59 хүн, 2016 онд 31 хүн, 2018 онд 16 түүнээс дээш насны 10000 хүн тутмаас 56 хүн ял шийтгүүлжээ.

Зураг 3.3.2 Шүүхээр ял шийтгүүлсэн өсвөр насны хүн, 2000-2018 он



Шүүхээр ял шийтгүүлсэн өсвөр насны хүний тоо 2018 онд 295 болж, өмнөх оноос 130 (30.6%)-аар буурсан байна. 16, түүнээс дээш насны 10000 хүнд ногдох шүүхээр ял шийтгүүлсэн өсвөр насны хүний тоо 2 байсан бол 2018 онд 1.4 болж 30.0%-иар буурсан байна (Зураг 3.3.2).

2018 онд шүүхээр ял шийтгүүлсэн хүний 41.3 %-ийг 18-29 насны залуучууд, 22.8%-ийг 30-34 насныхан, 33.5 %-ийг 35-аас дээш насныхан, 2.4 %-ийг 18 хүртэлх насны хүүхдүүд эзэлж байна. Насны бүлгээр нь авч үзвэл ял шийтгүүлсэн 35-аас дээш насныхан өмнөх оноос 0.1 пунктээр өсөж, харин 30-34 насныхан 3.7 пунктээр, 18-29 насныхан 1.4 пунктээр, 18 хүртэлх насныхан 2.4 пунктээр буурсан байна. Ял шийтгүүлсэн 1344 эмэгтэйн 87 (6.5%) нь 55-аас дээш насны эмэгтэйчүүд байна.

Зураг 3.3.2 Шүүхээр ял шийтгүүлсэн хүн, насны бүлгээр, хүйсээр, 2002-2018 он


Он	Улсын дүн		14-15	16-17	18-29	30-34	35, түүнээс дээш
	Эмэгтэй						
2002	11 357	859	288	899	4 832	2 573	2 765
2003	9 029	734	307	807	4 593	1 485	1 837
2004	9 473	735	347	820	4 835	1 533	1 938
2005	10 153	876	341	837	5 122	1 656	2 197
2006	7 792	660	162	565	3 508	1 699	1 858
2007	8 463	710	221	742	4 231	1 330	1 939
2008	8 495	799	168	379	4 135	1 459	2 354
2009	7 513	656	112	274	3 915	1 376	1 836
2010	7 292	612	136	315	3 802	1 255	1 784
2011	8 210	724	124	418	4 273	1 390	2 005
2012	8 324	726	177	393	4 274	1 364	2 116
2013	8 065	692	206	359	3 941	1 463	2 096
2014	8 178	718	134	353	3 980	1 431	2 280
2015	7 696	664	110	349	3 616	1 302	2 319
2016	6 566	518	84	276	3 037	1 186	1 983
2017	9 019	933	87	341	3 852	1 724	3 015
2018	12 088	1 344	70	225	4 994	2 753	4 046

Зураг 3.3.3 Шүүхээр ял шийтгүүлсэн хүн, боловсролын түвшинээр, хувиар



2018 онд шүүхээр ял шийтгүүлсэн хүний 44.5% нь бүрэн дунд, 17.7 % нь суурь, 17.6% нь дээд, 8.7 % нь бага боловсролтой, 5.8% нь боловсролгүй хүн байна.

Зураг 3.3.4 Шүүхээр ял шийтгүүлсэн төрийн албан хаагчид, төрийн албаны ангиллаар, 2017-2018 он



Шүүхээр ял шийтгүүлсэн хүний 31 (6.3%) нь улс төрийн албан тушаалтан, 37 (7.5%) нь төрийн захиргааны албан хаагч, 127 (25.8%) нь төрийн тусгай албан хаагч, 297 (60.4%) нь төрийн үйлчилгээний албан хаагч байна. Шүүхээр ял шийтгүүлсэн 12.0 мянган хүний 6.0 мянган хүн нь ажилгүй, 21 нь ялтан байна.

2018 онд ял шийтгүүлсэн 12088 хүнд нь 3245 хорих ял оногдуулсны 2995 (92.3%) нь хорих ялыг биечлэн эдэлж, 2040 хорих ялыг тэнсэж, 7437 торгох ял оногдуулж, 6.7 тэрбум төгрөгийн торгууль ноогдуулсан байна (Хүснэгт 3.3.3).

Хүснэгт 3.3.3 Шүүхээс оногдуулсан ял, ялын төрлөөр, 2017-2018 он

Он	Ял шийтгүүлсэн хүний тоо	Торгох ял	Нийтэд тустай ажил хийлгэх ял	Хорих ял	Хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ	Албадан ажил хийлгэх ял	Эмнэлэгийн чанартай албадлагын арга хэмжээ	Хорих ял оногдуула хгүйгээр тэнсэх
2017	9019	2768	710	4596	123	239	5	962
2018	12088	7437	1683	3245	127	0	23	2040

Шүүхээр ял шийтгүүлсэн 12.0 хүний 7340 (60.7%) нь Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг, 3039 (25.1%) нь Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг, 548 (4.5%) нь Хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг, 189 (166%) нь Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг, 192

(1.6%) нь Хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг, 158 (1.3%) нь Олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг үйлдэж ял шийтгүүлсэн байна.

Хүснэгт 3.3.4 Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэргийн улмаас ял шийтгүүлсэн хүн, 2018 он

Эрүүгийн хуулийн зүйлээр	Шийдвэрлэвэл зохих		Хянан шийдвэрлэсэн		Хорих ял оногдуулахг үйгээр тэнсэх	Ял шийтгүүлсэн хүн-бүгд		
	Хэрэг	Хүн	Хэрэг	Хүн		Хүн	Эмэгтэй	Өсвөр насны
Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг-Бүгд	1,157	1,199	1,025	1,056	481	548	74	1
Төмөр замын, агаарын, усан замын тээврийн хөдөлгөөний ба ашиглалтын аюулгүй байдлын журам зөрчих	1	4	1	4	-	4	-	-
Замын байгууламжийн ашиглалт, засварын аюулгүй байдлын журам зөрчих	1	4	-	2	2	-	-	-
Авто тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих	1,150	1,186	1,021	1,047	479	541	74	1
Авто тээврийн гэмт хэрэг үйлдсэн жолооч зугтаах	5	5	3	3	-	3	-	-

Анхан шатны шүүхэд 2018 онд 1199 хүнд холбогдох 1157 Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдлын ашиглалтын журмын эсрэг хэргээс 1056 хүнд холбогдох 1025 хэргийг хянан шийдвэрлэж, 7 хүнд холбогдох 4 хэргийг хэрэгсэхгүй болгож, 2 хүнд холбогдох 1 хэргийг түдгэлзүүлж, 2 хүнд холбогдох 2 хэргийг цагаатгаж, 13 хүнд холбогдох 13 хэргийг эрүүгийн хариуцлагаас чөлөөлж, 481 хүнд холбогдох 481 хэргийг хорих ял оногдуулахгүйгээр тэнсэж, 548 хэрэгт холбогдох 548 хүнд ял оногдуулсан байна. Энэ төрлийн гэмт хэргийн улмаас ял шийтгүүлсэн 548 хүний 74 (13.5%) нь эмэгтэйчүүд, 1 (0.2%) өсвөр насны хүн байна.


Хүснэгт 3.3.5 Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэргийн хохирогч, хүйс, насны ангиллаар

Он	Улсын дүн	Эмэгтэй	0-17	18-24	25-29	30-34	35-39	40-44	45-49	50-54	55-59	60-64	65-69	70, түүнээс дээш
2018	1 292	506	133	140	188	202	191	143	86	93	51	30	14	21

2018 онд ХАБТХАЖ-ын эсрэг 1025 хэргийн улмаас 1292 хүн хохирсон нийт гэмт хэргийн хохирогчийн 9.2%-ийг эзэлж байна. Монгол Улсын Эрүүгийн хуулийн 27.10 (Авто тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих)-р зүйлийг зөрчиж, 1021 гэмт хэрэг үйлдэгдсэний улмаас 1291 хүн хохирч, үүнээс 133 (10.3%) нь 0-17 насны хүүхэд байна. 0-17 насны 133 хүүхдийн 25 нь 0-4 насны, 34 нь 5-9 насны, 38 нь 10-14 насны, 36 нь 15-17 насны хүүхэд байна.

3.4 УЧИРСАН ХОХИРОЛ, НӨХӨН ТӨЛҮҮЛЭЛТ, ХОХИРОГЧ ХҮН, ХУУЛИЙН ЭТГЭЭД

Зураг 3.4.1 Шүүхээр шийдвэрлэсэн эрүүгийн хэргийн учирсан хохирол, нөхөн төлүүлэлт, тэрбум төгрөгөөр, 2009-2018 он



2018 оны байдлаар шүүхээр 12551 эрүүгийн хэрэгт холбогдох 40.2 тэрбум төгрөгийн хохирол учирч, 22.3 тэрбум төгрөгийн хохирлыг нөхөн төлүүлжээ. 40.2 тэрбум төгрөгийн учирсан хохирлын 35.2 (88.0%) тэрбум төгрөг нь хувь хүнд, 5.0 (12.0%) тэрбум төгрөгийн хохирол нь хуулийн этгээдэд учирсан хохирол байна. 2018 онд хувь хүнд учирсан 35.2 тэрбум төгрөгийн хохирлын 55.5%-ийг нөхөн төлүүлсэн бол хуулийн этгээдэд учирсан 5.0 тэрбум төгрөгийн хохирлын 55.1%-ийг нөхөн төлүүлсэн байна.


Хүснэгт 3.4.1 Хохирсон хүн, хүйс, насны бүлгээр, 2018 он

Он	Улсын дүн	Эмэгтэй	0-17	18-24	25-29	30-34	35-39	40-44	45-49	50-54	55-59	60-64	65-69	70, түүнээс дээш
2018	14 053	4 772	764	1 925	2 623	2 637	2 152	1 499	1 002	719	380	172	85	95

Эрүүгийн гэмт хэргийн улмаас 2018 онд 14.0 мянган хүн, 227 хуулийн этгээд хохирсон байна. Нийт хохирсон хүний 4772 (34.0) нь эмэгтэйчүүд байна. Эрүүгийн гэмт хэргийн хохирогчийн 764 (5.4%) нь 0-17 насны хүүхдүүд, 1925 (13.7%) нь 18-24 насныхан, 2623 (18.7%) нь 25-29 насныхан, 2637 (18.8%) нь 30-34 насныхан, 2152 (15.3%) нь 35-39 насныхан, 1499 (10.7%) нь 40-44 насныхан, 1002 (7.1%) нь 45-49 насныхан, 719 (5.1%) нь 50-54 насныхан, 380 (2.7%) нь 55-59 насныхан, 172 (1.2%) нь 60-64 насныхан, 85 (0.6%) нь 65-69 насныхан, 95 (0.7%) нь 70-аас дээш насныхан байна. Эрүүгийн гэмт хэргийн хохирогч 14053 хүний 5710 (40.6%) нь бүрэн дунд боловсролтой, 3221 (22.9%) нь дээд боловсролтой, 2121 (15.1%) нь суурь боловсролтой, 1292 (9.2%) нь техникийн

болон тусгай мэргэжлийн боловсролтой, 1100 (7.8%) нь бага боловсролтой, 609 (4.3%) боловсролгүй хүн байна (Зураг 3.4.2).

Зураг 3.4.2 Гэмт хэргийн улмаас хохирсон хүн, боловсролын түвшнээр, 2018 он



Хүснэгт 3.4.2 Хохирсон хүн, гэмт хэргийн төрлөөр, 2018 он

Гэмт хэргийн төрөл	Бүртгэгдсэн гэмт хэрэг	Шүүхээр шийдвэрлэсэн эрүүгийн хэрэг	Ял шийтгүүлсэн хүн	Хохирогч хүн
Улсын дүн	36 220	12 551	12 088	14 053
Хүний амьд явах эрхийн эсрэг	714	222	192	217
Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг	9 134	6 923	7 340	7 157
Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг	621	314	308	255
Хүний халдашгүй чөлөөтэй байх эрхийн эсрэг	115	16	17	16
Хүний хувийн, улс төрийн эрх, эрх чөлөөний эсрэг	6	-	-	-
Эрүүл мэндийн эсрэг	33	12	6	3
Хүүхдийн эсрэг	21	7	2	4
Өмчлөх эрхийн эсрэг	22 468	3 113	3 309	4 820
Үндэсний аюулгүй байдлын эсрэг	99	53	52	4
Эдийн засгийн гэмт хэрэг	242	189	75	23
Олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг	314	189	158	63
Хүрээлэн байгаа орчны эсрэг	366	255	189	96
Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг	1 231	1 025	548	1 292
Нийтийн албаны ашиг сонирхлын эсрэг	237	89	79	77
Хэрэг шалган шийдвэрлэх ажиллагааны эсрэг	196	41	50	11
Авлигын гэмт хэрэг	362	28	30	4
Цэргийн албаны эсрэг	15	10	1	5
Цахим мэдээллийн аюулгүй байдлын эсрэг	42	3	-	6
Хүн төрөлхтний аюулгүй байдал, энх тайвны эсрэг	1	-	-	-
2002 оны ЭХ-аар шийдвэрлэсэн хэрэг	-	62	-	-

Хүснэгт 3.4.3 Хохирсон хүн, хүйс, насны ангиллаар, 2018 он

Эрүүгийн хуулийн бүлэг, зүйл	Гэмт хэргийн улмаас хохирсон хүн-бүгд	Хохирогч хүн, насны ангиллаар																
		Эмэгтэй	Өсвөр насны хохирогч				18-21	22-24	25-29	30-34	35-39	40-44	45-49	50-54	55-59	60-64	65-69	70 түүнээс дээш
			0-4	5--9	10--14	15-17												
Улсын дүн	14053	4772	104	95	240	325	606	1319	2623	2637	2152	1499	1002	719	380	172	85	95
Хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг	217	57	12	2	1	1	3	9	19	47	29	35	10	21	13	6	5	4
Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг	7157	2428	59	30	64	142	315	775	1486	1477	1117	692	450	299	153	50	20	28
Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт	255	246	4	24	99	62	14	17	17	6	3	3	2	2	1	-	-	1
Хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийн эсрэг гэмт хэрэг	16	7	-	-	-	7	3	1	-	2	2	1	-	-	-	-	-	-
Эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг	3	2	1	-	-	-	1	-	-	-	-	1	-	-	-	-	-	-
Хүүхдийн эсрэг гэмт хэрэг	4	3	1	1	-	-	-	-	1	1	-	-	-	-	-	-	-	-
Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг	4820	1469	1	4	38	74	223	392	845	820	753	605	441	298	158	83	44	41
Эдийн засгийн гэмт хэрэг	23	4	-	-	-	-	-	3	3	7	8	1	1	-	-	-	-	-
Үндэсний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг	4	-	-	-	-	-	-	-	-	1	3	-	-	-	-	-	-	-
Олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг	63	8	1	-	-	3	1	20	10	9	6	2	4	3	-	2	2	-
Хэрэг шалган шийдвэрлэх ажиллагааны эсрэг гэмт хэрэг	11	3	-	-	-	-	-	-	4	2	2	-	-	-	2	1	-	-
Авлигын гэмт хэрэг	4	-	-	-	-	-	-	-	-	1	2	1	-	-	-	-	-	-
Нийтийн албаны ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг	77	6	-	-	-	-	-	8	28	22	11	3	5	-	-	-	-	-
Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг	96	32	-	-	-	-	-	-	21	37	23	7	3	3	2	-	-	-
Цахим мэдээллийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг	6	1	-	-	-	-	-	-	1	2	2	1	-	-	-	-	-	-
Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг	1292	506	25	34	38	36	46	94	188	202	191	143	86	93	51	30	14	21
Цэргийн албаны эсрэг гэмт хэрэг	5	-	-	-	-	-	-	-	-	1	-	4	-	-	-	-	-	-

Эх үүсвэр: Шүүхийн ерөнхий зөвлөл

Шүүхээр шийдвэрлэсэн эрүүгийн хэргийн 14053 хохирогчийн 7157(50.9%) нь Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн хохирогч, 4820(34.3%) нь Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэргийн хохирогч, 1292(9.2%) нь Хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэргийн хохирогч, 255(1.8%) нь Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн хохирогч байна. 2018 онд Цагдаагийн байгууллагад бүртгэгдсэн хэргийн 33.6 мянган хохирогчийн 14.0 (42.0) нь шүүхээр гэмт хэргийн хохирогч болсноо тогтоолгосон байна (Хүснэгт 3.4.3).

3.5 АНХАН ШАТНЫ ШҮҮХЭЭР ШИЙДВЭРЛЭСЭН ИРГЭНИЙ ХЭРЭГ

Анхан шатны шүүх 2018 онд 64.5 мянган нэхэмжлэл, гомдол, хүсэлт хүлээн авснаас 10.4 мянган (16.1%) нэхэмжлэлийг хуульд заасан үндэслэлээр хүлээн авахаас татгалзаж, буцаах, харьяаллын дагуу зохих байгууллагад шилжүүлэх зэрэг арга хэмжээ авч, 48.2 мянган иргэний хэргийг хянан шийдвэрлэжээ. Анхан шатны шүүхээр шийдвэрлүүлэхээр ирүүлсэн 64.5 мянган нэхэмжлэл, гомдол, хүсэлтийн 48.5 (74.6 %) мянгыг шийдвэрлэсэн нь өмнөх оноос 3.1 пунктээр өссөн байна. Анхан шатны шүүхээр шийдвэрлэсэн иргэний хэрэг өмнөх оноос 2.9 (6.5%) мянгаар өсөхөд худалдах, худалдан авах болон арилжаатай холбоотой маргаан 511 (8.5%), зээлийн гэрээний маргаан 991 (17.8%), банк, зээлийн үйл ажиллагаатай холбоотой маргаан 525 (35.1%)—аар өссөн нь голлон нөлөөлжээ.


Хүснэгт 3.5.1 Шүүхээр шийдвэрлэсэн иргэний хэрэг, хуулиар, 2011-2018 он

Үзүүлэлт	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2018
Шийдвэрлэсэн иргэний хэрэг-Бүгд	30 368	27 792	35 314	33 996	40 674	46 173	45 233	48 155
Иргэний хуулиар	11568	11 796	12 738	14 708	20 805	24 826	22 783	21 616
Иргэний хэргийг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулиар	11 152	9 262	15 571	12 421	11 532	11 942	13 600	18 318
Гэр бүлийн тухай хуулиар	4 449	3 878	4 276	4 207	4 539	4 674	4 566	4 763
Хөдөлмөрийн тухай хуулиар	897	742	1 080	1 377	1 487	2 220	2 214	1 785
Газрын тухай хуулиар	101	142	93	132	198	148	119	169
Дампуурлын тухай хуулиар	7	37	11	13	16	10	28	15
Компаны тухай хуулиар	24	16	18	8	18	32	21	35
Нийгмийн даатгалын багц хуулиар	128	97	148	326	436	476	403	332
Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулиар	210	147	162	118	204	381	384	323
Татварын ерөнхий хуулиар	283	251	412	305	621	574	274	215
Үл хөдлөх хөрөнгийн бүртгэлийн тухай хуулиар	5	2	6	4	-	1	1	1
Төрийн албаны тухай хуулиар	6	4	2	3	7	4	4	15
Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөн олговор олгох тухай хуулиар	70	73	52	55	44	45	17	32
Бусад	1 439	1 378	678	319	767	840	819	536


Иргэний хэргийн анхан шатны шүүхүүдээс энэ онд шийдвэрлэсэн хэргүүдийн 73.0%-ийг Улаанбаатар хот дахь анхан шатны шүүхүүд шийдвэрлэсэн бөгөөд энэ нь өмнөх оноос 16.4 пунктээр өссөн байна. Шүүхээр шийдвэрлэсэн иргэний хэргийн 21.6 (44.9%) мянга нь Иргэний хуулиар 18.3 (38.0%) мянга нь ИХШХШ хуулиар, 4.8 (9.9%) мянга нь Гэр бүлийн тухай хуулиар, 1.8 (3.7%) мянга нь Хөдөлмөрийн тухай хуулиар, 3.5% нь бусад хуулиар шийдвэрлэжээ (Хүснэгт 3.5.1).

2018 онд шүүхээр шийдвэрлэсэн 48.2 мянган хэргийн 28.8 (60.0%) мянган хэргийг ердийн журмаар, 12.5 (26.0%) мянган хэргийг хялбаршуулсан журмаар, 6.8 (14.1%) мянган хэргийг хэрэгсэхгүй болгосон бөгөөд ердийн журмаар шийдвэрлэсэн хэрэг өмнөх оноос 3.3 пункт, хэрэгсэхгүй болгосон хэрэг 0.9 пунктээр өсөж, харин хялбаршуулсан журмаар шийдвэрлэсэн хэрэг 4.1 пунктээр буурсан байна.

Зураг 3.5.1 Иргэний хэрэг, маргааныг шийдвэрлэсэн байдал, дүнд эзлэх хувиар, 2017-2018 он




Зураг 3.5.2 Шийдвэрлэсэн иргэний хэрэг, хуулиар, 2017-2018 он



Монгол Улсын “Хөдөлмөрийн тухай” хуулиар 2018 онд 1785 хөдөлмөрийн маргаан шийдвэрлэгдсэний 943 (52.8%) нь ажлаас үндэслэлгүй халагдсан, 637 (35.7%) нь цалин хөлсний маргаан, 31 (1.7%) нь ажлаас буруу шилжүүлсэн маргаан бөгөөд өмнөх оноос ажлаас үндэслэлгүй халагдсан маргаан 11.9 пунктээр, буруу шилжүүлсэн маргаан 0.7 пунктээр буурч, харин цалин хөлсний маргаан 10.2 пунктээр өссөн байна.

Зураг 3.5.3 Шүүхээр шийдвэрлэсэн хөдөлмөрийн маргаан, маргааны төрлөөр 2016-2018 он



2018 онд шүүхээр шийдвэрлэгдсэн хөдөлмөрийн маргааны 20.4 % нь баруун бүсэд, 9.2 % нь хангайн бүсэд, 9.8 % нь төвийн бүсэд, 4.0 % нь зүүн бүсэд, 56.6 % нь Улаанбаатар хотод гарсан байна. Шүүхээр шийдвэрлэсэн нийт хөдөлмөрийн маргаанд баруун бүсийнх өмнөх оноос 0.5 пункт, зүүн бүс 0.4 пункт, Улаанбаатар хот 1.2 пунктээр өсөж, харин төвийн бүсийнх 1.5 пункт, хангайн бүсийнх 0.6 пунктээр буурсан байна. Хөдөлмөрийн маргаан өмнөх оноос буурахад ажлаас үндэслэлгүй халагдсан маргаан 489 (34.1%), ажлаас буруу шилжүүлсэн маргаан 22 (41.5%)-оор буурсан нь голлон нөлөөлжээ.


Монгол Улсын “Дампуурлын тухай” хуулиар 2018 онд 15 аж ахуйн нэгж шүүхийн шийдвэрээр дампуурлаа зарласан бөгөөд эдгээрийн 12 (80.0%) аж ахуйн нэгжийнх нь хариуцагчийг татан буулгасан байна.

Хүснэгт 3.5.2 “Гэр бүлийн тухай” хуулиар шийдвэрлэсэн хэрэг, 2011-2018 он

Үзүүлэлт	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2018
Улсын дүн	4 449	3 878	4 276	4 207	4 539	4 674	4 566	4 763
Гэрлэлт цуцалсан	3 642	3 100	3 382	3 182	2 978	2 980	2 791	2 945
Эцэг тогтоосон	325	278	313	430	531	450	467	392
Эцэг, эх байх эрх хассан	7	4	6	21	37	17	24	11
Хүүхдийн тэтгэлэг гаргуулах	364	370	454	478	825	1 006	1 056	1 146
Гэрлэлт болон гэрлэлт цуцлалтыг хүчин төгөлдөр бус гэж тооцох	9	11	11	32	59	47	50	64
Бусад	102	115	110	64	109	174	178	205

Монгол Улсын “Гэр бүлийн тухай” хуулиар 2018 онд 4763 хэрэг шийдвэрлэгдсэний 2945 (61.8%) нь гэрлэлт цуцалсан, 392 (8.2%) нь эцэг тогтоосон, 1146 (24.1%) нь хүүхдийн тэтгэлэг гаргуулах, 11 (0.2%) нь эцэг, эх байх эрх хассан, 64 (1.3%) нь гэрлэлт болон гэрлэлт цуцлалтыг хүчин төгөлдөр бус гэж тооцсон, 205 (4.3%) нь бусад хэрэг байна. “Гэр бүлийн тухай” хуулийн дагуу анхан шатны шүүхээр шийдвэрлэсэн хэрэг өмнөх оноос 197 (4.3%)-оор өсөхөд гэр бүл цуцлалт 154 (5.5%)-өөр өссөн нь голлон нөлөөлжээ.

Зураг 3.5.4 “Гэр бүлийн тухай” хуулиар шийдвэрлэсэн хэрэг, хувиар



2018 онд 1146 хүүхдийн тэтгэлэг гаргуулах маргаан шийдвэрлэж, 985 хүүхэд тэтгэлэг тогтоолгосон нь өмнөх оноос хүүхдийн тэтгэлэг гаргуулах маргааны тоо 90 (8.5%)-ээр, тэтгэлэг тогтоолгосон хүүхдийн тоо 108 (12.3%)-аар өссөн байна.

3.6 АНХАН ШАТНЫ ШҮҮХЭЭР ШИЙДВЭРЛЭСЭН ЗАХИРГААНЫ ХЭРЭГ

Захиргааны хэрэг гэдэг нь бүх нийтээр буюу тухайн нутаг дэвсгэрт дагаж мөрдүүлэхээр тогтоосон захиргааны журмыг санаатай буюу болгоомжгүйгээр зөрчсөн үйлдэл, эс үйлдэхүйг хэлнэ.

Хүснэгт 3.6.1 Анхан шатны шүүхийн захиргааны хэрэг, 2011-2018 он

Үзүүлэлт	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2018
Улсын дүн	891	961	1 097	1 187	1 439	1 780	1 908	1 638
Ашигт малтмалтай холбоотой маргаан	86	119	72	43	96	142	172	154
Байгал орчныг хамгаалахтай холбоотой маргаан	1	4	3	2	2	3	-	3
Боловсролтой холбоотой маргаан	2	2	3	4	4	1	2	4
Газрын маргаан	228	210	280	386	338	419	372	416
Иргэний бүртгэлтэй холбоотой маргаан	27	18	13	28	16	30	29	22
Нийгмийн даатгалтай холбоотой маргаан	24	11	16	23	37	40	35	43
Оюуны өмчийн маргаан	6	1	3	4	6	2	3	
Сонгуулийн маргаан	10	120	103	14	6	184	42	18
Татварын маргаан	76	73	65	81	128	127	77	59
Төрийн албаны маргаан	139	133	203	297	400	417	660	335
Төрийн болон орон нутгийн өмчийн тухай маргаан	11	18	16	9	11	6	54	61
Төрийн хяналт, шалгалттай холбоотой бусад маргаан	54	42	46	81	83	75	52	62
Тусгай зөвшөөрөлтэй холбоотой бусад маргаан	19	7	2	15	15	10	18	34
Хуулийн этгээдийн улсын бүртгэлтэй холбоотой бусад маргаан	12	5	6	12	14	24	33	25
Үл хөдлөх эд хөрөнгийн улсын бүртгэлтэй холбоотой маргаан	83	80	88	59	104	83	112	65
Бусад	113	118	178	129	179	217	247	337
Нэхэмжлэгч-бүгд	1 045	1 001	1 150	1 398	1 651	2 041	2 340	2 085
Иргэд	685	590	689	955	1 089	1 293	1 660	1 228
Хуулийн этгээд	360	411	461	443	562	748	604	648

Захиргааны хэргийн анхан шатны шүүх 2018 онд нийт 2500 хэрэг, нэхэмжлэл хүлээн авснаас 1638 хэргийг хянан шийдвэрлэсэн нь шийдвэрлэвэл зохих хэргийн 65.5%-ийг хянан шийдвэрлэсэн байна. Энэ нь өмнөх оноос 12.1 пунктээр буурсан байна. Захиргааны хэргийн анхан шатны шүүх 2018 онд 2085 нэхэмжлэгчид холбогдох 1638 хэргийг шийдвэрлэсэн нь өмнөх оноос нэхэмжлэгчдийн тоо 255 (10.9%)-аар, харин хэргийн тоо 270 (14.2%)-аар буурсан байна. Нийт нэхэмжлэлийн 1228 (59.0%) нь иргэний нэхэмжлэл, 648 (31.1%) нь хуулийн этгээдийн нэхэмжлэл байна. Улсын хэмжээгээр хянан шийдвэрлэсэн нийт маргааны 964 (58.9%) нь нийслэлийн захиргааны хэргийн шүүхэд шийдвэрлэсэн хэрэг бөгөөд өмнөх оноос 3.3 пунктээр өссөн байна. Захиргааны хэрэг буурахад төрийн албаны маргаан 325-аар, сонгуулийн маргаан 24-өөр, ашигт малтмалын холбоотой маргаан 18-аар буурсан нь голлон нөлөөлжээ. Захиргааны хэргийн шүүхэд 2018 онд 2085 нэхэмжлэгчээс 6.6 тэрбум төгрөгийн хохирлыг нэхэмжилж, харин шүүхээс 5.7 тэрбум төгрөгийн хохирлыг нөхөн төлүүлэхээр шийдвэрлэжээ. 2018 онд шийдвэрлэсэн нийт

хэргийн 473 (28.9%) хэргийг хялбаршуулсан журмаар, 1042 (63.6%) хэргийг ердийн журмаар шийдвэрлэж, харин 123 (7.5%) хэргийг хэрэгсэхгүй болгосон байна.

Хүснэгт 3.6.2 Анхан шатны шүүхийн захиргааны хэргийн хариуцагч, хэлбэрээр, 2017-2018 он

Үзүүлэлт	2017	2018
Төрийн гүйцэтгэх эрх мэдлийг хэрэгжүүлдэг байгууллага, албан тушаалтан-бүгд	1790	1728
Засгийн газрын бус бие даасан агентлаг, түүнтэй адилтгах бусад байгууллага-бүгд	47	42
Захиргааны чиг үүргийг хууль болон нийтийн эрх зүйн гэрээний үндсэн дээр шилжүүлэн авсан этгээд-бүгд	7	6
Төрийн ба холимог өмчийн сургууль, эмнэлэг, эрчим хүч гэх зэрэг байгууллагын захиргаа-	13	5
Нутгийн өөрөө удирдах байгууллага болон шийдвэр, үйл ажиллагаанд нь гомдол гаргахаар хуульд заасан байгууллага-бүгд	170	119
Нийтийн эрх зүйн субъект болох бусад байгууллага, албан тушаалтан-бүгд	22	3
Захиргааны хэргийн хариуцагч-бүгд	2049	1903

2018 онд захиргааны хэргийн анхан шатны шүүхээр шийдвэрлэсэн 1638 хэргийн 1903 хариуцагч байгаа нь өмнөх оноос хариуцагчийн тоо 506 (7.1%) –аар буурсан байна (Хүснэгт 3.6.2).

3.7 ДАВЖ ЗААЛДАХ ШАТНЫ ШҮҮХЭЭР ШИЙДВЭРЛЭСЭН ХЭРЭГ


Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүх 2018 онд 2377 хэрэг хүлээн авч, 2166 хэргийг хянан шийдвэрлэсэн нь өмнөх оноос 195 (9.9%)-аар өсжээ. Шинээр үүссэн нөхцөл байдлын улмаас 4 хэргийг хянуулах прокурорын дүгнэлтийг хүлээн авахаас татгалзаж, 44 хэрэгт шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас хэргийг хянуулах прокурорын дүгнэлтийг хүлээн авч, 77 хэргийг давж заалдах шатны шүүхээр хэлэлцүүлэхгүй тухай шийдвэр гаргасан байна.

Давж заалдах шатны шүүхээр 2018 онд 2166 эрүүгийн хэрэг, 3520 иргэний хэрэг, 1340 захиргааны хэргийг хянан шийдвэрлэсэн нь эрүүгийн хэрэг өмнөх оноос 195 (9.9%)-аар өсөж, харин иргэний хэрэг 191 (10.3%), захиргааны хэрэг 328 (19.7%)-аар буурсан байна (Хүснэгт 3.7.1).

Хүснэгт 3.7.1 Давж заалдах шатны шүүхээр шийдвэрлэсэн хэрэг, 2011-2018 он


Үзүүлэлт	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2018
Эрүүгийн хэрэг	2032	2168	1960	2161	1971	1822	1 971	2 166
Иргэний хэрэг	1803	1634	1806	1947	2519	3108	3 721	3 530
Захиргааны хэрэг	362	517	598	883	1049	1460	1 668	1 340

Зураг 3.7.1 Давж заалдах шатны шүүхийн эрүүгийн хэргийн шийдвэрлэлт, хувиар, 2013-2018 он



Давж заалдах шатны шүүхийн шийдвэрээр тогтоолыг хэвээр үлдээсэн хэрэг өмнөх оноос 4.1 пунктээр өсөж, харин тогтоолыг хүчингүй болгосон нь 2.2 пункт, тогтоолд өөрчлөлт оруулсан нь 1.9 пунктээр буурсан байна.

Зураг 3.7.2 Давж заалдах шатны шүүхээр тогтоолыг хүчингүй болгосон хэрэг, хувиар, 2017-2018 он



2018 онд давж заалдах шатны шүүхээс шүүгчийн тогтоолыг хүчингүй болгосон 723 эрүүгийн хэргийн 377(52.1%) шүүхийн тогтоолд заасан дүгнэлт нь хэргийн бодит байдалтай нийцээгүй, 221 (30.6%) нь эрүүгийн хуулийг буруу хэрэглэсэн, 125 (17.3%) нь Эрүүгийн байцаан шийтгэх хууль, Эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэх хуулийг ноцтойгоор зөрчсөн байна.


Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх 2018 онд 3807 хэрэг хүлээн авч, 3527 хэргийг хянан шийдвэрлэсэн нь шийдвэрлэвэл зохих хэргийн 92.6 %-ийг хянан шийдвэрлэсэн нь өмнөх оноос 3.3 пунктээр өссөн байна (Хүснэгт 3.7.2).

Хүснэгт 3.7.2 Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхээр шийдвэрлэсэн хэрэг, 2013-2018 он

Үзүүлэлт	2013	2014	2015	2016	2017	2018
Хүлээн авсан хэрэг-бүгд	2 011	2 116	2 800	3 475	4 167	3 807
Шийдвэрлэсэн хэрэг-бүгд	1 806	1 962	2 540	3 143	3 776	3 562
Хянан шийдвэрлэсэн -бүгд	1 837	1 947	2 519	3 108	3 721	3 527
Арбитрийн шийдвэрийг хүчингүй болгох тухай хүсэлтийг хянан шийдвэрлэсэн	15	5	7	13	38	23
Шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас шүүхийн шийдвэрийг хянасан	16	10	14	22	17	12
Давж заалдах гомдлыг хэлэлцэхээс татгалзсан	36	46	69	54	70	72
Давж заалдах гомдлоосоо татгалзсан	36	13	40	44	39	38
Үлдэгдэл хэрэг	103	95	151	234	282	135

Эх үүсвэр: Шүүхийн ерөнхий зөвлөл

Зураг 3.7.3 Давж заалдах шатны шүүхийн иргэний хэргийн шийдвэрлэлт, хувиар, 2013-2018 он



Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхээр 2018 онд тогтоолыг хэвээр үлдээсэн хэрэг өмнөх оноос 2.7 пунктээр, тогтоолыг хүчингүй болгосон хэрэг 3.9 пунктээр өсөж, харин тогтоолд өөрчлөлт оруулсан хэрэг 6.5 пунктээр буурсан байна (Зураг 3.7.3).

Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх 2018 онд 1750 хэрэг хүлээн авч, 1668 хэрэг хянан шийдвэрлэсэн нь өмнөх оноос 208(14.2%)-аар өссөн байна.

Хүснэгт 3.7.3 Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн шийдвэр, 2013-2018 он

Үзүүлэлт	2013	2014	2015	2016	2017	2018
Хүлээн авсан хэрэг-бүгд	660	933	1 126	1 555	1 750	1 458
Хянан шийдвэрлэсэн -бүгд	598	883	1 049	1 460	1 668	1 382
Анхан шатны шүүхийн шийдвэрийг хянасан	384	512	606	823	923	687
Анхан шатны шүүхийн тогтоол, шүүгчийн захирамжийг хянасан	185	343	416	573	649	594
Бусад	26	25	25	60	90	94
Шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас шүүхийн шийдвэрийг хянасан	3	3	2	4	6	7
Үлдэгдэл хэрэг	62	50	77	95	82	76

Эх үүсвэр: Шүүхийн ерөнхий зөвлөл

Давж заалдах шатны захиргааны хэргийн шүүхээр 2018 онд 1382 хэрэг шийдвэрлэсний 687 (49.7%) нь анхан шатны шүүхийн шийдвэрийг хянасан, 594 (43.0%) нь анхан шатны шүүхийн тогтоол, шүүгчийн захирамжийг хянасан, 7 (0.5%) нь шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас шүүхийн шийдвэрийг хянасан хэрэг байна (Хүснэгт 3.7.3).

3.8 ХЯНАЛТЫН ШАТНЫ ШҮҮХЭЭР ШИЙДВЭРЛЭСЭН ХЭРЭГ


Хяналтын шатны шүүх 2018 онд 570 эрүүгийн хэрэг, 2074 иргэний хэрэг, 689 захиргааны хэрэг, нийт 3333 хэргийг хянан шийдвэрлэсэн нь өмнөх оноос 446 (15.4%)-аар өссөн байна .

Хүснэгт 3.8.1 Хяналтын шатны шүүхээр шийдвэрлэсэн хэрэг, 2011-2017 он


Үзүүлэлт	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2018
Эрүүгийн хэрэг	807	859	685	629	512	448	342	570
Иргэний хэрэг	1089	778	983	1 017	1 376	1 655	1 829	2 074
Захиргааны хэрэг	382	220	268	381	421	548	716	689

2018 онд хяналтын шатны шүүхийн шийдвэрлэсэн нийт хэргийн 62.2 хувийг иргэний хэрэг, 17.1 хувь нь эрүүгийн хэрэг, 20.7 хувь нь захиргааны хэрэг байгаа бөгөөд иргэний хэрэг өмнөх оноос 0.8 пункт, эрүүгийн хэрэг 2.6 пунктээр өсөж, харин захиргааны хэрэг 3.4 пунктээр буурсан байна (Хүснэгт 3.8.1) .

Зураг 3.8.1 Хяналтын шатны шүүхээр шийдвэрлэсэн хэргийн бүтэц, дүнд эзлэх хувиар, 2017-2018 он



Зураг 3.8.2 Хяналтын шатны шүүхийн хэргийн шийдвэрлэлт, 2017-2018 он



4. УЛС ОРНУУДЫН ГЭМТ ХЭРГИЙН НӨХЦӨЛ, БАЙДЛААС

Хүснэгт 4.1.1 Санаатай аллагын гэмт хэргийн хохирогч, 100000 хүнд ногдохоор
(ТХЗ-16.1.1)

Улс орны нэр	Үзүүлэлтийн нэр	2011	2012	2013	2014	2015	2016
Киргизстан	Хохирогчийн тоо	494	301	206	216	304	267
	100 000 хүн ногдохоор	9.0	5.4	3.6	3.7	5.2	4.5
Хятад	Хохирогчийн тоо	12 015	11 286	10 640	10 083	9 200	8 634
	100000 хүн ногдохоор	0.9	0.8	0.8	0.7	0.7	0.6
Япон	Хохирогчийн тоо	442	429	370	395	363	362
	100 000 хүн ногдохоор	0.3	0.3	0.3	0.3	0.3	0.3
Монгол	Хохирогчийн тоо	266	199	205	218	214	184
	100 000 хүн ногдохоор	9.6	7.1	7.1	7.3	6.2	5.7
Солонгос	Хохирогчийн тоо	427	411	342	372	365	356
	100 000 хүн ногдохоор	0.9	0.8	0.7	0.7	0.7	0.7
Индонез	Хохирогчийн тоо	1 467	1 456	1 386	1 277	1 491	1 292
	100 000 хүн ногдохоор	0.6	0.6	0.5	0.5	0.6	0.5
Филлипин	Хохирогчийн тоо	8 674	8 484	9 153	9 756	9 643	11 385
	100 000 хүн ногдохоор	9.1	8.8	9.3	9.7	9.5	11.0
Сингапур	Хохирогчийн тоо	16	11	17	14	14	18
	100 000 хүн ногдохоор	0.3	0.2	0.3	0.3	0.3	0.3
Тайланд	Хохирогчийн тоо	3 307	3 323	2 894	2 649	2 387	2 229
	100 000 хүн ногдохоор	4.9	4.9	4.2	3.9	3.5	3.2
Энэтхэг	Хохирогчийн тоо	47 640	47 478	45 878	47 356	44 385	42 678
	100 000 хүн ногдохоор	3.8	3.8	3.6	3.7	3.4	3.2
Пакистан	Хохирогчийн тоо	13 860	13 846	13 937	13 276	9 486	8 516
	100 000 хүн ногдохоор	8.0	7.8	7.7	7.2	5.0	4.4
Финланд	Хохирогчийн тоо	110	88	89	88	82	78
	100 000 хүн ногдохоор	2.0	1.6	1.6	1.6	1.5	1.4
Ирланд	Хохирогчийн тоо	42	53	52	52	29	38
	100 000 хүн ногдохоор	0.9	1.1	1.1	1.1	0.6	0.8
Норвега	Хохирогчийн тоо	111	27	46	29	24	27
	100 000 хүн ногдохоор	2.2	0.5	0.9	0.6	0.5	0.5
Швед	Хохирогчийн тоо	81	68	87	87	112	106
	100 000 хүн ногдохоор	0.9	0.7	0.9	0.9	1.1	1.1
Итали	Хохирогчийн тоо	552	530	502	475	469	400
	100 000 хүн ногдохоор	0.9	0.9	0.8	0.8	0.8	0.7
Австри	Хохирогчийн тоо	75	79	62	45	46	57
	100 000 хүн ногдохоор	0.9	0.9	0.7	0.5	0.5	0.7
Франц	Хохирогчийн тоо	856	784	777	792	1,017	875
	100 000 хүн ногдохоор	1.4	1.2	1.2	1.2	1.6	1.4
Герман	Хохирогчийн тоо	738	659	682	716	682	963
	100 000 хүн ногдохоор	0.9	0.8	0.8	0.9	0.8	1.2
Австрали	Хохирогчийн тоо	248	243	245	243	236	227
	100 000 хүн ногдохоор	1.1	1.1	1.1	1.0	1.0	0.9

Эх үүсвэр: <https://www.unodc.org/>

Монгол Улсад санаатай аллагын гэмт хэргийн хохирогч 2016 онд 184 бүртгэгдсэн нь өмнөх оноос 30 (14.0%)-аар буурсан хэдий ч дээрх улс орнуудтай харьцуулахад 100000 хүнд ногдох санаатай аллагын хохирогчийн тоо өндөр байна. Сонгосон улс орнуудтай харьцуулахад 2016 онд Филиппин

улсын дараа хоёрдугаарт орж байна. Энэ нь энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх шаардлагатай байгааг харуулж байна (Хүснэгт 4.1.1).

Хүснэгт 4.1.2 Хулгайлах гэмт хэрэг, 100000 хүнд ногдохоор, 2014-2016 он

Улс орны нэр	Үзүүлэлтийн нэр	2014	2015	2016
Киргизстан	Хэргийн тоо	9 029	9 894	9 292
	100 000 хүнд ногдох түвшин	156.4	168.7	156.1
Турк	Хэргийн тоо	214 204	213 310	169 917
	100 000 хүнд ногдох түвшин	278.0	272.5	214.0
Япон	Хэргийн тоо	451 648	411 350	374 497
	100 000 хүнд ногдох түвшин	352.4	321.4	293.3
Монгол	Хэргийн тоо	8 424	9 169	9 065
	100 000 хүнд ногдох түвшин	288.1	308.0	299.8
Солонгос	Хэргийн тоо	266 222	245 853	203 037
	100 000 хүнд ногдох түвшин	528.4	485.9	400.0
Индонез	Хэргийн тоо	24 538	26 298	26 636
	100 000 хүнд ногдох түвшин	9.6	10.2	10.2
Филлипин	Хэргийн тоо	112 857	82 751	49 634
	100 000 хүнд ногдох түвшин	112.7	81.4	48.0
Сингапур	Хэргийн тоо	16 182	15 207	13 665
	100 000 хүнд ногдох түвшин	297.0	274.7	243.0
Тайланд	Хэргийн тоо	39 898	39 371	33 042
	100 000 хүнд ногдох түвшин	58.3	57.3	48.0
ОХУ	Хэргийн тоо	802 163	1 111 925	736 089
	100 000 хүнд ногдох түвшин	558.0	772.8	511.6
Пакистан	Хэргийн тоо	42 747	38 902	40 388
	100 000 хүнд ногдох түвшин	23.0	20.5	20.9
Финланд	Хэргийн тоо	127 342	122 226	114 490
	100 000 хүнд ногдох түвшин	2 332.4	2 229.6	2 081.0
Ирланд	Хэргийн тоо	77 697	78 864	64 981
	100 000 хүнд ногдох түвшин	1 657.9	1 614.1	1 371.6
Норвега	Хэргийн тоо	132 018	114 828	104 507
	100 000 хүнд ногдох түвшин	2 568.3	2 208.3	1 990.7
Швед	Хэргийн тоо	413 389	399 646	375 396
	100 000 хүнд ногдох түвшин	4 266.4	4 093.2	3 816.9
Австри	Хэргийн тоо	148 263	140 254	143 531
	100 000 хүнд ногдох түвшин	1 717.4	1 616.1	1 649.9
Франц	Хэргийн тоо	1 429 398	1 397 363	1 381 425
	100 000 хүнд ногдох түвшин	2 226.8	2 167.9	2 134.8
Герман	Хэргийн тоо	1 322 144	1 348 955	1 290 481
	100 000 хүнд ногдох түвшин	1 622.5	1 651.0	1 576.2
Австрали	Хэргийн тоо	535 556	561 174	593 369
	100 000 хүнд ногдох түвшин	2 281.4	2 357.9	2 460.1

Эх үүсвэр: <https://dataunodc.un.org/crime/theft>

НҮБ-ын Гэмт хэргийн чиг хандлагын судалгааны 2016 оны тооцооллоор сонгосон дэлхийн улс орнуудаас 100000 хүнд ногдох хулгайлах гэмт хэрэг Швед (3816.9), Австрали (2460.1), Франц (2134.8) орнуудад хамгийн өндөр байна. Харин Ази тивийн улс орнуудаас Солонгос улсад хамгийн өндөр, Монгол Улс 2 дугаарт байна. 2016 онд Монгол улсын Цагдаагийн байгууллагад 9065 хулгайлах гэмт хэрэг бүртгэгдсэн бол 100000 хүн тутамд ногдох хулгайлах гэмт хэрэг 299.8 байна. Энэ нь өмнөх оноос 8.2 (2.7%)-оор буурсан хэдий ч хүн ам цөөтэй манай орны хувьд өндөр тоо байна.

ДҮГНЭЛТ

- Улсын хэмжээгээр 2018 онд 36.2 мянган гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оноос 3961 (12.3%)-ээр өссөн байна.
- Улсын дунджаар 2018 онд 16, түүнээс дээш насны 10000 хүн тутамд 169 бүртгэгдсэн гэмт хэрэг ногдож байгаа бол шүүхээр шийдвэрлэсэн эрүүгийн хэрэг 59 ногдож байна.
- Бүртгэгдсэн 36.2 мянган гэмт хэргийн 22.5 (62.0%) мянга нь Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг, 9.1 (25.2%) мянга нь Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг, 1.2 (3.4%) мянга нь Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг байна.
- Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэргийн тоо 2018 онд 22468 бүртгэгдэж, өмнөх оноос 4292 (23.6%)-оор өсөхөд энэ төрлийн гэмт хэргийн 59.7 хувийг эзэлж буй хулгайлах хэрэг 1202 (9.8%)-оор, залилах гэмт хэрэг 2376 (79.3%)-гаар, дээрэмдэх гэмт хэрэг 264 (21.4%)-оор, хөрөнгө завших гэмт хэрэг 193 (52.3%)-аар, мал хулгайлах гэмт хэрэг 195 (21.6%)-аар өссөн нь голлон нөлөөлжээ.
- Мал хулгайлах гэмт хэрэг 1096 бүртгэгдсэн нь өмнөх оноос 195 (21.6%)-аар өсжээ. Мал хулгайлах гэмт хэргийн тоо өмнөх оноос өсөхөд Хэнтий (51), Дорнод (42), Сүхбаатар (41), Хөвсгөл (35)-аар өссөн нь голлон нөлөөлжээ.
- Дээрэмдэх гэмт хэрэг 2018 онд 1497 бүртгэгдсэн нь өмнөх оноос 264 (21.4%)-оор өссөн байна. Сүүлийн 24 жилийн хугацаанд дээрэмдэх хэрэг 2018 онд хамгийн их гарсан байна.
- Олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг гэмт хэргийн бүрэлдэхүүнд зонхилох байр суурийг эзэлдэг мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар ашиглах гэмт хэрэг 2018 онд улсын хэмжээгээр 195-д хүрч, өмнөх оноос 66 (51.2%)-аар өссөн байна. Улсын хэмжээгээр 2018 онд бүртгэгдсэн мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар ашиглах гэмт хэргийн 150 (76.9 %) нь Улаанбаатар хотод бүртгэгдсэн байна.
- Авлигын гэмт хэрэг 2018 онд 362 бүртгэгдсэн нь өмнөх оноос 212 (2.4 дахин)-оор өссөн байна. Сүүлийн 23 жилийн хугацаанд авлигын гэмт хэрэг 2006 онд хамгийн цөөн (92), 2018 онд хамгийн олон (362) бүртгэгджээ.
- Хүн худалдаалах гэмт хэргийн 7 (70.0%) нь Улаанбаатар хотод бүртгэгдсэн байна. Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийг насны ангиллаар авч үзвэл ихэвчлэн 14-29 насныхан байна.
- 2018 онд үйлдэгдсэн гэмт хэргийн 3289 (9.1%) нь согтуугаар үйлдэгдсэн хэрэг, 176 (0.5%) нь мансуурсан үедээ үйлдсэн хэрэг, 39 (0.1%) нь галт зэвсгээр үйлдэгдсэн хэрэг, 1069 (3.0%) нь гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн хэрэг, 85 (0.2%) нь зохион байгуулалттай гэмт хэрэг, 741(2.0%) нь хүүхэд оролцсон гэмт хэрэг, 2939 (8.1%) нь эмэгтэйчүүд оролцсон хэрэг байна.

- Гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн гэмт хэрэг 2018 онд 1069 болж, өмнөх оноос 217-оор буурахад Улаанбаатар хот (168), Баян-Өлгий (20), Дорноговь (13), Сүхбаатар (21) аймгуудад буурсан нь голлон нөлөөлөв. Гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн гэмт хэргийн 1069 хэргийн 589 (55.1%) нь Улаанбаатар хотод бүртгэгдсэн байна.
- Мансуурсан үедээ үйлдэгдсэн хэрэг улсын хэмжээгээр 2018 онд 176 бүртгэгдсэн нь өмнөх оноос 84 (91.3%)-өөр өссөн байна. Мансуурсан үедээ үйлдсэн хэрэг 2018 онд 176 бүртгэгдсэний 151 нь Улаанбаатар хотод бүртгэгдсэн нь 2016 оноос 21 (40.4%), 2017 оноос 78 (2.1 дахин)-аар өссөн байна.
- 2018 онд гэмт хэргийн улмаас хохирсон 33.6 мянган хүний 14.7 мянга (43.7%) нь эмэгтэйчүүд, 1688 (5.0%) нь хүүхэд, 5545 (16.5%) нь 25-29 насны хохирогч, 5650(16.8%) нь 30-34 насны хохирогч, 4482 (13.4%) нь 35-39 насны хохирогч, 3815 (11.4%) нь 40-44 насны хохирогч байна.
- 2018 онд гэмт хэргийн улмаас хохирсон хүний 20859 (62.1%) нь Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэргээс, 9148 (27.3%) нь Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэргээс, 1375 (4.1%) нь Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэргийн улмаас хохирсон байна.
- 2018 онд өмчлөх эрхийн эсрэг гэмт хэргийн 20.9 мянган хохирогчийн 11.6 мянга (55.4%) нь хулгайлах хэргийн хохирогч байна. Хулгайлах гэмт хэргийн хохирогчийн 292 (2.5%) нь хүүхэд, 5.7 мянга (49.4%) нь эмэгтэйчүүд байна.
- 2018 онд гэмт хэргийн улмаас хохирсон 33.6 мянган хохирогчийн 1375 (4.1%) нь хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэргийн хохирогч байна. Энэ төрлийн гэмт хэргийн хохирогчийн 192(14.0%) нь 18 хүртэлх насны хүүхдүүд, 592 (43.1%) нь эмэгтэйчүүд байна. ХАБТХАЖ-ын эсрэг гэмт хэргийн хохирогч өмнөх оноос 353 (20.4%)-аар буурсан байна.
- Гэмт хэргийн улмаас 2018 онд 934 хүн нас барсны 325 (34.8%) нь зам тээврийн ослын улмаас нас барсан нь өмнөх оноос 0.1 пунктээр буурсан байна. Гэмт хэргийн улмаас 2018 онд 9283 хүн гэмтсэний 998 (10.8%) нь зам тээврийн ослын улмаас гэмтжээ.
- Зам тээврийн ослын улмаас нас барсан 325 хүний 91 (28.0%) нь Улаанбаатар хотынх байна. Сонгинохайрхан(29), Хан-Уул(15) Баянзүрх(15) Налайх(10) дүүргүүдэд зам тээврийн ослын улмаас хамгийн олон хүн амь насаа алджээ. Харин аймгуудаас Төв(35), Дорноговь(19), Сэлэнгэ(19), Дорнод (17), Өвөрхангай (17) аймгуудад хамгийн олон хүн зам тээврийн ослын улмаас амь насаа алджээ.
- Улсын хэмжээгээр 2018 онд гэмт хэргийн улмаас 934 хүн нас барсны 88 (9.4%) нь хүүхэд байна. Гэмт хэргийн улмаас нас барсан 88 хүүхдийн 45 (51.1%) нь зам тээврийн ослын улмаас амь насаа алджээ. Харин өмнөх оноос гэмт хэргийн улмаас нас барсан хүүхдийн тоо 39 (30.7%)-өөр, зам тээврийн ослын улмаас нас барсан хүүхдийн тоо 10 (18.2%)-аар буурсан байна.
- Гэмт хэргийн улмаас 2018 онд 934 хүн нас барсны 168 (18.0%) нь хүнийг санаатай алах гэмт хэргийн улмаас, 325 (34.8%) нь хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг, 335(35.9%) нь хүнийг амиа хорлох нөхцөл байдалд хүргэх, 49 (5.2%) нь хүний амь насыг болгоомжгүйгээр хохироох гэмт хэргийн улмаас амь насаа алджээ.
- Улсын хэмжээгээр 2018 онд 10000 хүнд ногдох зам тээврийн ослын улмаас нас барсан түвшин 92 байна (ТХЗ-ын 3.6.1).

- 2018 онд гэмт хэргийн улмаас хохирсон 33.6 мянган хүний 196 нь санаатай алах гэмт хэргийн хохирогч байгаа нь өмнөх оноос 5-аар буурсан байна. 2018 онд санаатай аллагын гэмт хэргийн хохирогчийн 1.5 хувь нь хүүхэд байгаа нь өмнөх оноос 2.7 пунктээр буурсан байна.
- 2018 онд хүчиндэх гэмт хэргийн хохирогч болсон 238 хүүхдийн 127 (53.4%) нь 14-17 насны охид, 91(38.2%) 8-13 насны охид, 20(8.4%) нь 7 хүртэлх бага насны охид байна.
- Сүүлийн 10 жилийн байдлаар жилд дунджаар 1382 хүүхэд гэмт хэргийн улмаас хохирсон байна. Хүүхдүүд ихэвчлэн Хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг, Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг, Өмчлөх эрхийн эсрэг, ТХХАБАЖ-ын эсрэг гэмт хэргийн улмаас хохирдог байна.
- 2018 онд хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн 579 хохирогчийн 487 (84.1%) нь хүчиндэх гэмт хэргийн хохирогч байна. Хүчиндэх гэмт хэргийн 487 хохирогчийн 469 (96.3%) нь эмэгтэйчүүд, 238 (48.9%) нь 18 хүртэлх насны хүүхдүүд байна. 18 хүртэлх насны хүүхдүүдийн 20 (8.4%) нь 7 хүртэлх насны хүүхдүүд, 91 (18.7%) нь 8-13 насны хүүхдүүд, 127 (53.4%) нь 14-17 насны хүүхдүүд байна.
- 2018 онд гэмт хэргийн улмаас учирсан 193.3 тэрбум төгрөгийн нийт хохирлын 164.6 (85.2%) тэрбум төгрөгийн хохирол нь хохирсон 57 хуулийн этгээдэд учирчээ. Гэмт хэргийн улмаас 2018 онд 57 хуулийн этгээдэд учирсан 164.6 тэрбум төгрөгийн хохирлын 26 (45.6%) хуулийн этгээдэд холбогдох нь 130.9 тэрбум төгрөг нь Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэргийн хохирол, 13 (22.8%) хуулийн этгээдэд холбогдох 20.3 тэрбум төгрөг нь Эдийн засгийн гэмт хэргийн хохирол, 4 (7.0%) хуулийн этгээдэд холбогдох 30.3 сая төгрөг нь Олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг гэмт хэргийн хохирол, 3 (5.3%) хуулийн этгээдэд холбогдох 142.6 сая төгрөг нь Авлигын гэмт хэргийн хохирол, 3 (5.3%) хуулийн этгээдэд холбогдох 11.7 тэрбум төгрөг нь Нийтийн албаны ашиг сонирхлын эсрэг гэмт хэргийн хохирол, 8 (14.0%) хуулийн этгээдэд холбогдох 1.5 тэрбум төгрөг нь Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэргийн хохирол байна. Хуулийн этгээдүүдэд гэмт хэргийн улмаас учирсан 164.6 тэрбум төгрөгийн хохирлын 18.4 тэрбум төгрөгийг нөхөн төлүүлсэн бөгөөд 1.0 тэрбум нь төрийн өмчийн, 556.8 сая төгрөг нь орон нутгийн өмчийн, 16.7 тэрбум төгрөг нь хувийн өмчийн хуулийн этгээдэд төлсөн нөхөн төлбөр байна.
- Гэмт хэргийн улмаас учирсан хохирол 2018 онд 193.3 тэрбум төгрөг, нөхөн төлүүлсэн хохирлын хэмжээ 32.4 тэрбум төгрөг болж, өмнөх оноос учирсан хохирол 4.8 (2.4 %) тэрбум төгрөгөөр, нөхөн төлүүлсэн хохирол 42.1 (56.5 %) тэрбум төгрөгөөр буурсан байна.
- Гэмт хэргийн улмаас 2018 онд 33566 хүн хохирсны 934 (1.2%) нь нас барж, 9283 (27.7%) нь гэмтсэн байна. Хохирсон хүний тоо өмнөх оноос 9.7%, нас барсан хүний тоо 17.3 %, гэмтсэн хүний тоо 11.7%-иар буурчээ.
- Яллагдагчдын тоо 2018 онд 16.4 мянгад хүрч, өмнөх оноос 1742 (9.6%)-оор буурсан хэдий ч гэмт хэрэгт холбогдсон 16.4 мянган яллагдагчдын 12.0 мянга (73.8%) нь шүүхээр ял шийтгүүлсэн нь өмнөх оноос 24 пунктээр өссөн байна. Өөрөөр хэлбэл 2017 онд нийт яллагдагчдын 49.7 % нь ял шийтгүүлж байсан бол 2018 онд нийт яллагдагчдын 73.8% нь ял шийтгүүлжээ.
- Гэмт хэрэгт холбогдсон яллагдагчдын 55.7 % нь эрхэлсэн тодорхой ажилгүй хүн байна.
- Гэмт хэрэгт холбогдсон яллагдагчдын 6885(42.0%) нь Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг үйлдэж, өмнөх оноос 3.8 пунктээр, 6936 (42.3%) нь Хүний эрүүл мэндийн халдашгүй

байдлын эсрэг гэмт хэрэг үйлдэж, 2.3 пунктээр өсөж, харин 903 (5.5%) нь ХАБТХАЖ-ын эсрэг гэмт хэрэг үйлдсэн нь өмнөх оноос 1.5 пунктээр буурчээ.

- Анхан шатны шүүхээр 2018 онд 12551 эрүүгийн хэрэг, 48155 иргэний хэрэг, 1638 захиргааны хэрэг хянан шийдвэрлэж, 12904 зөрчилд хариуцлага оногдуулсан бөгөөд анхан шатны шүүхээр шийдвэрлэсэн эрүүгийн хэрэг өмнөх оноос 3.7 (42.0%) мянга, иргэний хэрэг 2.9 (6.5%) мянга, захиргааны хэрэг 578 (45.4%), хариуцлага ногдуулсан зөрчил 4.5 (52.7%) мянгаар тус тус өссөн байна Анхан шатны шүүхээр 2018 онд 62.3 мянган хэрэг, 12.9 мянган зөрчил шийдвэрлэсэн нь өмнөх оноос шийдвэрлэсэн хэргийн тоо 1.2 (2.05) мянгаар буурч, харин хариуцлага оногдуулсан зөрчлийн тоо 4.5 (52.7%) мянгаар өссөн байна.
- 16, түүнээс дээш насны 10000 хүнд ногдох шүүхээр шийдвэрлэсэн эрүүгийн хэрэг 2018 онд Улаанбаатар хотод 68-д хүрсэн нь улсын дунджаас 9 (13.2%)–өөр их байна. Аймгуудаас 16, түүнээс дээш насны 10000 хүнд ногдох эрүүгийн хэрэг Говьсүмбэр (99), Өмнөговь (75), Дорнод (67) байгаа нь хамгийн өндөр бол Говь-Алтай, Баян-Өлгий, Завхан аймагт хамгийн бага байна.
- Шүүхээр 2018 онд шийдвэрлэсэн 12.6 мянган эрүүгийн хэргийн 55.2% нь Эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг, 24.8% нь Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг, 8.2% нь ХАБТХАЖ-ын эсрэг гэмт хэрэг, 1.8% Хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг, 1.8% нь бусад төрлийн гэмт хэрэг, 2.0% нь Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг, 1.5% нь Олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг, 1.5% нь эдийн засгийн гэмт хэрэг, 0.7% нь Нийтийн албаны ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг байна.
- 2018 онд шүүхээр ял шийтгүүлсэн хүний 41.3 %-ийг 18-29 насны залуучууд, 22.8%-ийг 30-34 насныхан, 33.5 %-ийг 35-аас дээш насныхан, 2.4 %-ийг 18 хүртэлх насны хүүхдүүд эзэлж байна. Насны бүлгээр нь авч үзвэл ял шийтгүүлсэн 35-аас дээш насныхан өмнөх оноос 0.1 пунктээр өсөж, харин 30-34 насныхан 3.7 пунктээр, 18-29 насныхан 1.4 пунктээр, 18 хүртэлх насныхан 2.4 пунктээр буурсан байна. Ял шийтгүүлсэн 1344 эмэгтэйн 87 (6.5%) нь 55-аас дээш насны эмэгтэйчүүд байна.
- Шүүхээр ял шийтгүүлсэн хүний 31 (6.3%) нь улс төрийн албан тушаалтан, 37 (7.5%) нь төрийн захиргааны албан хаагч, 127 (25.8%) нь төрийн тусгай албан хаагч, 297 (60.4%) нь төрийн үйлчилгээний албан хаагч байна. Шүүхээр ял шийтгүүлсэн 12.0 мянган хүний 6.0 мянган хүн нь ажилгүй, 21 нь ялтан байна.
- Шүүхээр ял шийтгүүлсэн 12.0 хүний 7340 (60.7%) нь Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг, 3039 (25.1%) нь Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг, 548 (4.5%) нь Хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг, 189 (1.6%) нь Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг, 192 (1.6%) нь Хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг, 158 (1.3%) нь Олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг үйлдэж ял шийтгүүлсэн байна.
- 2018 онд ХАБТХАЖ-ын эсрэг 1025 хэргийн улмаас 1292 хүн хохирсон нь нийт гэмт хэргийн хохирогчийн 9.2%-ийг эзэлж байна. Монгол Улсын Эрүүгийн хуулийн 27.10 (Авто тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих)-р зүйлийг зөрчиж, 1021 гэмт хэрэг үйлдэгдсэний улмаас 1291 хүн хохирч, үүнээс 133 (10.3%) нь 0-17 насны хүүхэд байна. 0-17 насны 133 хүүхдийн 25 нь 0-4 насны, 34 нь 5-9 насны, 38 нь 10-14 насны, 36 нь 15-17 насны хүүхэд байна.
- 2018 оны байдлаар шүүхээр шийдвэрлэсэн 12551 эрүүгийн хэрэгт холбогдох 40.2 тэрбум төгрөгийн хохирлын 22.3 тэрбум төгрөгийн хохирлыг нөхөн төлүүлжээ.

- Эрүүгийн гэмт хэргийн улмаас 2018 онд 14.0 мянган хүн, 227 хуулийн этгээд хохирсон байна. Нийт хохирсон хүний 4772 (34.0) нь эмэгтэйчүүд байна. Эрүүгийн гэмт хэргийн хохирогчийн 764 (5.4%) нь 0-17 насны хүүхдүүд, 1925 (13.7%) нь 18-24 насныхан, 2623 (18.7%) нь 25-29 насныхан, 2637 (18.8%) нь 30-34 насныхан, 2152 (15.3%) нь 35-39 насныхан, 1499 (10.7%) нь 40-44 насныхан, 1002 (7.1%) нь 45-49 насныхан, 719 (5.1%) нь 50-54 насныхан, 380 (2.7%) нь 55-59 насныхан, 172 (1.2%) нь 60-64 насныхан, 85 (0.6%) нь 65-69 насныхан, 95 (0.7%) нь 70-аас дээш насныхан байна.
- Анхан шатны шүүх 2018 онд 64.5 мянган нэхэмжлэл, гомдол, хүсэлт хүлээн авснаас 10.4 мянган (16.1%) нэхэмжлэлийг хуульд заасан үндэслэлээр хүлээн авахаас татгалзаж, буцаах, харьяаллын дагуу зохих байгууллагад шилжүүлэх зэрэг арга хэмжээ авч, 48.2 мянган иргэний хэргийг хянан шийдвэрлэжээ. Анхан шатны шүүхээр шийдвэрлүүлэхээр ирүүлсэн 64.5 мянган нэхэмжлэл, гомдол, хүсэлтийн 48.5 (74.6 %) мянгыг шийдвэрлэсэн нь өмнөх оноос 3.1 пунктээр өссөн байна. Анхан шатны шүүхээр шийдвэрлэсэн иргэний хэрэг өмнөх оноос 2.9 (6.5%) мянгаар өсөхөд худалдах, худалдан авах болон арилжаатай холбоотой маргаан 511 (8.5%), зээлийн гэрээний маргаан 991 (17.8%), банк, зээлийн үйл ажиллагаатай холбоотой маргаан 525 (35.1%) –аар өссөн нь голлон нөлөөлжээ.
- Монгол Улсын “Гэр бүлийн тухай” хуулиар 2018 онд 4763 хэрэг шийдвэрлэсний 2945 (61.8%) нь гэрлэлт цуцалсан, 392 (8.2%) нь эцэг тогтоосон, 1146 (24.1%) нь хүүхдийн тэтгэлэг гаргуулах, 11 (0.2%) нь эцэг, эх байх эрх хассан, 64 (1.3%) нь гэрлэлт болон гэрлэлт цуцлалтыг хүчин төгөлдөр бус гэж тооцсон, 205 (4.3%) нь бусад хэрэг байна. “Гэр бүлийн тухай” хуулийн дагуу анхан шатны шүүхээр шийдвэрлэсэн хэрэг өмнөх оноос 197 (4.3%)-оор өсөхөд гэр бүл цуцлалт 154 (5.5%)-өөр өссөн нь голлон нөлөөлжээ.

САНАЛ, ЗӨВЛӨМЖ

- Хууль, тогтоомж, хөгжлийн бодлого, хөтөлбөрийг боловсруулахдаа статистик мэдээлэлд үндэслэн судалгаа, дүн шинжилгээ хийж, үнэлэлт дүгнэлт өгөх шаардлагатай байна.
- НҮБ-ын Гэмт хэрэг, мансууруулах бодистой тэмцэх газар болон НҮБ-ын Статистикийн комиссоос батлан гаргасан гэмт хэргийн статистикт зориулсан олон улсын ангиллыг үйл ажиллагаандаа нэвтрүүлж, Монгол Улсын гэмт хэргийн статистикийн үзүүлэлтүүдийн олон улсад харьцуулагдах байдлыг хангах явдал чухал байна.
- НҮБ-ын Гэмт хэрэг, мансууруулах бодистой тэмцэх газрын гэмт хэргийн чиг хандлагын судалгааны үзүүлэлтүүд болон Тогтвортой хөгжлийн зорилтын холбогдох үзүүлэлтүүдийг гаргах боломжийг бүрдүүлж ажиллах явдал тулгамдсан асуудлуудын нэг болоод байна. Тогтвортой хөгжлийн зорилтын гэмт хэргийн статистикийн гарахгүй байгаа үзүүлэлтүүдийг гаргахын тулд Хууль зүй дотоод хэргийн яам болон хууль сахиулах, шүүх эрх мэдлийн байгууллагуудын оролцоотойгоор хохирогчийн судалгааг зохион байгуулж явуулах шаардлагатай байна.
- Жил бүр улсын хэмжээнд бүртгэгдсэн гэмт хэргийн 65-70 орчим хувь нь Улаанбаатар хотод бүртгэгддэг байна. **2018 оны байдлаар Улаанбаатар хотод 16, түүнээс дээш насны 10000 хүнд ногдох бүртгэгдсэн гэмт хэрэг 263 болж, улсын дунджаас 94 (55.6%)-өөр их байна.** Энэ нь хүн ам хэт их төвлөрсөн нийслэл хотод гэмт хэргийн гаралтыг бууруулах ажлыг эрчимжүүлэх шаардлагатай байгааг харуулж байна. Гэмт хэргийн төрөл тус бүрээр авч үзэхэд ч нийт бүртгэгдсэн хэргийн 60 орчим хувь Улаанбаатар хотод бүртгэгдсээр байна.

- 2018 оны байдлаар хүчиндэх гэмт хэргийн 487 хохирогчийн 469 (96.3%) нь эмэгтэйчүүд, 238 (48.9%) нь 18 хүртэлх насны хүүхдүүд байна. 2018 онд хүчиндэх гэмт хэргийн хохирогч болсон 238 хүүхдийн 127 (53.4%) нь 14-17 насны охид, 91(38.2%) 8-13 насны охид, 20(8.4%) нь 7 хүртэлх бага насны охид байна. 2009-2018 оны хүчиндэх гэмт хэргийн хохирогчийн 10 жилийн мэдээллээс харахад жил тутам дунджаар 7-17 насны 159 охид хүчиндэх гэмт хэргийн хохирогч болсон маш эмгэнэлтэй мэдээлэл харагдаж байна. Иймд эцэг эх, багш нар бүх шатны хүүхэд хамгааллын байгууллагууд бага насны охидод тавих анхаарал халамжаа эрс нэмэгдүүлэх, бүхий л шатанд охидын хүчирхийллийн хэлбэрийг устгах ажлыг эрчимжүүлэх нь зүйтэй гэж үзэж байна.
- НҮБ-ын Гэмт хэрэг, мансууруулах бодистой тэмцэх газраас гэмт хэргийн чиг хандлагын судалгааны мэдээлэлд үндэслэн тооцсон тооцоогоор Монгол Улс 2016 оны байдлаар 100000 хүнд ногдох хулгайлах гэмт хэргээр Ази тивд Солонгос улсын дараа 2 дугаарт орсон байна. Эндээс үзэхэд хүн ам цөөн МУ-ын хувьд Өмчлөх эрхийн эсрэг, түүний дотор хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр хийх ажлаа улам эрчимжүүлэх хэрэгтэй байна.
- 2018 оны байдлаар гэмт хэрэгт холбогдогчдын 55.9% нь ажилгүй хүн, шүүхээр ял шийтгүүлэгчдийн 49.9 хувь нь ажилгүй хүн байгаа нь ажлын байргүйн улмаас залуучууд гэмт хэрэгт холбогдох, улмаар ял шийтгэл авах явдал их байгааг харуулж байна. Иймээс ажлын байрыг шинээр бий болгох, ажилгүй иргэдийг ажлын байраар хангах ажлыг холбогдох байгууллагууд эрчимжүүлэх нь зүйтэй байна.
- Гэмт хэргийн улмаас 2018 онд 934 хүн нас барсны 325 (34.8%) нь зам тээврийн ослын улмаас нас барсан байна. Зам тээврийн ослын улмаас нас барсан 325 хүний 91 (28.0%) нь Улаанбаатар хотынх байна. Улсын хэмжээгээр 2018 онд 10000 хүнд ногдох зам тээврийн ослын улмаас нас барсан түвшин 92 байна (*ТХЗ-ын 3.6.1*). Хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэргийн тоо 2018 онд өмнөх оноос буурсан хэдий ч зам тээврийн ослын улмаас нас барсан түвшин Улаанбаатар хотод 140 байгаа нь улсын дунджаас 48-аар их байна. Иймд замын хөдөлгөөнд оролцож буй нийт жолооч, явган зорчигчдын үүрэг хариуцлагыг эрс дээшлүүлэх хэрэгцээ, шаардлага байсаар байна. Зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх ажлын хүрээнд жолоочийн ур чадвар, үүрэг, хариуцлагыг дээшлүүлэх, нийт иргэдэд замын хөдөлгөөнд зүй зохистой оролцох соёл, дадал эзэмшүүлэх, замын чанар, гэрэлтүүлэг, жолооны сургалтын чанарыг сайжруулах, орон нутаг, гэр хорооллын замыг стандартад нийцүүлэх ажлуудыг хийх шаардлагатай байна. Бага насны хүүхэд зам тээврийн ослын улмаас нас барах явдал байсаар байгаа нь эцэг эхчүүдийн үр хүүхдэдээ тавих анхаарал, халамж сул нөгөөтэйгүүр жолооч нарын сахилга, хариуцлагатай холбоотой юм. Бага насны хүүхдийг зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэхэд сургуулийн багш, нийгмийн ажилтан, эцэг эхчүүд, жолооч нарын үүрэг хариуцлагыг дээшлүүлэх зайлшгүй шаардлагатай байна.
- 2018 онд гэмт хэргийн улмаас учирсан 193.3 тэрбум төгрөгийн нийт хохирлын 164.6 (85.2%) тэрбум төгрөгийн хохирол нь хохирсон 57 хуулийн этгээдэд учирчээ. Хуулийн этгээдүүдэд учирсан 164.6 тэрбум төгрөгийн хохирлын 18.4 (11.2%) тэрбум төгрөгийг нөхөн төлүүлсэн нь учирсан хохирлыг нөхөн төлүүлэх ажлыг эрчимжүүлэх, хуулийн этгээдүүдийн хохирлын дийлэнх хувийг эзэлж буй Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг, Эдийн засгийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг эрчимжүүлэх шаардлагатай байна.

- 2018 онд гэмт хэргээс хохирсон 33.6 мянган хүний 14.7 мянга (43.7%) нь эмэгтэйчүүд, 1688 (5.0%) нь хүүхэд, 5545 (16.5%) нь 25-29 насны хохирогч, 5650(16.8%) нь 30-34 насны хохирогч, 4482 (13.4%) нь 35-39 насны хохирогч, 3815 (11.4%) нь 40-44 насны хохирогч байна. Гэмт хэргийн улмаас хохирсон хүнийг хамгаалах, учирсан хохирлыг барагдуулах, гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хүнд үйлчлэх байр, нийгмийн бусад тусламж үйлчилгээг сайжруулж, шинэ шатанд гаргах хэрэгцээ, шаардлага байсаар байна.
- Одоогоор Монгол Улсад гэмт хэргийн хохирогчийн зөвхөн эд материалын хохирлын тодорхой хэсгийг нөхөн төлүүлж байгаа бөгөөд цаашид бусад хохирлыг нөхөн төлүүлэх үйл ажиллагааг үе шаттайгаар хэрэгжүүлэх тодорхой хөтөлбөр, төсөл боловсруулан ажиллах хэрэгтэй байна.

..... о О о